



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



# ДОТУУР БАЙРНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХҮЧИН ЧАДЛЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

УЛААНБААТАР ХОТ

2024



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



# ДОТУУР БАЙРНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХҮЧИН ЧАДЛЫГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

## **Агуулга**

Агуулга .....	2
Хүснэгтийн жагсаалт .....	3
ОРШИЛ .....	6
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ДОТУУР БАЙРНЫ МАТЕРИАЛЛАГ ОРЧИН, ХҮЧИН ЧАДАЛ.....	9
1.1. Дотуур байрны гадна орчин .....	14
1.2. Дотуур байрны дотоод орчин.....	16
Дүгнэлт.....	26
Санал, зөвлөмж .....	27
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ДОТУУР БАЙРАН ДАХЬ ХҮҮХЭД ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ.....	28
2.1. Дотуур байранд зохион байгуулагддаг хүүхэд хөгжлийн үйл ажиллагаа, хүүхдийн оролцоо .....	28
2.2. Дотуур байран дахь хүүхэд хамгааллын нөхцөл байдал .....	37
2.3 Дотуур байрны ажилтнуудын ажлын байран дахь хүүхэд хамгааллын асуудал.....	51
2.4 Эцэг эх, асран хамгаалагчдын дэмжлэг үйл ажиллагаа.....	57
Дүгнэлт.....	60
ГУРАВДУГААР БҮЛЭГ: ДОТУУР БАЙРНЫ БАГШ, АЖИЛТНЫ АЖЛЫН НӨХЦӨЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ.....	63
3.1 Дотуур байрны багшийн мэргэжил дээшлүүлсэн байдал .....	63
3.2 Дотуур байрны багшийн үйл ажиллагаа, албан тушаалын тодорхойлолт .....	65
3.3 Дотуур байрны ажилтны эрхэлдэг ажил, бэрхшээл.....	69
Дүгнэлт.....	76
Санал, зөвлөмж .....	78
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ДОТУУР БАЙРНЫ МЕНЕЖМЕНТ, ТҮНШЛЭЛ ХАМТЫН АЖИЛЛАГАА ...	79
4.1 Ерөнхий мэдээлэл .....	79
4.2. Дотуур байрны хөгжилд сургуулийн удирдлагын үүрэг, хариуцлага .....	80
4.3. Дотуур байрны хөгжилд орон нутгийн дэмжлэг, оролцоо.....	82
Дүгнэлт.....	86
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ .....	86
ХАВСРАЛТ -1 .....	96
ХАВСРАЛТ -2 .....	100

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Гэрээний загвар .....	10
Хүснэгт 2. Дотуур байрны гадна орчинд тавигдах шаардлага хангагдсан байдал .....	15
Хүснэгт 3. Дотуур байрны барилга байгууламжид тавигдах шаардлага хангасан байдал.....	16
Хүснэгт 4. Дотуур байрны хүүхэд амьдрах өрөөнд тавигдах шаардлага хангасан байдал .....	17
Хүснэгт 5. Дотуур байрны ариун цэврийн өрөөнд тавигдах шаардлага хангасан байдал .....	19
Хүснэгт 6. Дотуур байрны бие засах өрөөнд тавигдах шаардлага хангасан байдал тоогоор.....	20
Хүснэгт 7. Дотуур байрны хүүхэд хөгжлийн өрөө, номын сан, багшийн өрөөнд тавигдах шаардлага хангасан байдал .....	21
Хүснэгт 8. Эрүүл мэндийн өрөөнд тавигдах шаардлага хангасан байдал.....	23
Хүснэгт 9. Дотуур байрны гал тогоонд тавигдах шаардлага хангасан байдал.....	24
Хүснэгт 10. Дотуур байрны камержуулалт .....	24
Хүснэгт 11. Дотуур байрны ашиглалтын хугацаа .....	25
Хүснэгт 12. "Хүүхэд хөгжлийн өрөө"-өөр үйлчлүүлэх давтамж.....	29
Хүснэгт 13. Гэрийн даалгавраа хийдэг газар (Хувиар, Тоогоор) .....	31
Хүснэгт 14. Дотуур байрандаа чимээ шуугиангүй нөхцөлд хичээлээ хийдэг байдал (Хувиар, Тоогоор) .....	31
Хүснэгт 15. Дотуур байранд зохиогддог сургалт зөвлөгөөний чиглэл (Хувиар) .....	31
Хүснэгт 16. Дотуур байранд зохиогддог үйл ажиллагаанд хүүхдийн оролцоо (Хувиар) .....	35
Хүснэгт 17. Хүүхдүүд дотуур байранд усанд ордог байдал (Хувиар, Тоогоор) .....	39
Хүснэгт 18. Ариун цэврийн өрөө хүйсээр тусдаа эсэх, хүүхдийн хариулт (Хувиар, Тоогоор) .....	40
Хүснэгт 19. Дотуур байрны хүүхдээс үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа авдаг эсэх (Хувиар, Тоогоор).....	45
Хүснэгт 20. Дотуур байранд багш, ажилтнуудын зүгээс дарамт байдаг эсэхэд хүүхдийн хариулт (Хувиар, Тоогоор).....	46
Хүснэгт 21. Судалгаанд хамрагдсан багш нар (улсад ажилласан жилээр).....	63
Хүснэгт 22. Сургуулийн удирдлагаас багшийг дэмждэг эсэх.....	64
Хүснэгт 23. Дотуур байрны төсвийн санхүүжилтийн зарцуулалт .....	80
Хүснэгт 24. Дотуур байрны менежментийг сайжруулснаар гарах өөрчлөлт .....	81
Хүснэгт 25. Сургуулийн зүгээс шаардлагатай дэмжлэг .....	84
Хүснэгт 26. Аймаг, орон нутгийн байгууллагуудын дэмжлэг (%) .....	85
Хүснэгт 27. Дотуур байрны барилга, тоног төхөөрөмжийн дэмжлэг .....	85

## Зургийн жагсаалт

Зураг 1. Судалгаанд хамрагдсан дотуур байр (хувиар).....	9
Зураг 2. Хүүхэд хөгжлийн өрөөний номын санд байгаа номны эзлэх хувь.....	22
Зураг 3.Дотуур байранд амьдарсан жил (хувиар) .....	29
Зураг 4. Суралцдаг анги (хувиар).....	29
Зураг 5. "Хүүхэд хөгжлийн өрөө" - суралцагчдын хийдэг үйл (Хувиар).....	30
Зураг 6. Номын санд хийх үйл ажиллагаа (Хувиар).....	30
Зураг 8. Дотуур байранд "хүүхэд хамгаалал" чиглэлээр явагддаг сургалт, зөвлөгөө (Хувиар, Тоогоор) .....	32
Зураг 9. Хүүхдийн хоолны сэтгэл ханамж (Хувиар, Тоогоор).....	38
Зураг 10. Хоолны чанарын талаар хүүхдүүдээс санал асуулга авдаг байдал (Хувиар, Тоогоор) .	38
Зураг 11. Дотуур байрны ариун цэврийн өрөөний үйлчилгээний цэвэрлэгээ (Хувиар, Тоогоор) ..	41
Зураг 12. Дотуур байрны хөнжил гудасны чанар, хүүхдийн хариулт (Хувиар, Тоогоор) .....	42
Зураг 13. Дотуур байрны гудас, хөнжлийн чанар хүүхдийн хариулт (Хувиар, Тоогоор) .....	42
Зураг 14. Эрүүл мэндийн үзлэгт хамрагдалт, суралцагчдын хариулт (Хувиар, Тоогоор) .....	42
Зураг 15. Дотуур байран дахь үе тэнгийнхний дээрэлхэлтийн талаарх хүүхдийн хариулт (Хувиар, Тоогоор) .....	45
Зураг 16. Дотуур байран дахь хүүхдийн сэтгэл санааны баяр баясгалантай байдал (Хувиар, Тоогоор) .....	50
Зураг 17.Дотуур байран дахь хүүхдүүдийн сэтгэл санааны уйтгар гунигтай байдал (Хувиар, Тоогоор) .....	50
Зураг 18. Судалгаанд хамрагдсан багш нар (насаар).....	63
Зураг 19.Судалгаанд хамрагдсан багш нар (хүйсээр).....	63
Зураг 20. Багш нарын мэргэжил дээшлүүлсэн байдал .....	64
Зураг 21.Сургуулийн удирдлагаас багшийг дэмждэг эсэх .....	64
Зураг 22. Дотуур байрны багшийн оролцоо .....	65
Зураг 23.Судалгаанд хамрагдсан багш нар (боловсролын түвшнээр) .....	65
Зураг 24. Хүүхдийг дотуур байранд анх орж ирэхэд байрны дүрэм, үйлчилгээний талаар танилцуулдаг эсэх .....	66
Зураг 25. Дотуур байрны хүүхэд эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг байдал .....	66
Зураг 26. Дотуур байрны хүүхдийн эрүүл хоол хүнс хэрэглэхтэй холбоотой эцэг эх, асран хамгаалагчдаас дэмжлэг авдаг эсэх.....	66
Зураг 27. Хүүхэд хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад оролцогчид .....	67
Зураг 28. Сургуулийн жилийн төлвөлөгөөнд дотуур байрны багш, ажилтнуудын оролцоо, хувиар	67
Зураг 29. Дотуур байрны багш хүүхдийн гэрийн даалгаварт тусалдаг эсэх.....	67
Зураг 30. Дотуур байранд хүүхдүүд үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, нэр хоч өгөх явдалд өртөх эрсдэл байдаг эсэх .....	68
Зураг 31. Тандалт судалгаа авдаг эсэх .....	68
Зураг 32. Дотуур байранд ирдэг санал гомдол .....	68
Зураг 33. Дотуур байрны багшаар ажиллахад тулгардаг бэрхшээл .....	68

Зураг 34. Багшийн гүйцэтгэлийг үнэлдэг эсэх .....	69
Зураг 35. Цаашид дотуур байрны багшаар ажиллах хүсэлтэй эсэх .....	69
Зураг 36. Сургуулийн менежментийг сайжруулснаар гарах өөрчлөлт .....	69
Зураг 37. Сургуулийн удирдлага ба дотуур байрны багш, ажилтнуудын хамтын ажиллагаа .....	74
Зураг 38. Асуулга судалгаанд хамрагдагсдын нас (мэргэжилтэн, сургуулийн удирдлага) .....	79
Зураг 39. Сургуулийн захирал (сургалтын менежер)-аар ажиллаж буй жил .....	79
Зураг 40. Мэргэжилтнээр ажиллаж буй жил .....	79
Зураг 41. Боловсролын зэрэг, хувиар .....	80
Зураг 42. Өөрийн үнэлгээний үр дүнг ашигладаг байдал .....	81
Зураг 43. Дотуур байрны нөхцөл байдалтай танилцсан эсэх .....	83

## ОРШИЛ

1921 оны 8-р сарын 25-нд дунд сургуулийн танхимын дүрэм, хэмжээг тогтоосон тогтоол гарч батлагдсанаас хойш 1921-1940 оны хооронд ЕБС-ийн тогтолцоо үүсэх явцад малчдын хүүхдийн сурах нөхцөл бий болгож дотуур байрны асуудлыг шийдэх болсон байна.

Сурагчид хичээлийн жилд 9 сар буюу жилийн 224-245 хоногт эцэг эх, асран хамгаалагчдаасаа хол дотуур байрны багш, тогооч, ажилтны асрамжид сурч хөгждөг байна. Үүнтэй холбоотой ерөнхий боловсролын тухай хуульд:

*Хүүхдүүд нь:*

- ... эрүүл мэнд болон хоол, хүнсний аюулгүй байдлыг хангасан, суралцагч өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжтой дотуур байраар хангагдах...

*Сургууль нь:*

- ...ерөнхий боловсролын сургууль дотуур байртай байж болно. Дотуур байрны орчин, үйлчилгээний стандарт, техникийн зохицуулалтыг стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу баталж, мөрдөх...

- ... хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;

- ... дотуур байрны орчинд аливаа дарамт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтээс сэргийлэх, хүүхэд хамгааллын хөтөлбөрийг тусгайлан боловсруулж, хэрэгжүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, тайланг хэлэлцэх; ...

*Нутгийн өөрөө удирдах байгууллага нь:*

- ... болон захиргааны байгууллага дотуур байранд амьдарч байгаа суралцагчийн эрүүл мэнд болон хоол хүнсний аюулгүй байдлыг хангаж хэвийн амьдрах, сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлнэ гэж тусгагдсан байна.

Эдгээр баримт бичгийг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны орчин нөхцөл байдалд шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлууд болон нөхцөл байдлыг сайжруулах хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Судалгааны зорилго:

ЕБС-ийн дотуур байрны орчин, үйлчилгээний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, менежментийг сайжруулах санал, зөвлөмж боловсруулна.

Зорилт:

- Дотуур байрны үйлчилгээ үзүүлэх хүчин чадалд шинжилгээ хийх
- Дотуур байранд амьдардаг суралцагчийн эцэг эхийн хандлага, үүрэг, хариуцлага хамтын ажиллагаа;
- Дотуур байранд амьдардаг суралцагчийн суралцах болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцох оролцоо;
- Дотуур байрны багшийн албан тушаалын тодорхойлолтод шинжилгээ хийх;
- Дотуур байрны менежмент, түншлэл-хамтын ажиллагаа, хэрэгцээнд шинжилгээ хийх;
- Судалгааны үр дүнд тулгуурлан дотуур байрны менежментийг сайжруулахад санал зөвлөмж боловсруулах

Судлах зүйл, судлагдахуун

**Судлагдахуун нь:** Дотуур байрны орчин, үйлчилгээ

**Судлах зүйл нь:** Дотуур байрны хүчин чадал, хэрэгцээ, хүүхэд хөгжил хамгааллын үйлчилгээ, менежмент-түншлэл хамтын ажиллагаа

Судалгааны арга, аргачлал

Судалгааны ажлыг холимог судалгааны арга зүй (mixed methods research) буюу тоон (quantitative) ба чанарын (qualitative) судалгааны аргыг хослуулан явуулсан.



Энэхүү арга зүйн хүрээнд мэдээлэл цуглуулахад ажиглалт, баримт бичиг, асуулга, ярилцлага, үндсэн аргуудыг хэрэглэсэн.

#### *Судалгааны хамрах хүрээ*

Судалгаанд 21 аймаг, нийслэлээс сонгогдсон сум болон төвийн 137 дотуур байрны 7374 суралцагч, 399 багш, 264 захирал удирдах ажилтан, 158 байрны ажилтан, 1200 эцэг эх, асран хамгаалагч, 136 орон нутгийн төрийн захиргааны байгууллагын мэргэжилтэнг хамруулсан.

#### *Хүлээгдэж буй үр дүн*

Судалгааны үр дүнг дараах байдлаар харж байна. Үүнд:

- Дотуур байрны орчин үйлчилгээнд тавигдах шаардлага стандартад нэмэлт өөрчлөлт оруулах санал тодорхой болно.
- Дотуур байрны багшид тавигдах шаардлага, чиг үүргийг тодорхойлох саналтай болсон байна.
- Сургуулийн дотуур байрны менежментийг сайжруулах зөвлөмжийг боловсруулсан байна.


## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ДОТУУР БАЙРНЫ МАТЕРИАЛЛАГ ОРЧИН, ХҮЧИН ЧАДАЛ

### Ерөнхий мэдээлэл

ЕБС-ийн гадна болон дотоод орчны хүчин чадлын судалгаанд 21 аймгийн ЕБС-ийн 137 дотуур байр хамрагдсанаас 84 сургуулийн дотуур байранд судалгааны баг ажиллаж, 53 сургуулийн дотуур байрнаас “ Google form”-оор тус тус мэдээлэл цуглуулж боловсруулалт хийж, үр дүнг гаргаж авлаа.

Улсын хэмжээнд нийт бага, дунд боловсролын 415 сургуулийн 528<sup>1</sup> нь дотуур байранд 42990 хүүхэд амьдарч, тэдний төлөө 3466 ажилтнууд, үүнээс 587 үндсэн багш ажилладаг байна.

Зураг 1. Судалгаанд хамрагдсан дотуур байр (хувиар)



Нийт дотуур байртай сургуулийн 31.6 хувийг судалгаанд хамруулсан ба түүний 38.7 хувийг нь цахимаар буюу “google form”-оор, 61.3 хувьд нь судлаачид судалгааны мэдээллийг тодорхой аргачлалын дагуу цуглуулсан байна.

### Дотуур байр- эцэг эх, асран хамгаалагч – суралцагч гурвалсан гэрээ

Дотуур байрны стандартын 4.3-д дотуур байрны үйлчилгээ (MNS6781:2019) гэсэн нэр томъёоны тодорхойлолтод “Суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагчтай гэрээлсний үндсэн дээр суралцагчдыг байрлуулан тэдний амьдралын хэвийн, аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх, асран хамгаалуулах, эрүүл мэнд, хөгжил хамгаалал, хоол хүнсний үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээ “ гэж тодорхойлжээ.

Суралцагч нь боловсрол эзэмшихийн тулд оршин суудаг газраасаа сургуульд тогтмол явуулах боломжгүй бол эцэг эх, асран хамгаалагчдын хүсэлтээр сургуулийнхаа дотуур байранд амьдрах хүсэлт гаргаж хүсэлтийг сургуулийн захирал болон дотуур байрны багш шийдвэрлэдэг байна. Шийдвэрлээд эцэг эх, асран хамгаалагчтай БШУ-ны сайдын 2019 оны А/508 дугаар “Гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай” тушаалын хавсралтыг баримтлан гэрээ хийж баталгаажуулдаг байна.

Суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээний үлгэрчилсэн загвар нь ерөнхий зүйл, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх, үүрэг, ерөнхий боловсролын сургуулийн эрх, үүрэг, бусад гэсэн дөрвөн зүйлээс бүрдсэн байна.

#### Гэрээ байгуулсан эсэх

Бид судалгаанд хамрагдсан дотуур байрны хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагч-суралцагч хамтран гурвалсан гэрээнд баримт бичгийн анализ хийж үзлээ.

<sup>1</sup> ЕБС-ийн дотуур байрны хүчин чадлын 2023-2024 оны хичээлийн жилийн тайлан БШУЯ

Гэрээ нь : Монгол улсын Иргэний хуулийн хүрээнд гэрээг 2 ба түүнээс дээш этгээдийн хооронд эрх зүйн харилцаа үүсгэх болон өөрчлөх, дуусгахад чиглэгдсэн үйлдэл эс үйлдлийг хэлнэ.

Дотуур байрны багш, эцэг эх, асран хамгаалагч суралцагчдтай байгуулах гэрээ нь албан ёсны бичиг баримт болж байна. Гэрээнд 3 талын эрх үүрэг, гарч болох эрсдлээс хамгаалахын тулд баримтлах хууль тогтоомжийг тусгаж өгсөн байна. Үүнд:

- Монгол Улсын Боловсролын тухай хууль
- Бага дунд боловсролын тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Хүүхдийн эрхийн конвенц
- БСШУ, спортын сайдын 2018 оны А/476 дугаар тушаалаар баталсан “ЕБС-ийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлого” болон бусад хууль тогтоомжийг тусгасан байна.

Хүснэгт 1. Гэрээний загвар

д/д	Гэрээний нэршил	Хувь	Хууль тогтоомж тусгасан	3 талын эрх, үүрэг тусгасан	Хугацаа заасан
1	Дотуур байрны багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагчтай байгуулах” “Хариуцлагын гэрээ”	14.7	8-10 тусгасан	Тус бүрийг 8-10 зүйл	гэрээнд хугацаа заасан
2	... аймаг... сумын ... сургуулийн .... оны дотуур байрны багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагчтай байгуулсан хамтын гэрээ	44.1	6-7 тусгасан	Тус бүрийг 15-8 зүйл	заагаагүй
3	Дотуур байранд амьдардаг хүүхдийн эцэг эхтэй хийсэн гэрээ	8.8	тусгаагүй	Эрх тусгаагүй үүрэг 5-11 заалтаар	заагаагүй
4	...аймгийн... сургуулийн дотуур байрны хүүхэд, эцэг эх асран хамгаалагч болон сургуулийн захиргаатай байгуулах гурвалсан гэрээ	17.4	тусгаагүй	Тус бүрийг 10-14 зүйл	заасан
5	... сургуулийн зүгээс дотуур байрны эцэг эх, асран хамгаалагчтай хийх гэрээ	8.8	тусгаагүй	Эрх тусгаагүй үүрэг 5-11 заалтаар	заагаагүй
6	Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах гэрээ	2.9	тусгаагүй	Тус бүрийг 3-8 зүйл	заагаагүй

Гэрээний зорилгыг өөр өөрөөр тодорхойлсон байна.

Дотуур байрны орчинд хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүүхэд тавих анхаарал халамж, хараа хяналтыг сайжруулж, хүүхдийн эрхийг хангах чиглэлээр талууд хамтран ажиллахад чиглэнэ.

*Гэрээний зорилго:-д*

- багш,ажилтан, сурагч, эцэг эхийн үүрэг харицулагыг дээшлүүлэх, сурагчдыг бие хүн болж зөв төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, дүрэм журам дагаж мөрдүүлэх...
- ... эрүүл орчинд амьдруулах, мэндэлж хүндэлж сургахад ...
- ... суралцагчийн амьдрах, сурах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, зөв дадал хандлага төлөвшүүлэх, аливаа эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ...
- ... амьдрах, хамгаалагдах, хөгжих, оролцох эрхүүдийг хангасан материаллаг болон сэтгэл зүйн таатай орчин нөхцлийг бүрдүүлэх,..
- ... сурагчийн бодит хамтын үйл ажиллагааг бэхжүүлэхэд гэрээний зорилго оршино...гэх мэтээр олон хэлбэрээр илэрхийлсэн байна.

Байрны сурагчдыг аливаа төрлийн гэмт хэрэг аюул ослоос урьдчилан сэргийлэхэд эцэг эх, асран хамгаалагч, багшийн хараа хяналтыг сайжруулах зөв боловсон амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд гэрээний зорилго оршино.

.... аймгийн .... дотуур байрны гэрээ

Үүнээс үзэхэд суралцагчдыг аливаа төрлийн гэмт хэрэг, аюул ослоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эцэг эх, асран хамгаалагч, багшийн хараа хяналтыг сайжруулах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд гэрээний зорилго чиглэсэн байна.

*Гэрээний бүтэц нь:*

- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх үүрэг,
- ЕБС-ийн эрх үүрэг
- Бусад гэсэн бүтэцтэй байна.

*Мөн зарим гэрээ нь:*

- Ерөнхий зүйл
- Дотуур байрны багш ажилтнуудын хүлээх эрх, үүрэг
- Сурагчдын эрх, үүрэг
- Эцэг эхийн эрх, үүрэг
- Бусад (хариуцлага тооцох) гэх мэтээр олон янзын бүтэцтэй хийгдсэн байна.

*Гэрээнд дотуур байрны багшийн эрх -д:*

- Багш суралцагчийн талаар шаардлагатай мэдээллийг эцэг эхээс авч судалгаа хийх, суралцагчдад болон эцэг эх, асран хамгаалагчид зөвлөгөө өгөх
- Суралцагчдыг өдрийн дэглэмийг мөрдүүлж, давтлага, даалгавар, нэмэлт хичээл хийлгэх
- Багш боловсролын тухай хуулийн 43.1дэх хэсэгт заасан нийгмийн баталгаагаар хангагдана
- .... хуулийн 44.1-д заасан эрхээс гадна хүүхдийн сургалтын ажил, эрүүл мэнд, аюулгүй байдал, эрх ашигт сөрөг нөлөө үзүүлэх аливаа үйл ажиллагааг таслан зогсоох, хориглоход бичлэн оролцох эрх эдэлнэ гэж заасан байна.

Гэрээнд багшийн нэр хүнд, эрүүл мэнд, мэдээлэл авах, хамгаалуулах талаар заагаагүй байна.

*Дотуур байрны багшийн үүрэг-т:*

- Багшийн ёс зүйн хэм хэмжээг сахиж биелүүлэх
- Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргах тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх.
- Байрны суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон уралдаан тэмцээн, соёл хүмүүжлийн ажлыг санаачлан төлөвлөж захирлаар батлуулан хэрэгжүүлж ажиллах.
- Сурагч бүр ухаалаг утсыг оройн 21<sup>00</sup> цагаас өглөөний 07<sup>00</sup> цаг хүртэл багшид хураалгах.
- Сурагчдыг дотуур байранд тав тухтай суух нөхцөлөөр хангах.
- Улсаас тогтоосон төсөвт багтаан эрүүл илчлэгтэй, ариун цэврийн шаардлага хангасан хоол хүнсээр хангах.
- Дотуур байрны сурагчдын соёл хүмүүжлийн ажлыг байрны багш жил, улирлын төлөвлөгөөний дагуу зохион байгуулах.
- Хүүхдийг чөлөөт цагаараа хөгжих боломжийг бүрдүүлэх.
- Хүүхдийн ялгаатай байдлыг ойлгож, дэмжин туслах замаар суралцахуйг нь дэмжих
- Коронавируст (COVID-19) халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдүүлэх.

*Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх-д:*

- Эцэг эх, асран хамгаалагчийн хувийн мэдээллийн нууцыг чандлан хадгалах гэх мэт эрх, үүргүүдийг тусгасан байна.
- Хүүхдийнхээ сурлага, төлөвшлийн талаар анги удирдсан багш, дотуур байрны багшаас мэдээлэл авах, амьдарч сурч буй орчин нөхцөлтэй танилцах
- Сургууль, багш, дотуур байрны багш, ажилтнуудын зан харилцаа, үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт гаргах..... гэх мэт

*Эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг-т:*

- Хоцрогдсон хичээлээр давтлага авах, урлаг, спортын секц дугуйланд хамрагдах
- Ая тухтай эрүүл, аюулгүй орчоор хангуулах амьдрах
- Тасагтаа цэвэр цэмцгэр суух
- Байрны багш, ажилтнуудаас өгсөн үүрэг даалгаварыг хугацаанд нь чанартай биелүүлж тэдний ажилд бүх талын дэмжлэг үзүүлэн, илэрсэн зөрчил дутагдлын талаар тухай бүрд нь мэдэгдэж байх
- Бусдад ямар нэг хэмжээгээр дарамт шахалт үзүүлэхгүй байх
- Дотуур байрны өрөө тасагт утаат болон электрон тамхи татах, дэлбэрэх тэсрэх бодис, галд амархан шатах бодис, үнэт эдлэл, их хэмжээний мөнгө хадгалах ... гэх мэтээр тусгасан байна.

*Сурагчийн эрх, үүрэг:*

- Хүүхдийнхээ нас хөгжлийн онцлог, зан төлөвийг танин мэдэж, хүүхдээ ойлгож, дамжин туслах замаар боловсрол эзэмших, авьяас чадвараа хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх...
- Дотуур байранд амьдарч байгаа хүүхэдтэйгээ байнга холбоотой байх, эргэлтээр ирж, дотуур байрны багш болон анги удирдсан багштай уулзаж, зөвлөгөө авах, мэдээлэл солилцох...
- Багш, ажилтны нэр хүндийг гутаан доромжилсон үг хэллэг, үйлдлийг санаатай болон санамсаргүй байдлаар гаргахгүй, хүндэтгэлтэй харилцах ...

Эцэг эх, асран хамгаалагчдын ярилцлагаас үзэхэд сургууль - эцэг эх – дотуур байр гэсэн гурвалсан гэрээ байгуулсан надад гэрээний нэг хувь байгаа би гэрээний дагуу хүлээсэн үүргээ мэднэ гэж хариулсан хариулт 15 орчим хувьтай байна.

Ерөөсөө очоогүй, одоо л очих санаатай байна. Охин маань гэрээнд гарын үсгээ өөрөө зурсан гээд байх шиг байсан.

*... аймгийн ... сумын ... нэгэн өвөөгийн ярианаас*

Гэрээ байгуулж байгаагүй гэж нэгэн аймгийн эцэг эх, асран хамгаалагчид бүгд хариулсан байна. Бусад аймгийн хувьд гэрээ байгуулдаг ч нэг хувийг нь эцэг эх, асран хамгаалагчдад өгөөгүй байх эсвэл гэрээ байгуулсан ч гэрээг авсан үгүйгээ санахгүй, гэрээнд ямар үүрэг хүлээсэнээ санахгүй байх тохиолдлууд байна.

Гэрээтэй өөрийн биеэр уншиж танилцаагүй. Хааяа нэг эцэг эхийн хурал болдог байсан. Тэнд танилцуулдаг байсан. Сүүлийн 2 жилд хурал болоогүй. Захирал өмнөх жилүүдэд дотуур байранд өөрөө ирж хяналт, шаардлага тавьж овоо сайн ажилладаг байсан. Сүүлийн үед захирал анхаарал тавихаа байсан. Энэ намраас хоол амтгүй, уухгүй гээд хүүхдүүд маань гэрээс ааруул, боорцог их аваад явдаг болсон. .... гэж байрны багш их загнадаг, хэл амаар доромжилж байна. Бага ангийн жаахан хүүхдүүдийг эрт босоогүй гээд орилж, загнаж сэрээдэг...

*..... аймгийн нэгэн ээжийн ярианаас*

Эцэг эх, асран хамгаалагчид ярилцах явцад дотуур байранд хүүхэд байх давуу талуудыг хамгийн олон давтамжтай илэрхийлсэн байна. Үүнд:

- Хүүхэд бие даах чадвартай болдог
- Цэвэрхэн, дулаахан орчинд тайван амьдардаг
- Чирэгдэл багатай. Харуул хамгаалалттай. Хоол ундтай. Хичээлийг нь хийлгэдэг. Дулаахан.
- Амар байдаг. Орой үдэш гаргадаггүй. Амрах цагт нь амраадаг
- Өөрийн дураар, хоол унд сайтай, дэмий тэнэхгүй
- Айлд байхаас илүү амар тайван
- Сэтгэл амар, хүүхдэд аюулгүй
- Бие даагаад, хичээлээ хийгээд, аягаа угаагаад сурч байна, даалгавраа надаас хамааралгүй хийж байна. Хувцсаа ялгаад өөрөө өмсөөд сурч байна.
- Сэтгэл санаа зовох нь бага, амар тайван байдаг
- Гэртээ байгаа юм шиг л амьдардаг
- Нийтэч болдог, бусадтай эвтэй харилцаатай болно.
- Дотуур байр нь хараа хяналт сайтай байна. Орой 6 цагаас хойш ирэхгүй байвал над руу ярьдаг багш нар нь хариуцлагатай байдаг гэх мэтээр хариулсан байна.

...Хөдөөний бид нарт хүүхдээ харуулах найдвартай хүн багш нар байх юм даа гэж боддог. Суман дээр нэг гэртэй ч хоол унд юу ч хийж идэх юм, орой үдэш гараад явчихаар хараад хянах зөвлөх хүнгүй тэндээс бид нар санаа зовохоос өөр зүйлгүй утсаар л ярихаас хэтрэхгүй тэгснээс сургуулийнхаа дотуур байранд байх нь найдвартай амар санагддаг.

*..... аймгийн ..... сумын ээжийн ярианаас*

### 1.1. Дотуур байрны гадна орчин

Дотуур байрны үйлчилгээ үзүүлэх орчинд тавигдах стандартад: - гадна орчин, барилга, байгууламж, хүүхэд амьдрах өрөө, ариун цэврийн өрөө, бие засах газар,

хүүхэд хөгжлийн өрөө, номын сан, багшийн өрөө, эрүүл мэндийн өрөө, гал тогоо, дотуур байрны үйлчилгээ буюу хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээ, хүүхэд сурч боловсрох, хөгжүүлэхэд чиглэсэн үйлчилгээ, хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээ, хоол, хүнсний үйлчилгээ, хүний нөөцөд тавигдах шаардлага, цэвэрлэгээ, ариутгал, засвар үйлчилгээ, аюулгүй байдалд тавих шаардлага, хориглох зүйлсийг стандартад тусгаж орчин, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг тусгасан байна. Уг цогц стандарт нь 10 бүлгээс бүрдэх бөгөөд дотуур байрны үйлчилгээ эрхэлж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллагууд заавал хэрэгжүүлэхээр заасан байна. Үүний хэрэгжилт ямар байгааг бид энэхүү судалгаагаар илрүүлэхийг зорив.

Хүснэгт 2. Дотуур байрны гадна орчинд тавигдах шаардлага хангагдсан байдал

	Гадна орчинд тавигдах шаардлага	шаардлага хангасан	шаардлага хангаагүй	шаардлага хангасан хувиар
1	Дотуур байр сургуулиас 150 метр хүртэлх зайд	116	21	84.7
2	Сургууль дотроо хамт байрласан	42		30.7
3	Эзэмшил газрын 25 хувиас багагүй газрыг мод тарьж зүлэгжүүлсэн	76	61	55.5
4	Эмнэлэг, цагдаа, онцгой байдлын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нэвтрэх, болон ачаа ачих буулгах боломжтой	127	10	92.7
5	Дотуур байрны хашаан дотор болон эзэмшил газарт автомашины зогсоолтой	74	63	54
6	Биеийн тамирын задгай талбай, турник, гар, сагс, хөл бөмбөг тоглох талбайтай	94	40	70.8
7	Дотуур байрны өрөө бүр цонхтой, бүх өрөөний цонх хамгаалалттай	98	39	71.5

Дээрх хүснэгтээс үзэхэд судалгаанд хамрагдсан дотуур байр нь сургуулиас 150 метр хүртэлх зайд 85 хувь байрласан, 93 хувь нь эмнэлэг, цагдаа, онцгой байдлын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нэвтрэх, болон ачаа ачих буулгах боломжтой, 71 хувь нь биеийн тамирын задгай талбайтай түүнд турник, гар бөмбөг, сагсан бөмбөг, хөл бөмбөг тоглох талбайтай байна гэсэн шаардлагыг биелүүлсэн байна.

Сургуулийн болон дотуур байрны эзэмшил газрын 25 хувиас багагүй газрыг мод тарьж зүлэгжүүлсэн байх шаардлагыг 54.7 хувь нь бүрдүүлсэн байна. Ашиглалтад орсон хугацаагаар авч үзэхэд 1960 оноос өмнө ашиглалтад орсон дотуур байрны 80 хувь нь мод тарьж зүлэгжүүлсэн, 1970-1979 онд ашиглалтад орсон дотуур байрны 51.6 хувь нь, 2010-2019 онд ашиглалтад орсон дотуур байрны 22 нь, 2020 оноос хойш ашиглалтад оруулсан дотуур байрны 4 нь гадна орчноо зүлэгжүүлэн мод тарьсан байгаагаас үзэхэд сүүлийн 10 жилд ашиглалтад орсон байрууд нь гадаад орчноо тохижуулж амжаагүй тохижуулан зүлэгжүүлэхэд хугацаа ордог байна. Эзэмшил газрын 25 хувиас багагүй газрыг мод тарьж тохижуулсан дотуур байрны хувьд агааржуулалтын системтэй ( $r=343^{**}$ ,  $p<0.01$ ), цахилгаан холболтын аюулгүй байдал хангасан эсэхтэй ( $r=230^{**}$ ,  $p<0.01$ ), нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээ ( $r=232^{**}$ ,  $p<0.01$ ), биеийн тамирын гадаа талбайтай ( $r=303^{**}$ ,  $p<0.01$ ) хамааралтай байна.

Дотуур байрны өрөө бүр нь цонхтой байх шаардлагыг 71.5 хувь нь хангасан ба үүнийг ашиглалтад орсон хугацаагаар нь авч үзэхэд 2020 оноос хойш ашиглалтад орсон 11 дотуур байр, 2010-2019 онд ашиглалтад орсон 24 дотуур байр, 2000-2009 онд



ашиглалтад орсон 12 дотуур байр, 1960-1969 ашиглалтад орсон 2 дотуур байр бүрэн хангасан байна.

Дотуур байрны хашаан дотор болон эзэмшил газарт 54 хувь нь автомашины зогсоол байгуулсан байна.

## 1.2. Дотуур байрны дотоод орчин

Хүснэгт 3. Дотуур байрны барилга байгууламжид тавигдах шаардлага хангасан байдал

д/д	Барилга байгууламжид тавигдах шаардлага	шаардлага хангасан	шаардлага хангаагүй	шаардлага хангасан хувь
1	Төрийн албан ёсны хэлээр бичсэн хаягтай	109	28	79.6
2	Тэргэнцэрийн зориулалтын замтай	61	76	44.5
3	Аюулгүй байдлын дохиоллын системтэй	48	89	35.0
4	Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй	127	10	92.7
5	Агааржуулалтын системтэй	86	51	62.8
6	Аянга зайлуулагчтай	64	73	46.7
7	Хүүхдийн өрөө нь цахилгаан холболтын аюулгүй байдал (цахилгааны утас ил биш, далдлагдсаныг хангасан эсэх)	116	21	84.7
8	Төвийн цахилгаан эх үүсвэр бүхий халаалтын шугамтай	118	19	86.1
9	Бие даасан уурын зуухтай	33	104	24.1
10	Хүүхдийн амьдрах өрөөнд цахилгааны разетктай	113	24	82.5
11	Дотуур байрны коридор нь цахилгааны холболтын аюулгүй байдал хангагдсан	119	18	86.9
12	Дотуур байрны гал тогоо нь цахилгааны холболтын аюулгүй байдал хангагдсан	120	17	87.6
13	Ус цэвэршүүлэгчтэй	114	23	83.2
14	Буцалсан устай	123	14	89.8
15	Төвийн цахилгаан эрчим эх үүсвэрт холбогдсон	132	5	96.4

Сургууль дотуур байрны 79.5 хувь нь төрийн албан ёсны хэлээр бичсэн хаягтай байгаа ба 92.7 хувь нь байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй; 96.3 хувь дотуур байрны техник, тоног төхөөрмж цахилгаан холболтыг цахилгааны аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу гүйцэтгэсэн барилга байгууламжтай байна.

Дотуур байрандаа агааржуулалтын системтэй байгаа нь цонхны салхивч нь дээд талдаа байрласантай ( $r=0.602^{**}$ ,  $p<0.01$ ), цахилгааны холболт далд байрлуулсан эсэхтэй ( $r=0.360^{**}$ ,  $p<0.01$ ), 30 хүүхэд тутамд 1 угаалтууртай, суултууртай ( $r=0.345^{**}$ ,  $p<0.01$ ), гар хатаагч, таглаатай хогийг савтай ( $r=0.421^{**}$ ,  $p<0.01$ ) гэх мэт олон үзүүлэлттэй холбоотой байна.

Дотуур байрны 44.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд орж гарах зориулалтын замтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн зам тавьсан сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ( $r=0.261^{**}$ ,  $p<0.01$ ), зориулсан угаалтууртай ( $r=0.288^{**}$ ,  $p<0.01$ ) байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиромжтой байдал үүсгэж буй дотуур байрны

хувьд 2010-2019 онд ашиглалтад орсон дотуур байрны 71.9 хувь, 2020 оноос хойш ашиглалтад орсон дотуур байрны 78.6 хувь нь байгаагаас үзэхэд сүүлд баригдаж буй барилгын стандартад нэг үзүүлэлт болж оруулсан байх талтай байна.

Ямар нэг гэнэтийн аюултай үед 35 хувь нь хэрэглэх дохиоллын системтэй, аянга цахилгаантай бороо орсон үед 46.7 хувь л аянга зайлуулагчтай байгаа нь хангалтгүй үзүүлэлт байна. Аянга зайлуулагч байрлуулсан дотуур байрны хувьд 1990-1999 онд ашиглалтад орсон дотуур байрны 25 хувь, 1969 оноос өмнө орсон байрны 20-40 хувь нь байгаа бол 2000 оноос хойш баригдсан байрны 50-53.1 хувь, 2020 оноос хойш баригдсан байрны 71.4 хувьд нь байгаа нь мөн барилга барихдаа байршуулдагтай холбоотой болсон байна гэж үзэж болохоор байна. Аюулгүй байдлын дохиоллын систем мөн дотуур байрны ашиглалтад орсон жилтэй буюу 2010 оноос хойш орсон байрны 65.6-85.7 хувь нь холбоотой байна.

Дотуур байрны 62.7 хувь нь агааржуулалтын системтэй, хүүхдийн амьдарч буй өрөөндөө 82.4 хувь нь далд утастай цахилгааны разетктай, 86.8 хувь нь коридор нь цахилгааны холболтын аюулгүй байдал хангагдсан далд цахилгааны утастай байгаа нь аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Төвийн болон цахилгааны эх үүсвэр бүхий халаалтын шугамтай дотуур байр 86.1 хувь нь байгаа ба 87.5 хувьд нь гал тогооны өрөө нь цахилгааны холболтын аюулгүй байдал хангагдсан, 83.2 хувь нь ус цэвэршүүлэгчтэй байна.

... аймгийн ... сумын сургуулийн дотуур байр нь 20.. онд ашиглалтад орсон шинэ барилга стандартын дагуу аянга зайлуулагч, агааржуулагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэргэнцэрийн зам гээд олон шалгуур хангасан ч барилгын чанар муу хаалганы амалгаа сул, унах гээд багш нар дахин хадаж тогтоосон, сантехникийн буруу холболтоос болоод хана цуурсан, тааз нь мөөгөнцөртэй гэх мэт барилгын чанар талаас стандартад тусгах шаардлагатай байна.



..... судлаачийн тэмдэглэлээс

Хүснэгт 4. Дотуур байрны хүүхэд амьдрах өрөөнд тавигдах шаардлага хангасан байдал

д/д	Хүүхэд өрөөнд тавигдах шаардлага	шаардлага хангасан	шаардлага хангаагүй	шаардлага хангасан хувь
1	Нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээ 4м <sup>2</sup> -аас багагүй	99	38	72.3
2	Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн тустай өрөөтэй, нэг өрөөнд 8-аас ихгүй хүүхэд амьдардаг	129	8	94.2
3	Өрөө бүр цонхтой, 22°С-ын хэмээс доошгүй дулаантай, салхивчтай	110	27	80.3
4	Хүүхдийн тоогоор ортой	117	20	85.4
5	Хогийн савтай	129	8	94.2
6	Өрөөний тааз цагаан, хана цайвар өнгөтэй	126	11	92.0
7	Гудас цэвэрхэн	121	16	88.3
8	Гудас зузаан	94	43	68.6

9	Хөнжил цэвэрхэн	124	13	90.5
10	Хөнжил дулаан	116	21	84.7
11	Ширээтэй	130	7	94.9
12	Сандалтай	127	10	92.7

Хүүхдүүдийн 72.3 хувь нь ерөөндөө 4м<sup>2</sup>-аас багагүй талбайд амьдарч байгаа ба хүйсийн хувьд ч мөн тус тусдаа ерөөнд амьдардаг байна. Дотуур байрны стандартын шаардлагын дагуу 94.2 хувь нь 1 ерөөнд 8-аас ихгүй хүүхэд амьдарч байгаа ба ерөө бүр нь цонхтой, 22°С-ын хэмээс доошгүй дулаантай, салхивчтай ерөөнд 80.3 хувь нь амьдарч байна.

Дотуур байрны 85.4 хувь нь хүүхдийн тоогоор ортой байгаа ба хүүхдийн тоо их байгаа ч зайлшгүй орох хүүхдүүдийг хамаатан садан, ах, эгчийнх нь өвөрт хамт унтуулах замаар шийдсэн тохиолдол цөөнгүй байна.

Хүүхдүүдийн амьдарч буй ерөөний 92.0 хувь нь ерөөний тааз, цагаан, хана нь цайвар өнгөтэй, 90 хувь нь хөнжил нь цэвэрхэн, 84.7 хувь нь дулаан хөнжилтэй, 88 хувь нь хүүхдийн унтах гудас нь цэвэрхэн, 68.6 хувьд нь гудас унтахад нь тухтай зузаан, 94.2 хувь нь хогийн савтай байна. Сургуулийн удирдлага нь хүүхдийн хөнжил, гудас, ор хөнжлийн даавууг аль болох солих тухтай болгох тал дээр анхааран ажилладаг байдал судалгааны үр дүнд харагдсан байна. Энэ нь дотуур байрны стандартын 5.3.5 -д заасан шаардлагад нийцэж байна. Хөнжил нь цэвэрхэн бол ( $r=0.623^{**}$ ,  $p<0.01$ ), гудас нь зузаан ( $r=0.323^{**}$ ,  $p<0.01$ ), цэвэрхэн ( $r=0.503^{**}$ ,  $p<0.01$ ) байдаг байна.

Нийслэлийн захын сургуулийн дотуур байр нь ерөө тус бүрд амьдарч буй хүүхдийн тоогоор хувцасны шүүгээтэй, 6 настай хүүхдийн ерөө нь тэдэнд тохирсон ор, ширээ сандалтай, хувцасны шүүгээ нь хүртэл биеийн онцлогт тохирсон хэмжээтэй байна.

Нийслэлийн ..... дүүргийн ..... сургуулийн дотуур байр

Мөн стандартад хүүхдийн насны онцлогт тохирсон ширээ, сандал, хувцасны шүүгээтэй байна гэдэг заалтыг авч үзэхэд 94.9 хувь нь ширээтэй, 92.7 хувь нь сандалтай гэж байгаа боловч тухайн ерөөнд амьдарч буй хүүхдийн тоогоор, хүүхдийн бие бялдрын онцлогт тохирсон эсэхийг тодруулан үзээгүй тал байна.

Дотуур байранд хүүхдүүдийг оруулахдаа хамаатан садан, ах эгчтэй нь хамт оруулдаг учир нэг насныхан биш янз бүрийн насны хүүхдүүд хамт амьдарч буй учир ширээ, сандлын өндрийг тохируулан байршуулах нь нэг талаас хүндрэлтэй байдаг тал ажиглагдлаа. Зарим дотуур байр нь хүүхдүүдээ байршуулахдаа нас насаар нь нэг ерөө, тасагт оруулдаг ба энэ нь нэг талаас бие биедээ хичээл, даалгавар хийхэд тусалдаг бол нөгөө талаас үе тэнгийнхэнтэйгээ харилцах, санал бодол нийлэн нэг нэгнээ дэмжих боломжтой байдаг байна.

Манайх 6 настай хүүхдүүдээ нэг ерөөнд оруулдаг тэр нь амар байдаг. Яагаад гэхээр нэг үеийнхэн байранд амьдарч үзээгүй хүүхдүүд өөрсдөө оймсоо өмсөх, хувцсаа солих гээд бие даах нь илүү хурдан болдог. Эхний үед гэрээ санаад орондоо шээх тохиолдол байна. Энэ үед нь ах, эгчтэй нь нэг оронд унтуулаад дасгах байдлаар хэд хонуулдаг тэгээд өөрсдөө би нөгөө хэдтэйгээ нэг ерөөнд орьё гэж хэлэхээр нь оруулж өгдөг. Тэд нартайгаа хөөрхөн дасаад бие даагаад ирдэг. Багш хичээлд нь туслахад ч амар болдог.

Нийслэлийн ..... дүүргийн ..... сургуулийн дотуур байрны багшийн ярианаас

Нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээ 4м<sup>2</sup> -аас багагүй байна гэдэг шаардлагыг дотуур байрны ашиглалтад орсон хугацаатай авч үзэхэд 1990 оноос хойш баригдсан барилгын хувьд 75-85.7 хувь нь хангасан, нэг өрөөнд 8-аас ихгүй хүүхэд амьдардаг гэсэн үзүүлэлтийг 100 хувь хангасан, өрөө нь 22°С-ын хэмээс доошгүй дулаантай, салхивтай гэсэн үзүүлэлтийг 2010 оноос хойш баригдсан байр 87.5-92.9 хувь нь хангаж байгаа бол 1960 оноос өмнө баригдсан дотуур байрны 60 хувь нь хангасан ба 22 °С-аас доош хэмтэй байна.

Хүснэгт 5. Дотуур байрны ариун цэврийн өрөөнд тавигдах шаардлага хангасан байдал

д/д	Ариун цэврийн өрөө	шаардлага хангасан	шаардлага хангаагүй	шаардлага хангасан хувь
1	Агааржуулалтын системтэй, цонхны салхивч нь дээд талдаа байрласан	99	38	72.26
2	Цахилгааны холболт далд	113	24	82.48
3	30 хүүхэд тутамд 1 угаалтууртай	102	35	74.45
4	20 хүүхэд тутамд 1 шүршүүртэй.	70	67	51.09
5	Угаалга, хатаалгын төвлөрсөн өрөөтэй	82	55	59.85
6	50 хүүхэд тутамд 1 угаалга хатаалгын машин, индүүдлэгтэй	90	47	65.69
7	Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн ариун цэврийн өрөө, усанд орох өрөөг туспаа, охид, хөвгүүдээр ялгасан таних тэмдэгтэй	108	29	78.83
8	Гар угаах угаалтуур тогтмол савантай	66	71	48.18
9	Гар хатаагч, таглаатай хогийн савтай	67	70	48.91
10	Шал хальтардаггүй зориулалтын материалаар хийгдсэн	79	58	57.66
11	Бага насны хүүхдэд зориулсан угаалтуур, суултуур, шүршүүртэй	34	103	24.82
12	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан суултууртай	25	112	18.25
13	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан шүршүүртэй	12	125	8.76
14	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан угаалтууртай	22	115	16.06
15	Шилжилтийн насны охидод зориулсан дотуур хувцсаа угаах, солиход зориулсан, хаалгаар тусгаарласан угаалгын хэсэгтэй	33	104	24.09
16	Ариун цэврийн хэрэглэл, бусад хог хаягдлыг хаях тагтай хогийн савтай	96	41	70.07

Дээрх дүнгээс үзэхэд, 72.3 хувь агааржуулалтын системтэй, цонхны салхивч нь дээд талдаа байрласан байх стандарт шаардлага хангасан, 82.5 хувь нь цахилгааны холболт далд байх стандарт шаардлагыг хангасан байна.

Дотуур байрны 74.5 хувь 30 хүүхэд тутамд 1 угаалтууртай, 51.1 хувь нь 20 хүүхэд тутамд 1 шүршүүртэй байх шаардлага хангасан, 65.7 хувь нь 50 хүүхэд тутамд 1 угаалга хатаалгын машин, индүүний тавцантай байна.

Ариун цэврийн өрөөний 78.8 хувь нь хүйсээр ялгасан таних тэмдэгтэй, 59.9 хувь нь халуун усанд орох өрөө тус тусдаа хүйсээр ялгасан таних тэмдэгтэй, 48.2 хувьд нь гар

угаах угаалтуурт тогтмол саван байдаг байна. Халуун усны өрөөнд таних тэмдэгтэй байх тусам дотуур байр нь 20 хүүхэд тутамд 1 шүршүүртэй ( $r=0.599^{**}$ ,  $p<0.01$ ), бага насны хүүхдэд зориулсан шүршүүртэй ( $r=0.402^{**}$ ,  $p<0.01$ ), суултууртай ( $r=0.395^{**}$ ,  $p<0.01$ ), угаалтууртай ( $r=0.321^{**}$ ,  $p<0.01$ ), шал нь хальтрахгүй зориулалтын материалаар хийгдсэн байна. Иймд сургууль дотуур байрны ариун цэврийн өрөөний тохижилт стандарт шаардлагыг цогцод нь анхаардаг нь харагдаж байна.

Харин ариун цэврийн өрөөнд 48.9 хувь нь л гар хатаагч, таглаатай хогийн савтай, 57.7 хувьд шал нь хальтардаггүй материалаар хийгдсэн байна.

Судалгаанд хамрагдсан нийт дотуур байрны 24.8 хувь нь бага насны хүүхдэд зориулсан шүршүүртэй, 38.0 хувь нь бие засах суултууртай, 43.1 хувь нь л зориулсан угаалтууртай байгаа нь бага насны хүүхдэд тохирсон байдлаар тохижуулах шаардлагатай байна.

Харин 8.8 хувь нь хөгжлийн бэршээлтэй хүүхдэд зориулсан шүршүүртэй, 18.2 хувь нь тэдэнд тохирсон суултууртай, 16.1 хувь нь угаалтууртай байгаа нь мөн хөгжлийн бэршээлтэй хүүхэд дотуур байранд амьдрах боломж бүрдээгүй байгааг харуулж байна.

Дотуур байранд шилжилтийн насны охид амьдарч байгаатай холбоотой тэдэнд зориулсан дотуур хувцсаа угаах, солиход зориулсан, хаалгаар тусгаарлагдсан угаалгын хэсэг бий болгосон 33 дотуур байр буюу судалгаанд хамрагдсан дотуур байрны 24.1 хувийг эзэлж байна. Ариун цэврийн хэрэглэл болон бусад хогоо хаях тагтай хогийн савыг 70.1 хувь нь байршуулсан байна. Дотуур байрны ариун цэврийн өрөөг тавигдах шаардлагын дагуу бүрэн тохижуулах хэрэгтэйг судалгааны үр дүн харуулж байна.

Хүснэгт 6. Дотуур байрны бие засах өрөөнд тавигдах шаардлага хангасан байдал тоогоор

д/д	Бие засах өрөөнд тавих шаардлага	шаардлага хангасан	шаардлага хангаагүй	шаардлага хангасан хувь
1	Суултуурууд тусгаарлагчтай	106	31	77.37
2	25 эрэгтэй хүүхэд тутамд нэг суултуур, нэг шээлтүүртэй	89	48	64.96
3	20 эмэгтэй хүүхэд тутамд нэг суултууртай	95	42	69.34
4	Дотор суултуурыг галнаас дээш өндөрлөж суурилуулсан	80	57	58.39
5	Гадаа 00-ын явган суултуурыг шалнаас дээш өндөрлөж суурилуулсан	34	103	24.82
6	Гадна жорлон нь бат бэх, аюулгүй байдлыг хангасан материалаар хийгдсэн	59	78	43.07
7	Бие засах өрөөнд чийг болон эвгүй үнэр гардаг	60	77	43.80
8	Суултуурын татуурга, бариул нь бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиромжтой	50	87	36.50
9	Гадна бие засах газар нь дотуур байрны гарах хаалганаас 30 метр хүртэл зайнд байрладаг	68	69	49.64
10	Гадна бие засах газар хүрэх зам гэрэлтүүлэгтэй	67	70	48.91
11	Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан суултууртай	29	108	21.17

Дотуур байр нь ариун цэврийн өрөөндөө суултуурууд тусгаарлагчтай байх шаардлагыг 77.4 хувь нь хангасан бол 25 эрэгтэй хүүхэд тутамд нэг суултуур, нэг шээлтүүртэй байх шаардлага 65 хувь нь хангасан, 69.3 хувь нь 20 эмэгтэй хүүхэд тутамд нэг суултууртай байгаа ба 58.4 хувь нь 00-ийн өрөөний явган суултуурыг шалнаас дээш өндөрлөж суурилуулсан байна.

Дотуур байрууд нь гадаа болон дотор 00-ын өрөөтэй ба гадаа 00-ын хувьд 24.8 хувь нь явган суултуурыг шалнаас дээш өндөрлөж суурилуулсан байсан ба 43.1 хувь нь гаднах 00 - оо бат бэх, аюулгүй байдлыг хангасан материалаар хийсэн ба бие засах газар нь дотуур байрнаасаа 49.6 хувь нь 30 м зайд байрласан 48.9 хувь нь гэрэлтүүлэгтэй, 21.3 хувь нь бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан суултууртай байна.

Бие засах өрөө нь чийг болон эвгүй үнэр гардаг эсэх нь байр баригдсан онтой хамааралгүй байгаа ч 1960 оноос өмнө ашиглалтад орсон байрны 60 хувь, 1980-1989 онд ашиглалтад орсон байрны 46.4 хувь, 1990-1999 оны байрны 50 хувь, 2020 оноос хойш ашиглалтад орсон байрны 57.1 хувь нь чийг, эвгүй үнэртэй байна гэж тэмдэглэгдсэн байна. Иймд сүүлийн үед баригдаж байгааг байрыг барих болон хүлээж авахдаа сантехникийн байгууламжийг нэг шалгуур болгох хэрэгцээтэй байна.

Гадна бие засах газар нь дотуур байрны гарах хаалганаас 30 метрт байх нь ( $r=577^{**}$ ,  $p<0.01$ ) гэрэлтүүлэгтэй, бат бэх материалаар хийгдсэн ( $r=565^{**}$ ,  $p<0.01$ ), явган суултуурыг шалнаас дээш өндөрлөж ( $r=0.285^{**}$ ,  $p<0.01$ ) байрлуулсан эсэхтэй холбоотой байгаа нь гадаа нойлдоо анхаардаг сургуулиуд стандарт баримталдгийг харуулж байна.

Хүснэгт 7. Дотуур байрны хүүхэд хөгжлийн өрөө, номын сан, багшийн өрөөнд тавигдах шаардлага хангасан байдал


д/д	шаардлага	шаардлага хангасан	шаардлага хангаагүй	шаардлага хангасан хувь
<i>Хүүхэд хөгжлийн өрөөнд тавигдах шаардлага</i>				
1	Өрөөний талбайн хэмжээ 30м <sup>2</sup> -аас доошгүй	106	31	77.37
2	Хөгжим	50	87	36.50
3	Зурагт	100	37	72.99
4	Компьютер	47	90	34.31
5	Интернет	36	101	26.3
6	Сэтгэхүй хөгжүүлэх тоглоом	89	48	64.96
7	Буйдан	65	72	47.45
8	Номын булан	90	47	65.69
<i>Дотуур байрны номын санд тавигдах шаардлага</i>				
1	Нийт хүүхдийн 20 хувьд нэг дор үйлчлэх ширээ, сандал, самбартай	66	69	48.89
2	Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй	92	42	68.66
3	1 хүүхдэд ноогдох талбай 2.4 м <sup>2</sup> -аас доошгүй	72	62	53.73
4	Бүрэн дунд боловсролын сурах бичиг	53	80	39.85
5	Суурь боловсролын сурах бичиг	55	79	41.04
6	Бага боловсролын сурах бичиг	55	80	40.74
7	Гарын авлага	68	67	50.37
8	Уран зохиолын ном	81	54	60.00

Багшийн өрөөнд тавигдах шаардлага				
1	10 м <sup>2</sup> - аас доошгүй талбайтай	95	42	69.34
2	Компьютер	95	42	69.34
3	Ширээ, сандал	98	39	71.53
4	Мэргэжлийн ном	95	42	69.34

Хүүхэд хөгжлийн өрөөний талбайн хэмжээг авч үзвэл 77 хувь нь 30 м<sup>2</sup>-ээс доошгүй хэмжээтэй, 36.5 хувь нь хөгжимтэй, 73 хувь нь зурагттай, 34.3 хувь компьютертэй; 65.0 хувь нь сэтгэхүй хөгжүүлэх тоглоомтой, 47.4 хувь нь буйдантай; 26.3 хувь интернэтийн сүлжээтэй, 65.7 хувь нь номын булантай байна. Дотуур байрны хүүхэд хөгжлийн өрөө нь хөгжимтэй байгаа нь ( $r=0.256^{**}$ ,  $p<0.01$ ) зурагттай, компьютертэй ( $r=0.410^{**}$ ,  $p<0.01$ ), интернэт холболттой ( $r=0.271^{**}$ ,  $p<0.01$ ), сэтгэхүй хөгжүүлэх тоглоомтой өрөө нь ( $r=0.311^{**}$ ,  $p<0.01$ ) зурагттай, компьютертэй ( $r=0.273^{**}$ ,  $p<0.01$ ), интернэт холболттой ( $r=0.230^{**}$ ,  $p<0.01$ ) холбоотой байна.

Эндээс үзэхэд дотуур байр нь интернэтийн сүлжээгүй байгаа нь ахлах ангийнхан болон дунд ангийн сурагчид багшийн өгсөн даалгавар хийхэд болон бусад мэдээлэл авах боломж хязгаарлагдаж байгааг харуулж байна. Дотуур байрны 26.3 хувь нь интернэттэй байгаа учир 73 хувь нь өөрсдийн датаг ашигладаг байна. Хэдийгээр 66 хувь нь номын сантай гэж байгаа боловч номны агуулга, хүртээмж, сурах бичиг анги тус бүрээр хангалттай бус байна. Сурах бичгийн хувьд 38.7 хувь нь бүрэн дунд боловсролын сурах бичигтэй, 40.1 хувь нь суурь боловсрол, 40.1 хувь нь бага боловсролын сурах бичигтэй, 49.6 хувь нь гарын авлагатай; 59.1 хувь нь уран зохиолын номтой байна.

Зураг 2. Хүүхэд хөгжлийн өрөөний номын санд байгаа номны эзлэх хувь



Судалгаанд хамрагдсан нийт 106 дотуур байрны хүүхэд хөгжлийн өрөөтэй боловч сурах бичиг, унших ном зохиол нь хангалттай бус байна.

ЕБС-ийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага буюу MNS 6781:2019 стандартын 5.6 Хүүхэд хөгжлийн өрөө -нд 2 заалт буюу талбайн хэмжээ, төрөл бүрийн тоглоом шаардлагатай эд зүйлсээр хангана гэж заасан бол 5.7 Номын сан -ын 5.7.1-д Нийт хүүхдийн 20 хувьд нэг дор үйлчлэх боломж бүхий ширээ, сандал, самбар, зохиомол гэрэлтүүлэгтэй номын сантай байна. гэж заасан байна.

Нийт судалгаанд хамрагдсан дотуур байр нь хүүхэд хөгжлийн өрөө болон номын санг аль алинг хүүхдээ хөгжүүлэх үйл ажиллагаанд ашигладаг ба хүүхдийн 20 хувьд нэг дор үйлчлэх ширээ, сандал, самбартай байна гэдэг стандарт шаардлагыг 48.2 хувь нь

биелүүлсэн, номын сангийн 67.2 хувь нь байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.

Багшийн өрөөний хувьд 69.3 хувь нь 10 м<sup>2</sup>-аас доошгүй талбайтай өрөөтэй өрөөний тохижилтын хувьд 69.3 хувь нь компьютер, хяналтын нэгдсэн камертай, 71.5 хувь нь ширээ, сандал амрах буйдантай, 69.3 хувь нь мэргэжлийн номтой байгаа ч багш нарын 42 буюу 30.7 хувь нь өөрсдийн гэсэн өрөөгүй, ажил гүйцэтгэх компьютер принтергүй, мэргэжлийн ном, гарын авлага хангалтгүй байна.

Дотуур байр нь хүүхэд хөгжлийн өрөө ба номын сан нь стандарт хэмжээтэй байх нь бусад үзүүлэлтүүд хэрэгжих боломжтой байдаг байна. Тухайлбал - Өрөөний талбайн хэмжээ 30 м<sup>2</sup>-ээс доошгүй байх тусам ( $r=0.242^{**}$ ,  $p<0.01$ ) нийт хүүхдийн 20 хувьд үйлчлэх ширээ сандал, самбартай, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй ( $r=0.253^{**}$ ,  $p<0.01$ ), нэг хүүхдэд ногдох талбай 2.4м<sup>2</sup> -аас доошгүй байх ( $r=.290^{**}$ ,  $p<0.01$ ), чийрэгжүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эмчийн үзлэг хийхэд зориулсан өрөөтэй ( $r=0.227^{**}$ ,  $p<0.01$ ), эмнэлгийн хэрэгсэл бүхий шүүгээтэй ( $r=227^{**}$ ,  $p<0.01$ ), өндөр хэмжигч ( $r=0.229^{**}$ ,  $p<0.01$ ), чагнуур, үзлэг хийх зориулалтын ор, сандал, ширээтэй ( $r=0.280^{**}$ ,  $p<0.01$ ) байх боломжтой байдаг байна. Стандартад заасан талбайн хэмжээг баримтлах нь бусад заалтуудыг хэрэгжүүлэх боломжтой болдог байна.

Хүснэгт 8. Эрүүл мэндийн өрөөнд тавигдах шаардлага хангасан байдал

д/д	Эрүүл мэндийн өрөөнд тавих шаардлага	шаардлага хангасан	шаардлага хангаагүй	шаардлага хангасан хувь
1	Алжаал тайлж, чийрэгжүүлэх, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, эмчийн үзлэг хийхэд зориулсан, 12м <sup>2</sup> -аас доошгүй талбайтай өрөө	49	88	35.77
2	Анхан шатны яаралтай тусламж үзүүлэх, эмнэлгийн хэрэгсэл бүхий шүүгээ	64	73	46.72
3	Жин	46	91	33.58
4	Өндөр хэмжигч	50	87	36.50
5	Чагнуур	47	90	34.31
6	Даралт хэмжигч	45	92	32.85
7	Үзлэг хийх зориулалтын ор	44	93	32.12
8	Сандал	57	80	41.61
9	Ширээ	57	80	41.61

Бидний судалгаанд хамрагдсан дотуур байрны 35.8 хувь нь сурагчдын алжаал тайлж, чийрэгжүүлэх, эмчийн үзлэг хийхэд зориулсан өрөөтэй байгаа ба түүнээс 46.7 хувь нь анхны тусламж үзүүлэх хэрэгсэл бүхий шүүгээтэй, 33.6 хувь нь хүүхдийн биеийн жин үзэх боломжтой, 36.5 хувь нь өндөр хэмжигчтэй, 34.3 хувь нь чагнууртай, 32.8 хувь нь даралт хэмжигчтэй, 32.1 хувь нь үзлэг хийх зориулалтын ортой, 41.6 хувь нь сандалтай, 41.6 хувь нь ширээтэй байна. Энэ нь дотуур байранд эмч ирж ажиллах тоног төхөөрөмжтэй өрөө хангалтгүй байгааг харуулж байна. Дотуур байрны хүүхдүүд сургууль дээрээ эмчид үзүүлэх боломжтой ба оройн цагаар өвдсөн үед дотуур байрны жижүүр нь эмч дуудаж үзүүлэх тохиолдол гардаг байна.

...Дотуур байранд эрүүл ахуйч ажиллахын давуу тал нь – гал тогооны эрүүл ахуйн шаардлага хангагддаг, мөн дотуур байранд суудаг хүүхдүүдийн эрүүл мэндийн байдалд хяналт тавьдаг ...  
Улаанбаатар хотын ..... сургуулийн эмчийн ярианаас



Хүснэгт 9. Дотуур байрны гал тогоонд тавигдах шаардлага хангасан байдал

д/д	Гал тогоонд тавих шаардлага	шаардлага хангасан	шаардлага хангаагүй	шаардлага хангасан хувь
1	Шал, хана плитатай	114	23	83.21
2	Тааз ус нэвтэрдэггүй, бат бөх, тэгш гөлгөр гадаргуутай, өнгө үзэмж, цэвэрлэхэд хялбар, сайн чанарын материалтай	101	36	73.72
3	Гал унтраах хэрэгслийг нүдэнд ил харагдах газар байрлуулсан	88	49	64.23
4	Хүнсний зориулалтын материалаар хийсэн, таглаатай ундны ус зөөх хадгалах савтай	107	30	78.10
5	Эрүүл ахуйн шаардлагыг хангасан аяга, таваг, хоолны сав, хэрэгсэлтэй	91	46	66.42
6	Хооллох хэрэгслийг угаах, хатаах, ариутгах машинтай	105	32	76.64

Дотуур байрны гал тогооны өрөөний 83.2 хувь нь шал болон хана нь плитатай; 73.7 хувь нь тааз нь ус нэвтэрдэггүй гадаргуутай, өнгө үзэмжтэй, цэвэрлэхэд хялбар, сайн чанарын материалтай; 64.2 хувь нь гал унтраах хэрэгслийг нүдэнд ил харагдах газар байрлуулсан байна. Шал, хана плитатай байх нь ( $r=0.353^{**}$ ,  $p<0.01$ ) тааз ус нэвтэрдэггүй, бат бөх, тэгш гөлгөр гадаргуутай эсэхтэй болон гал унтраах хэрэгслийг нүдэнд ил харагдах газар байрлуулсан эсэхтэй ( $r=276^{**}$ ,  $p<0.01$ ), хүнсний зориулалтын материалаар хийсэн, таглаатай ундны ус зөөх хадгалах савтай байгаатай хүүхдүүдийн аяга таваг, хоолны сав нь шаазан шилэн материалтай байгаа эсэхтэй ( $r=296^{**}$ ,  $p<0.01$ ), хооллох хэрэгслийг угаах, ариутгах машинтай ( $r=250^{**}$ ,  $p<0.01$ ) байгаа эсэхтэй хамааралтай байна.

Дотуур байрны гал тогооны өрөөний 78.1 хувь нь хүнсний зориулалтын материалаар хийсэн, таглаатай ундны ус зөөх, хадгалах савтай, 66.4 хувь нь эрүүл ахуйн шаардлагыг хангасан аяга, таваг, хоолны сав, хэрэгсэлтэй; 76.6 хувь нь хооллох хэрэгслийг угаах, хатаах, ариутгах машинтай байгааг судалгааны үр дүн харуулж байна.

#### Дотуур байрны хүчин чадал (ашиглалтын хугацаа, камержуулалт)

Хүснэгт 10. Дотуур байрны камержуулалт

д/д	Дотуур байрны хүчин чадалд тавигдах шаардлага	шаардлага хангасан	шаардлага хангаагүй	шаардлага хангасан хувь
1	Дотуур байрны гадна талд камертай	112	25	81.75
2	Давхар бүрд камертай	117	20	85.40
3	Хүүхдийн амьдардаг өрөөнөөс бусад өрөө камертай	87	50	63.50

Дотуур байрны гадна талд камертай байх шаардлагын хувьд 81.8 хувь нь гаднаа камертай, 85.4 хувь нь давхар бүрд камертай, 63.5 хувь нь хүүхдийн амьдардаг өрөөнөөс бусад өрөөнд камер байрлуулсан ба хадгалах цагийг дотуур байрны багш ба жижүүрүүд тэр бүр сайн мэддэггүй, зарим нь 3-4 цаг байх, зарим нь 7-14 хоног байдаг байх гэж хариулсан байна.

...Дотуур байранд хүүхдийн амьдарч буй өрөөнд нь камертай байсан. Хүний эрхийн судлаачид ирж хүүхдийн өрөөнд камергүй тавьж болохгүй ав гэсэн. Эцэг эх, асран хамгаалагчид нь өрөөнд нь байх нь уул нь зүгээр дээ гэсэн ч бид авсан. Харин гадаад орчинг камержуулхад камерийн чанар чухал байдаг юм байна. Чанараасаа хамаараад үнэ нь их болоод бид хангалттай сайн чанартайг авч чадахгүй л байна...

*Улаанбаатар хотын ..... сургуулийн захирлын ярианаас*

Мөн дотуур байр хэдийгээр камержуулсан ч гэсэн дүрсийг тод харагдахаар, хадгалах хугацаа нь урт байхаар гэх мэт чанартай камер байх шаардлагатай байна.

*Хүснэгт 11. Дотуур байрны ашиглалтын хугацаа*

	<i>Ашиглалтад орсон хугацаа</i>	<i>Дотуур байрны тоо</i>	<i>шаардлага хангасан хувь</i>
1	1960 оноос өмнө	5	3.6
2	1960-1969 он	5	3.6
3	1970-1979 он	31	22.6
4	1980-1989 он	28	20.4
5	1990-1999 он	8	5.8
6	2000-2009 он	14	10.2
7	2010-2019 он	32	23.4
8	2020 оноос хойш	14	10.2

Урсгал засварыг 24 дотуур байр нь жил бүр (17.5%) хийдэг гэсэн бол 8 дотуур байр нь 2000-2008 онд урсгал засвар хийгдсэн, 21 дотуур байр нь 2012-2019 онд л урсгал засвар хийсэн, 2020-2023 онд 36 дотуур байр урсгал засвар хийсэн гэж хариулсан байна.

...Сургуулийн захирал төсөл хөөцөлдөж ... санхүүжилтээр манай дотуур байр энэ жил хүүхдүүдийнхээ ариун цэврийн өрөөг байх ёстой стандартаар нь тохижуулж авсан. Бас бага ангийн хүүхдэд тохирсон шүршүүртэй болсон. Ямар ч байсан хүүхдүүд маань усанд ороод байх боломжтой болсонд баяртай байгаа...

*Улаанбаатар хотын ..... дотуур байрны туслах багшийн ярианаас ..*

Дотуур байрны урсгал засвар, их засвар нь төсөвт мөнгө хуваарилагдаагүй бол хийгдэх боломж бага байдаг байна.

## Дүгнэлт

- Эцэг эх, асран хамгаалагчтай байгуулсан гэрээг нэгдсэн бүтэцтэй болгох, гэрээний хугацааг тодорхой болгох, гэрээний биелэлтийг хянах шаардлага байна.
- Дотуур байранд амьдарч буй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид ямар эрх үүрэгтэй талаар тэдэнд зориулсан сургалт зохион байгуулах шаардлагатай байна.
- Дотуур байрны орчинд тавих шаардлагын 5.1.2-т заагдсан шаардлага, MNS 5973;2009 стандартыг судалгаанд хамрагдсан дотуур байрны 45-46 хувьд нь хангаагүй байна. Иймд ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, дотуур байрны болон биологийн багш нар сурагчид, эцэг эх, төрийн бус байгууллагын оролцоо дэмжлэгтэйгээр дотуур байрны гадна орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, сурагчдын аюулгүй байдлыг хангаж ажиллах хэрэгцээ байна.
- БД 31-101-04 тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн норм болон Барилга байгууламжийн 5.2.2, 5.2.3-буюу БНбд21-02-01-ийн шаардлагын хүрээнд 55.5 хувь нь тэргэнцэрийн зориулалтын замтай байх; 65 хувь нь аюулгүй байдлын дохиоллын системтэй байх; 53.3 хувь нь аянга зайлуулагчтай байх шаардлагыг хангахуйц тохижилт хийгдээгүй байна.
- Стандартын 5.2.9-д заагдсан - Дотуур байрны техник, тоног төхөөрмж цахилгаан холболтыг цахилгааны аюулгүй ажиллагааны дүрэм, төвийн цахилгаан эх үүсвэр бүхий халаалтын шугам, давхар бүрд хүүхэд амрах, цай уух зориулалтай өрөө болон булан, хүүхдийн амьдрах өрөөнд цахилгааны разетка, дотуур байрны коридор, гал тогоо нь цахилгааны холболтын аюулгүй байдал хангагдсан, ус цэвэршүүлэгчтэй байх шаардлагуудыг 83-95 хувьтай хангасан байна.
- Стандартын 5.3-т буй хүүхдийн өрөөнд тавигдах 12 шаардлагын судалгаанд хамрагдсан дотуур байрны 80 хувь хангаж байгаа нь сурагчдын амьдрах өрөөг тав тухтай байлгахад илүү их анхаарч ажилладаг байна.
- Стандартын 5.5-т буй – 75.18 хувь нь “Бие засах өрөөний хувьд гадаа 00-ын явган суултуурыг шалнаас дээш өндөрлөж суурилуулсан байх; 56.93 хувь нь гадна жорлон нь бат бэх, аюулгүй байдлыг хангасан материалаар хийгдсэн байх; 56.2 хувь нь бие засах өрөөнд чийг болон эвгүй үнэр гардаг; 63.5 хувь нь суултуурын татуурга, бариул нь бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиромжтой байх; 50.4 хувь нь гадна бие засах газар нь дотуур байрны гарах хаалганаас 30 метр хүртэл зайнд байрлана байх; 51.9 хувь нь гадна бие засах газар хүрэх зам гэрэлтүүлэгтэй байх; 78.83 хувь нь бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан суултууртай байх” шаардлагыг хангах хэмжээнд тохижилт хийгдээгүй байна. Энэ нь дотуур байрны бие засах өрөөнд тавих шаардлага хангалтгүй байгааг харуулахаас гадна цаашид бие засах өрөөг тавигдах шаардлагын хүрээнд бүрэн тохижуулах хэрэгтэйг илэрхийлж байна.
- Стандартын 5.9-т буй Эрүүл мэндийн өрөөний тухайд 53.28 хувь нь анхан шатны яаралтай тусламж үзүүлэх, эм эмнэлгийн хэрэгсэл бүхий шүүгээтэй байх; 66.4 хувь нь жин; 63.5 хувь нь өндөр хэмжигч; 67.15 хувь нь даралт хэмжигчтэй байх; 67.9 хувь нь үзлэг хийх зориулалтын ортой байх шаардлагад нийцүүлэн эмчийн өрөөг тохижуулаагүй нь эмчийн өрөөг шаардлага, стандартын дагуу тохижуулах хэрэгцээг илэрхийлж байна.

- Дотуур байрны гадна талд 82 хувь нь камертай, давхар бүр нь 85 хувь нь камертай; хүүхдийн амьдардаг өрөөнөөс бусад өрөө камертай байх шаардлагыг 64 хувь нь хангаж байгаа нь дотуур байрны аюулгүй байдал, сурагчдыг янз бүрийн эрсдэлээс хамгаалахад зориулалттай байгаа ч чанар, хадгалах хугацааг сайжруулах шаардлагатай байна.
- Судалгаанд хамрагдсан дотуур байруудын 7.2 хувийг 1960 оноос өмнө болон 1960-1969 онд ашиглалтад; 22.6 хувийг 1970-1979 онд ашиглалтад орсон байрууд байгаа нь суралцагчдын аюулгүй, эрсдэлгүй амьдрах байдалд сөргөөр нөлөөлөх тул яаралтай шинэ дотуур байраар хангах хэрэгтэй байна.

### **Санал, зөвлөмж**

Дотуур байрны орчинд тавигдах шаардлагыг хангахын тулд дараах зүйлд анхаарлаа хандуулах нь зүйтэй юм. Үүнд:

#### *Барилга, байгууламжийн талаас:*

- Барилга, байгууламжийн чанарын асуудлыг зайлшгүй хөндөж тавих нэг шалгуур болгох
- Барилга байгууламж барихдаа өрөө тасалгааны хэмжээг баримтлах
- Багшийн өрөө, хүүхэд хөгжлийн өрөө, номын сан, жижүүрийн өрөө, эцэг эх, асран хамгаалагчийн өрөөний хэмжээг тус тусад нь нарийн тусгах
- Авто машины зогсоолгүй байна гэдэг үзүүлэлтийг эргэж харах
- Сүүлийн үед баригдаж байгааг байрыг барих болон хүлээж авахдаа сантехникийн байгууламжийг нэг шалгуур болгон тусгах
- Судалгаанд хамрагдсан 42 дотуур байр буюу 30.7 хувь нь нь багшийн өрөөгүй, 30.7 хувь нь мэргэжлийн ном, компьютергүй, 28.5 хувь нь ширээ сандалгүй байгааг анхаарах шаардлагатай байна.

#### **Хүүхдийн амьдрах өрөө**

- Нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээг баримтлах
- Тус журмын 5.3.5-д заасан хүүхдийн тоогоор ор, зөөлөн эдлэл байх бөгөөд хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон ширээ, сандал, хувцасны шүүгээ, хогийн савтай байна гэсэн заалтыг тодруулах тухайлбал 6 настай хүүхдийн өрөөний ор, ширээ, сандал, хувцасны шүүгээний өндрийн хэмжээг нарийн тогтоох гэх мэтээр хүүхдийн нас тус бүрийн онцлогт тохирсон байдлаар тусгах
- Зөөлөн эдлэлийн хэмжээ зузааны хэмжээг тухайлбал, гудас ямар материалаар хийгдсэн хэдэн см -ийн зузаантай байх, хөнжил мөн адил ямар материалаар хийгдсэн хүнд хөнгөний хэмжээг нарийн тусгаж стандартын шаардлага хэмжээг тусгах
- 6-8 сурагчдын дунд янз бүрийн хэмжээтэй 1 ширээ, 1 сандал нийтлэг байна. Иймд дотуур байрныхүүхдийн өрөөний ширээ, сандалд тавигдах шаардлагыг насны онцлогт нийцүүлэн тогтоох хэрэгтэй.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ДОТУУР БАЙРАН ДАХЬ ХҮҮХЭД ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

### 2.1. Дотуур байранд зохион байгуулагддаг хүүхэд хөгжлийн үйл ажиллагаа, хүүхдийн оролцоо

Монгол Улс 1990 онд албан ёсоор Хүүхдийн Эрхийн Конвенцид нэгдэн орсноор Монгол Улс нь Олон Улсын өмнө Хүүхдийн эрхийг дээдлэх хамгаалах үүргийг албан ёсоор хүлээсэн байдаг. Энэхүү Олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу хүүхэд бүр ямар ч алагчлалгүйгээр хүүхэд хамгааллын тусламж, үйлчилгээ хүртэж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж, бие хүн болж төлөвших, авьяас чадвараа бүрэн дүүрэн нээн хөгжүүлэх боломжоор хангагдаж, аз жаргал, хайр энэрэл, ойлголцол бүрдсэн орчинд өсөн торниж, өөрсдийн эрхийн талаар мэдлэг мэдээлэлтэй байж, эрхээ эдлэх үйл явцдаа идэвхтэй оролцох боломжоор хангагдах зэрэг нөхцөлийг бүрдүүлэх үүргийг хүлээсэн.

Ийнхүү конвенцид нэгдэн орсноор манай улс хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагаагаа Конвенцид нийцүүлж, нийгмийн амьдралын бүхий л хүрээнд хүүхдийн эрхийг дээдлэх, хүүхэд эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэх, эрхийг нь зөрчсөн тохиолдолд түүнийг таслан зогсоох арга хэмжээг зайлшгүй авах үүрэгтэй юм.

Хүүхдийн эрхийн тухай хуульд зааснаар төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмжлэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах, тэдний нас, бие сэтгэхүйн онцлогт нь тохирсон мэдээ мэдээллээр хангах зэрэг зарчмыг баримтална гэжээ.

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн амьдралын орчин болсон дотуур байранд хүүхдийн эрхийг дээдлэн ажиллах, хүүхэд хамгааллын таатай орчин бүрдүүлэх нь төр, олон нийтийн үүрэг юм.

#### Судалгааны арга зүй

Дотуур байранд амьдарч байгаа суралцагчдад зориулсан хөгжил, сургалтын үйл ажиллагаа, түүнд хүүхдийн идэвх оролцоог тогтоох зорилготой анкет, ярилцлагын аргаар судалгааг явууллаа.

Судалгааны асуулгад сонгогдсон, аймаг, сумын дотуур байранд амьдарч байгаа бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин бүрээс 10 хүүхэд буюу нийт 30 хүүхдийг санамсаргүй түүврийн аргаар сонгож асуулга бөглүүлсэн.


Ярилцлагыг ганцаарчилсан аргаар явуулсан ба бага анги, дунд анги, ахлах ангийн тус бүр 1 хүүхдийг санамсаргүйгээр сонгож ярилцлагыг авлаа.

Асуулгаар дотуур байрны хүүхэд хөгжлийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдлыг илрүүлэх үүднээс хүүхэд хөгжлийн өрөө, номын сангийн үйлчилгээ, хөгжил, төлөвшлийн үйл ажиллагааг тодруулахыг зориллоо.

#### 2.1.1. Ерөнхий мэдээлэл


Нийт 7374 хүүхэд асуулгад оролцсоноос 55 хувь нь эмэгтэй, 45 хувь нь эрэгтэй байна. Асуулгад оролцсон хүүхдийн ихэнх нь буюу 74 хувь нь 1-5 жил дотуур байранд амьдарсан байна.

Зураг 3. Дотуур байранд амьдарсан жил (хувиар)



Боловсролын түвшнээр нь авч үзвэл, бүрэн дунд боловсролын түвшний хүүхдүүд харьцангуй цөөн байгаа нь зарим сум орон нутагт 9 жилийн сургалттай ерөнхий боловсролын сургуулиуд байгаатай холбоотой.

Зураг 4. Суралцдаг анги (хувиар)



Нийт 391 багш асуулгад хариулсан байна. Ажилтны ярилцлагад 21 аймгийн сонгогдсон 27 сумын дотуур байрны ажилтан хамрагдав. Үүнд ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тогооч, жижүүр, хоол зүйч зэрэг хүмүүстэй ярилцлага хийсэн.

Судалгааны үр дүнг ярилцлагад хамрагдсан 70 хүүхдийн үр дүнд тулгуурлан гаргалаа.

### 2.1.2. Дотуур байрны “хүүхэд хөгжлийн өрөө” ба “номын сан”-гийн үйлчилгээ

Хүүхдийн бие махбод, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч буй ахиц, өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх ба энэ хүрээнд хүүхэд хэд хэдэн эрхийг эдлэхийн дотор чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээх авах амралт чөлөөт цагаараа тоглож наадах, хүсэл сонирхлын дагуу уралдаан тэмцээн, хөгжлийн хөтөлбөр, дугуйлан секц, бүлэг, клубт хамрагдах, хөгжлийн төв, ордонд суралцах зэргээр эдэлнэ гэж Хүүхдийн эрхийн тухай хуульд зүйлчлэн заажээ.

Судалгааны үр дүнд, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ихэнх нь буюу 63 хувь нь 1-4 өдөр үйлчлүүлдэг нь харагдлаа.


Хүснэгт 12. “Хүүхэд хөгжлийн өрөө”-өөр үйлчлүүлэх давтамж

Давтамж	Тоо	Хувь
1-2 удаа	2590	35.1
3-4 удаа	2079	28.2
5 ба түүнээс дээш удаа	1919	26.0
огт ордоггүй	353	4.8
хүүхэд хөгжлийн өрөөгүй	433	5.9

Хүүхэд хөгжлийн өрөөнд ихэвчлэн хичээлээ давтах, ном унших, тоглох зорилгоор ордог ч интернэтэд орох боломж тэр бүр байдаггүй юм байна.

Багш нарын хариултаас харахад хүүхдүүд голдуу хичээл давтах гэж ордог гэж 26 хувь нь, тоглох гэж ордог гэж 16 хувь нь хариулснаас харахад хүүхдүүдийн хариулттай нийцэхүйц байна. .


Зураг 5. "Хүүхэд хөгжлийн өрөө" - суралцагчдын хийдэг үйл (Хувиар)



"Хүүхэд хөгжлийн өрөө"-өөр бүх хүүхэд үйлчлүүлэх боломжтой юу гэсэн асуултад судалгаанд хамрагдсан багш нарын ойролцоогоор 58 хувь нь боломжтой гэсэн байна. Харин өрөөний боломж, ширээ сандлын тооноос хамаараад 30 гаруй хувь нь цөөн тооны хүүхдэд л үйлчлэх боломжтой гэж хариулснаас харахад үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатайг илэрхийлж байна.

Дотуур байрны номын санд ихэвчлэн юу хийдэг вэ? гэсэн асуултад ихэнх хүүхэд ном уншдаг, хичээлээ давтдаг гэж хариулсан бол 17 хувь нь номын сангүй гэдэг хариултыг өгсөн байна (зураг 6). Харин багш нарын 33 хувь нь дотуур байранд номын сангүй гэж зөрүүтэй хариулт өгсөн байна. Энд хүүхдүүд "Хүүхэд хөгжлийн өрөө"-ний номын буланг номын сантай гэж хариулсан байх магадлалтай юм.

Зураг 6. Номын санд хийх үйл ажиллагаа (Хувиар)



Судалгаанд оролцсон хүүхдүүдийн тодорхой хэсэг нь номын сан, хүүхэд хөгжлийн өрөөнд ном унших, хичээл давтдаг гэсэн хариултыг өгсөн боловч хичээлээ ихэвчлэн өөрийн амьдардаг тасагтаа хийдэг аж. Жишээлбэл, хүүхэд хөгжлийн өрөөнд 20 хувь нь, номын санд 16 хувь нь л хичээл, даалгавраа хийдэг гэж хариулжээ.

Номын сангүй гэсэн хүүхдүүдийн хариулт нь аймгийн төв, сумын төвийн байршлаас хамаарсан ялгаатай хариулт алга байна.

Мөн хичээлээ дотуур байрны багш, жижүүрийн өрөөнд, хоолны заланд хийх, сургууль дээрээ ангидаа очиж хийдэг гэсэн хариултыг цөөнгүй хүүхэд өгсөн байна. Ялангуяа, хоолны танхим том учраас хичээл хийх боломжтой байдаг, багш, жижүүрийн өрөө чимээ багатай байдаг учраас хичээл хийдэг хандлага ажиглагдлаа. Зарим дотуур байранд хичээл хийхэд тусдаа өрөө байдаг нь нэг сайн туршлага гэж харахаар байна.

Энэ талаар багш нараас тодруулахад, 43 хувь нь өөрийн амьдардаг тасагтаа хийдэг гэсэн хариултыг өгсөн байна.

Хүснэгт 13. Гэрийн даалгавраа хийдэг газар (Хувиар, Тоогоор)

Хичээл давтдаг газар	Хувь	Хариултын давтамж
Амьдардаг өрөөндөө	60.5	4461.3
Хүүхэд хөгжлийн өрөөнд	20.3	1496.9
Номын санд	16.1	1187.2
Хичээл, давтлагын өрөөнд	1.2	88.5
Хоолны заланд	0.5	38.3
Коридорт	0.6	44.2
Байрны багш, жижүүрийн өрөөнд	0.4	28.8
Сургууль дээр, ангидаа	0.4	28.8

Дотуур байр нь хичээл хийхэд чимээ шуугиан багатай байж чаддаг эсэхэд 50 хувь нь чаддаг, 40 хувь нь хааяа гэж хариулжээ.

Хүснэгт 14. Дотуур байрандаа чимээ шуугиангүй нөхцөлд хичээлээ хийдэг байдал Хувиар, Тоогоор)

Хариултын шкал	Хариултын давтамж	Хувь
Ихэвчлэн	3578	48.5
Хааяа	3055	41.4
Үгүй	741	10.0

### 2.1.3 Дотуур байрны сургалт хөгжлийн үйл ажиллагаа

Дотуур байранд хүүхэд хөгжүүлэх төлөвлөгөө тэр бүр байхгүй байна. Хүүхэд хөгжлийн төлөвлөгөөтэй болох, түүнийг хүүхдүүдэд таниулах үйл ажиллагааг хэвшүүлэх хэрэгцээтэй байна.

Дотуур байранд ямар сургалт зөвлөгөөнд хамрагддаг вэ гэсэн асуултад хүүхдүүд шүд, гараа угаах, дасгал хөдөлгөөн хийх, байгаль орчноо хамгаалах зэрэг эрүүл ахуйн болон байгаль орчинтойгоо харилцах талаарх сургалт зөвлөгөө ихэнхдээ явагддаг гэж хариулсан бол 6 хувь нь сургалт зөвлөгөө явагддаггүй гэж хариулжээ. Мөн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, авьяасаа нээн хөгжүүлэх, харилцаа, сэтгэлийн хөдөлгөөнөө зохицуулах ур чадварын сургалт зөвлөгөөг эрчимжүүлэх нь чухал байна.

Хүснэгт 15. Дотуур байранд зохиогддог сургалт зөвлөгөөний чиглэл (Хувиар)

Зохиогддог сургалт зөвлөгөөний төрөл	Хувь
Авьяас чадвараа нээн хөгжүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох	21.0
Харилцаа, сэтгэлийн хөдөлгөөний чадвар олгох	23.2
Эрүүл ахуйн болон дасгал хөдөлгөөн хийх, байгаль орчинтой харилцах чадвар олгох	60.6
Сургалт зөвлөгөө зохиогддоггүй	5.6



Би цаашдаа цэргийн хүн болно гэж боддог. Дотуур байранд ирээдүйн ажил мэргэжилтэй холбоотой ямар нэгэн үйл ажиллагаа явагддаггүй. Багшийн ажлын ачаалал маш их учраас төдийлөн энэ талын ажил зохион байгуулж амждаггүй байх гэж бодож байна.

... аймгийн дотуур байрны 15 настай хүүхдийн ярилцлагаас

Дотуур байранд хүүхдийн эрх, хамгааллын талаар ямар сургалтууд явдаг вэ гэсэн асуултад хүүхдийн эрх, үүрэг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үе тэнгийнхэнтэйгээ зөв харилцах талаар сургалт явагддаг гэжээ. Харин ямар нэгэн сургалт огт явагддаггүй гэж 399 хүүхэд хариулсан байна.

Компьютер тоглоомонд донтохоос болон цахим дээрэлхэлтээс өөрийгөө, найз нөхдийгөө хамгаалах талаарх сургалт, зөвлөгөөний ажлыг эрчимжүүлэх хэрэгцээтэй нь харагдлаа.

Зураг 7. Дотуур байранд "хүүхэд хамгаалал" чиглэлээр явагддаг сургалт, зөвлөгөө (Хувиар, Тоогоор)



Ганцаарчилсан ярилцлагаар дотуур байранд хүүхдэд зориулсан олон төрлийн үйл ажиллагаа явагддаг гэж хөдөө орон нутгийн дотуур байрны хүүхдүүд ярьсан байна.

Үүнд хамгийн их давталттай нь спортын уралдаан тэмцээн, АХА тэмцээн болдог гэжээ. Цөөн тооны хүүхдүүд дотуур байранд урлагийн наадам болдгийг дурдсан байна.

Жил болгон АХА явагдана. Танилцах үйл ажиллагаа явагддаг. Энд олон хүүхэд оролцдог. АХА -д зөвхөн манай байрныхан ордог. Би бас оролцдог.

Сар болгон хүмүүжлийн ажил болдог. Хүмүүжлийн ажлаар бие биетэйгээ танилцах, өөрийгөө нээх талаар ордог. Гар бөмбөгийн тэмцээн болдог. Бүгдээрээ оролцдог. Би хоёуланд нь идэвхтэй оролцдог.

... аймгийн ... сумын 14, 16 настай хүүхдийн ярилцлагаас

Дотуур байраанд тэмцээн уралдаан жилд 1-2 удаа зохион байгуулагддаг, энэ нь голдуу сагс, волейбол, шатрын тэмцээн байдаг. Хүүхдүүд энд ихэвчлэн идэвхтэй оролцдог. Би ч идэвхтэй оролцдог. Номын сан гэж манай дотуур байранд байдаггүй, сургуулийн номын сангаар үйлчлүүлнэ. Хүүхэд хөгжлийн өрөөнд би хичээлээ давтдаг.

Улаанбаатар хотын .... дүүргийн дотуур байрны 13 настай хүүхэдтэй хийсэн ярилцлагаас

Дотуур байрны багш нарын хариултаас үзэхэд, 47 хувь нь хүүхдүүдийн дунд уралдаан тэмцээн, 41 хувь нь амьдралын зөв дадал хэвшил олгох сургалт зөвлөгөө явуулдаг гэжээ.

Үйлчилгээ, зохиогдож байгаа үйл ажиллагаанд дараах тогтмол явагддаг ажлуудыг нэрлэсэн байна. Үүнд: урлагийн болон спортын арга хэмжээнүүд, зарим төрлийн дугуйлан, секц ажиллуулдаг, АХА тэмцээн, зааланд тоглуулах гэх мэт.

Дотуур байранд зохиогдож болох үйл ажиллагаануудын дараах санааг гаргасан байна. Үүнд:

- Амьдрах чадварт сургах үйл ажиллагаанууд: ногоо тарих, мужааны үйл, оёдол хатгамал, анхны тусламж үзүүлэх, цахим орчноос хөндийрүүлэх,
- Төрөл бүрийн сургалтууд: хүүхэд хөгжил, төлөвшлийн талаар, муу зуршлыг арилгах, үүрэг хариуцлагын талаар,
- Төрөл бүрийн тэмцээн уралдаан, ялангуяа хүүхэд хөгжүүлэх чиглэлийн
- Ном унших уралдаан – урамшуулалтай
- Ямар нэг үйлчилгээ, үйл ажиллагаа нь тасралтгүй, тогтмол явагдаж байгаасай.

Эдгээр үйл ажиллагаа, сургалтуудыг зөвхөн хүүхдүүдийн дунд төдийгүй ажилтан, ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагчдын дунд тогтмол, дор хаяж улиралд нэг удаа зохион байгуулж байх, сэтгэл зүйчтэй байх талаар дурдсанаас гадна дотуур байрны үйлчилгээ, тэр дундаа орчны талаар саналуудыг нийтлэг хэлсэн байгаагаас: орчны тохижилт тав тухтай байх, дотроо 00-той, халуун устай байх, сантехникийн асуудлуудыг шийдэх, төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгуулахад урамшуулалгүй бол оролцоо бага байдаг, санхүүгийн асуудал тулгамдаж байна, дотуур байрны хоолны мөнгө санхүү хангалтгүй гэх мэт хариуцсан ажил үүрэг, мэргэжлийнхээ дагуу саналуудыг илүүтэй өгсөн байна.

Дотуур байранд зохион байгуулагдаж байгаа ажлууд ер нь боломжийн, энэ байдлаараа цаашид явагдахад болно, аятайхан байдаг, нэмэлт санал байхгүй гэж зарим оролцогч хариулсан байна.

Дотуур байрны багш нар хүүхдүүдийн гэрийн даалгаврыг гүйцэтгэхэд тодорхой хэмжээний үүрэгтэй байна. Ялангуяа, бага ангийн суралцагчдын гэрийн даалгавараа хийхэд тусалцаа үзүүлдэг, харин дунд ахлах ангийнхны хувьд хичээл даалгавраа хийх нөхцөл боломжийг хангахад түлхүү анхаарч ажилладаг байна. Мөн дотуур байрны ахлах, дунд ангийн хүүхдүүд бага анги, дунд ангийн хүүхдүүдэд даалгавраа хийхэд нь тусалдаг дүр зураг харагдаж байна.

Заримдаа багшаас хичээл асуудаг, бодлого яаж бодохоо асуудаг. Ер нь бол дотуур байрны багш орчин нөхцөл бүрдүүлж өгнө. Том ангийнхан өөрсдөө л хийдэг. Гэхдээ том ангийнхан асуусан ч багш аль болохоор туслахыг их хичээдэг нь сайхан санагддаг.

Багш тусалдаг. Тоо бодуулж байна. Цээж бичиг хийлгэх, ойлгохгүй хичээлийг зааж өгдөг.

... аймгийн ... сумын 10, 11, 16 настай хүүхдийн ярилцлагаас

Би дотуур байрны багшаас даалгавраа хийх талаар асууж байгаагүй юм байна. Бага ангийн хүүхдүүдэд л хичээлийг нь зааж өгч байх шиг харагддаг. Би л хувьдаа байрны эгч нараасаа даалгавраа асуудаг.

*Улаанбаатар хотын .... дүүргийн дотуур байрны 13 настай хүүхэдтэй хийсэн ярилцлагаас*

#### **2.1.4 Дотуур байрны хүүхдийн бие даасан клуб, зөвлөлийн үйл ажиллагаа**

Дотуур байранд суралцагчийн зөвлөл, бие даасан клубууд ажилладаг ба тус зөвлөлийн гол үүрэг нь дотуур байрны дүрэм журмыг хэрэгжүүлэхэд хүүхдүүд болон багшид туслах чиг үүрэгтэй ажилладаг байна.

Бие даасан клубуудын хувьд, хүүхдүүдийн дунд төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгуулах чиг үүрэгтэй ажилладаг байна. Голдуу охидын клуб, хөвгүүдийн клуб, ном уншлагын клуб, эко клубууд үйл ажиллагаа явуулдаг аж. Харин бүжиг, дууны клубууд цөөн тооны дотуур байруудад байна. Зөвлөл, клубын гишүүд нь ихэвчлэн ахлах ангийн хүүхдүүдээс бүрддэг байна.

Ах, эгч нар ордог клуб байдаг. Жишээлбэл, “Эко клуб”, “Номын анд” гэх мэт клуб гэх мэт, Сурагчийн зөвлөл байдаг. Сурагчийн зөвлөлийнхөн дүү нарт юм зааж өгдөг. Хичээлийг нь голдуу зааж өгнө.

Номын сангийн клуб гэсэн байх, хүүхдүүдээр ном уншуулдаг, номын сангаас ном авч, буцааж өгдөг. Хүүхдүүдээр ном уншуулах, ном бүртгэх үүрэгтэй. Сурагчдын зөвлөл байдаг. Би зөвлөлийн гишүүн. Хүүхдүүдээр ном уншуулах, ном бүртгэх, хүүхдүүдийг босгож гар нүүрийг нь угаалгах эрт унтуулах гэх мэт дүрэм журам сахиулах гол үүрэгтэй.

*... аймгийн, ... сумын ЕБС-ийн 10, 11 настай хүүхдийн ярилцлагаас*

Манай дотуур байранд хүүхдэд зориулсан клуб, секц дугуйлан ер нь байдаггүй юм байна. Ганцхан сурагчдын зөвлөл гэж байна. Энэ зөвлөл нь байранд дүрэм журам сахиулах, ер нь эмх цэгцтэй байлгах л үүрэгтэй дээ. Хүүхэд хөгжлийн төлөвлөгөө гэж зүйл сонсоогүй юм байна. Цаашид гар урлал, оёдлын дугуйлан хичээллээсэй гэж хүсэж байна.

*Улаанбаатар хотын .... дүүргийн дотуур байрны 13 настай хүүхэдтэй хийсэн ярилцлагаас*

#### **2.1.5 Дотуур байрны секц, дугуйлангийн үйл ажиллагаа, зохиогддог уралдаан тэмцээн**

Судалгаанд оролцсон хүүхдүүдийн 53 хувь нь секц дугуйлан хичээллэдэггүй гэсэн хариултыг өгсөн бол багш нарын 62 хувь нь секц дугуйлан байдаг гэсэн хариултыг өгсөн байна. Иймд 50 хувьд нь секц дугуйлан хичээллэдэг юм байна гэж дүгнэхүйц байна.

Дотуур байранд зохиогддог уралдаан тэмцээнд хүүхдүүдийн 53 хувь нь байнга идэвхтэй оролцдог гэж хариулсан бол ямар нэгэн тэмцээн уралдаан зохиогддоггүй гэж цөөн тооны хүүхдүүд хариулжээ.

Ерөнхийдөө дотуур байранд байрны хүүхдүүдийн дунд тэмцээн уралдаанууд зохиогдож хэвшжээ гэж хэлж болохуйц дүр зураг харагдлаа.

Хүснэгт 16. Дотуур байранд зохиогддог үйл ажиллагаанд хүүхдийн оролцоо (Хувиар)

Оролцоо	Хариултын давтамж	Хувь
Байнга оролцдог	3894	52.8
Заримдаа оролцдог	2591	35.1
Зохиогддог боловч оролцдоггүй	446	6.0
Тэмцээн, уралдаан зохиодоггүй	443	6.0

Дотуур байрандаа хүүхдүүд өдөр тутамдаа дасгал хөдөлгөөн хийх нь тийм ч хангалттай биш, ихэнхдээ дулааны улиралд гадаа талбайд дасгал хөдөлгөөн хийдэг гэсэн дүр зураг харагдлаа.

Дасгал хөдөлгөөн хийх хэрэгтэй гэсэн ойлголтыг хүүхдүүдэд өгдөг боловч өдөр тутамдаа хийж амьдралын хэв маяг болгох нь дутагдалтай байна. Цөөн тооны дотуур байр хэвшил болгосон, цөөн тооны хүүхдүүд өөрсдөө сайн дураараа тасагтаа дасгал хийдэг, ер нь голдуу охид хийдэг байдал харагдлаа.

Дотуур байранд хүүхдүүдийн бие бялдрыг хөгжүүлэх материаллаг орчин нөхцөл, стандартыг бий болгох шаардлагатай байна.

Гадаа дулаахан байхад бид нар өглөө босоод жижиг Бамбар уулыг тойроод гүйж байсан. Хүйтэнд хийхээ больсон.

... аймаг, ... сум, 10 настай хүүхдийн ярилцлагаас

Би унтахын өмнө өөрөө дасгал хийдэг. Гэхдээ албан ёсоор бүх хүүхэд хийдэггүй.

... аймгийн ... сум, 13 настай хүүхдийн ярилцлагаас

Дасгал хийдэг. Манайх фитнесийн өрөөтэй тул тэндээ орж дасгал хийдэг. Сар болгон байрны эмч хүүхдүүдийн жинг үзээд илүүдэл жинтэй хүүхдүүдийг албан ёсоор фитнесийн өрөөнд дасгал хийхийг зөвлөнө. Тэнд тусдаа мэргэжлийн багш байдаг нь гоё санагддаг.

... аймгийн ... сум, хандсан дотуур байрны 11 настай хүүхдийн ярилцлагаас

Цаашид дотуур байранд ямар үйл ажиллагаа зохиогддог байгаасай гэж хүсэж байна гэсэн асуултад хүүхдүүд бүжиг, уран зураг, ярих чадвар, англи хэлний, гар урлал, хөгжмийн, бусадтай зөв харилцах чадвар, төрөл бүрийн спортын секц дугуйлан хичээллүүлэх талаар саналаа хэлжээ.

Том болж байгаа учраас хүнтэй зөв харилцахад хэрэгтэй “ярих чадвар” -ыг сайжруулах дугуйлан хичээллэвэл илүү үр дүнтэй байх гэж бодож байна.

.. аймаг, ... сумын ЕБС-ийн дотуур байрны 14 настай хүүхэдтэй хийсэн ярилцлагаас

Ажил, мэргэжилтэй холбоотой сургалт, өдөрлөг зохион байгуулах, алдартай хүмүүстэй уулзах гэх мэт ажил зохиогдвол сонирхолтой байна.

... аймгийн ... сум, дотуур байрны 15 настай хүүхдийн ярилцлагаас

Хүүхдийн эрүүл мэндэд хэрэгтэй дасгал хөдөлгөөн хийлгэх ажил хэрэгтэй. Хүүхдүүд утсанд хамаг анхаарлаа хандуулна.

Одооны хүүхдүүдийн харилцаа сөрөг талтай. Гэр бүлийн нөхцөл байдлаас болоод янз бүрийн ааштай хүүхдүүд байдаг. Энэ тал руу хүүхэд рүү хандсан ажил хийж харагдахгүй байна.

Улаанбаатар хотын дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас

Хоёр багштайгаа л хамтарч ойр ажилладаг. Хүүхдийн хичээлийн хоцрогдолд санаа тавьж ярилцдаг. Ямар нэг үйл ажиллагаа зохион байгуулахаараа бид нар тойрч сууж байгаад жилийн төлөвлөгөө гаргаад, үйл ажиллагаа, сургалт зохион байгуулдаг. Хүүхдүүдтэйгээ ярилцдаг.

*Аймгийн дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулахын тулд хүүхдүүд дараах зүйлийг санал болгож байна.

- Дотуур байрыг номын сантай болгох
- Номын санд ном унших боломжийг сайжруулах, ширээ сандал, номын фондыг нэмэгдүүлэх
- Хүүхэд хөгжлийн өрөөнд хөгжих боломжтой байх, шатар даам, хүүхэд хөгжүүлэх тоглоом дутагдалтай, хүүхдүүд зөвхөн даалгавраа хийх гэж л ордог
- Дотуур байр тасагт сандал ширээ хүрэлцээ муутай, сандал нь цөөн, эвдэрхий байдаг тул үүнийг сайжруулах
- Дотуур байрны хүүхдүүд бассейн, фитнессээр хичээллэх боломжтой байх

### **Дүгнэлт**

Хүүхэд хөгжлийн өрөөнд хүүхдүүд 7 хоногт 1-3 удаа орж цагийг өнгөрөөдөг байна. 433 хүүхэд буюу судалгаанд оролцсон хүүхдүүдийн 5 хувь нь хүүхэд хөгжлийн өрөөгүй тул тухайн үйлчилгээг авч чаддагүй байна. Харин номын сангүй гэж 1259 хүүхэд хариулснаас хувиар аваад үзэхэд аймгийн төвийн хүүхдүүд тухайн хариултыг илүү өгчээ.

Дотуур байрны хүүхэд хөгжлийн өрөө эсхүл номын санд ихэвчлэн ном унших хичээл давтах, даалгавраа хийх зорилгоор ордог ч ихэнхдээ гэрийн даалгавраа өөрийн амьдардаг тасагтаа, багшийн эсхүл жижүүрийн өрөөнд эсвэл хоолныхоо заланд хийдэг аж. Учир нь чимээ шуугиан багатай, том ширээтэй, сандалтай гэсэн шалтгааныг нэрлэсэн. Иймд хүүхэд хөгжлийн өрөө, номын сан дотуур байранд байлаа ч тэр бүр хүүхдийн хөгжих хэрэгцээг хангаж чадахгүй байна гэж дүгнэхүйц байна.

Дотуур байранд хүүхэд хөгжлийн төлөвлөгөө байхгүй, цөөн дотуур байранд байдаг хэдий ч хүүхдүүд тэр бүр мэддэггүй тал харагдлаа. Жилийн төлөвлөгөө байдаг эсэхийг асуухад хүүхдүүдийн 75 хувь нь сайн мэдэхгүй гэж хариулсан бөгөө багшийн өрөөнд байдаг, нэг удаа абидэнд танилцуулсан гэсэн хариултын 23 хувь нь өгсөн байна.

Дотуур байранд ихэвчлэн тэмцээн уралдаан, урлагийн үзлэг, эрүүл ахуй, амьдралын зөв дадал хэвшил олгох, хүүхдийн эрх үүрэгтэй холбоотой, мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, харилцааны ур чадвар олгох, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалтууд явагддаг байна.

Дотуур байранд ахлах ангийн хүүхдүүд голдуу гишүүнчлэл үүсгэдэг сурагчийн зөвлөл ажилладаг. Сурагчийн зөвлөлийн гол үүрэг нь дотуур байранд дүрэм журмыг сахиулах, хүүхдүүдийн хичээлийг давтуулах, багшид туслах гэх мэт үүргийг гүйцэтгэдэг.

Дотуур байранд хүүхдүүдийн дунд тодорхой чиглэлийн үйл ажиллагаа гүйцэтгэх чиг үүрэгтэй клубууд ажилладаг гэдгийг ярилцлага, асуулгын үед хүүхдүүд хэлсэн. Байгаль орчноо хамгаалах, амьдралын эрүүл ахуйн дадал хэвшүүлэх үйл ажиллагаагааны чиглэлтэй “Эко клуб”, ном унших дадлыг бий болгох зорилготой “Номын анд” клуб, охид хөвгүүдийн дунд төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгуулах үүрэгтэй охид,

хөвгүүдийн клуб ажиллаж хэвшсэн байна. Клубын гишүүд нь мөн ахлах ангийн хүүхдүүд байх нь олонтаа байна.

### **Санал, зөвлөмж**

- Цаашид хүүхэд хөгжлийн өрөө, номын санг тохижуулах, ялангуяа, сумын дотуур байрны хүүхэд хөгжлийн өрөө, номын санд хүүхдүүд хичээл давтах, ном унших боломжийг хангах, ширээ, сандлын тоог нэмэх тал дээр зайлшгүй анхаарах хэрэгцээтэй байна.
- Дотуур байранд хүүхдүүд тогтмол дасгал хөдөлгөөн хийж хэвших нь чухал байна. Охид хөвгүүдийн жигд оролцоог хангах тал дээр ажиллах шаардлага байна.
- Дотуур байрны хүүхдүүдэд зориулсан дугуйлан секцийн тоог дотоод хүний нөөц, боломжоо ашиглан идэвхжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, дотуур байранд хөгжим, урлагийн, харилцааны чадвар олгох сургалт, клубын үйл ажиллагааг удирдан чиглүүлэхэд багш, нийгмийн ажилтан сэтгэл зүйч, жижүүр байрны багш ажиллавал санхүүгийн урамшуулал, хөшүүргийг хэрхэн тусгах боломжтой талаар судлах хэрэгцээтэй байна.

## **2.2. Дотуур байран дахь хүүхэд хамгааллын нөхцөл байдал**

Дотуур байранд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хариу арга хэмжээ авахтай холбоотой хууль тогтоомжид заасан чиг үүргийг ЕБС-ийн багш, дотуур байрны багш, ажилтнууд түлхүү хэрэгжүүлнэ. Ийнхүү хэрэгжүүлэхдээ ангийн багш, сургуулийн сургалтын менежер, нийгмийн ажилтнууд түлхүү оролцоотой байдаг.

Дотуур байранд хүүхэд эцэг, эх асран хамгаалагчаас тусдаа орчинд амьдарч байгаа нь тэдний эрх, аюулгүй байдал зөрчигдөх эрсдэлийг бий болгодог тул сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, дотуур байрны багш ажилтнуудын чиг үүргийн үр дүнтэй хэрэгжилт, хамтын үйл ажиллагааны зохион байгуулалтыг шаарддаг.

Ялангуяа суралцагчийн эсэн мэнд амьдрах, хамгаалуулах эрхийн хэрэгжилт дотуур байрны хөгжил хамгааллын үндсэн цөм юм.

Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийг Хүүхдийн эрхийн тухай хуульд “... хүүхэд эрүүл өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх, эцэг эхийнхээ анхаарал халамжид байх, тусдаа үед тэдэнтэй байнгын харилцаатай байх, төрөөс эмнэлгийн тусламж, халамж, хамгааллын үйлчилгээ авах эрхтэй” болохыг заажээ.


Дотуур байрныхүүхэд хамгааллын үйлчилгээний нөхцөл байдлыг тодруулах үүднээс асуулга, ярилцлага, ажиглалтын аргаар мэдээллийг цуглуулсан.

### **2.2.1 Дотуур байрны үйлчилгээ**

#### **Дотуур байрны хоолны үйлчилгээ**

Дотуур байрныцай хоол таалагддаг эсэх, хоолны амт чанарын талаар санал хүсэлт авдаг эсэхийг тодруулахад, асуулгад оролцогчдын 70 хувь нь таалагддаг гэсэн хариултыг өгчээ. Бараг 30 хувь нь амт сул, нэр төрөл цөөн, хэмжээ бага байдаг гэсэн хариултыг өгсөн нь анхаарал хандуулах асуудал юм.


Зураг 8. Хүүхдийн хоолны сэтгэл ханамж (Хувиар, Тоогоор)



Дээрх зурагт бусад гэсэн хариултыг өгсөн 178 хүүхдийн хариултаас хоолны амт чанар маш хангалтгүй, ялангуяа шөлтэй хоол амтгүй байдаг, мах бага, хэт их байцаа ногоо өгдөг, тос ихтэй байдаг, заримдаа үс, хялгас гарч ирдэг, тогооч нарын ээлжээс хоолны амт чанар хамаардаг, заримдаа давс ихтэй, давс сул гэх мэт зүйлүүдийг дурджээ.

Дотуур байрны хоолны амт, чанарын талаар хүүхдүүдээс санал асуулга авдаг гэж 74 хувь нь, авдаггүй гэж 22 хувь нь хэлжээ.

Зураг 9. Хоолны чанарын талаар хүүхдүүдээс санал асуулга авдаг байдал (Хувиар, Тоогоор)



Бусад гэсэн хариултыг өгсөн 200 гаруй хүүхдийн хувьд сайн мэдэхгүй байна, байрныхаа багшид л хоолны чанар амтын талаар хэлдэг тул албан ёсоор санал асуулга өгдөггүй, тогооч өөрөө хүүхдүүдээс асуудаг, хааяа л асуулга авдаг гэх зэргээр хариулжээ.

Дотуур байрны тогооч хүүхдүүдэд аль болох шим тэжээлтэй хоолоор цаг тухайд нь үйлчлэхийг хичээдэг гэсэн хариултыг нийтлэг хэлсэн бөгөөд хоёроос дээш жил ажилласан багш, жижүүр, үйлчлэгчдийн хувьд хүүхдүүдээ таньж мэдээд, тэдний зан ааш, нөхцөл байдлыг сайн мэддэг болчихсон байдаг учраас харилцааны асуудал тэр болгон үүсээд байдаггүйг онцолжээ.

Хүүхдүүд хоолондоо цадсангүй гэнэ, ногоотой хоолонд муу байдаг. Хоолны меню шүүмжлэлтэй ханддаг. Нэг өдөр шөлтэй нэг өдөр хуурай хоол хийдэг ч хүүхдүүдэд хэр таалагдаж байгааг харж болдог. Хүүхдүүд ногоотой хоолонд сэтгэл дундуур байгаа нь санаа зовдог. Хоолны орцонд орох бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх хэрэгтэй санагддаг. Дотуур байранд олон жил амьдарсан хүүхдүүд ч ялгаагүй ногоонд муу хэвээрээ. 30 хувь нь ер нь ногоонд муу шүү.

Ногооны зутан тогоочтойгоо яриад оруулсан. Хүүхдүүд идэх нь тааруу. Тэгээд цайны газар ороод ширхгийн болохгүй хоол авч идээд байгаад би эмзэглэдэг. Сургуулийн байрны ойр чанар муутай хоол хийдэг цайны газар хүүхдийн хүнсний эрүүл ахуйд сөрөг нөлөөтэй гэж бодож байна. Мэргэжлийн хяналтын гүйцэтгэж байсан үүрэг саармагжсан тохиолдолд хяналт маш муу болсон. Оройд хүүхэд бэлэн гоймон авсан үед багш нар зөвлөгөө өгнө, хурааж авах ч тохиолдол байдаг.

*Улаанбаатар хотын сургуулийн дотуур байрны ажилтны ярилцлагаас*

Байрны жижүүр, үйлчлэгчийг зөвхөн тэдэнд үйлчлэх ёстой гэдэг хандлага зарим үед гаргадаг, тэр нь бас нэг бэрхшээл болдог талаар зарим оролцогч дурджээ.

Дотуур байртай холбоотой гомдол, санал ирдэггүй, одоогоор ирээгүй байна гэсэн хариултыг нийтлэг өгчээ. Зарим дотуур байрны хувьд хоолны амт чанар, орц, норм хүртээмжийн талаар санал хүсэлт ирдэг гэж тогооч нар хэлсэн бөгөөд энэ тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчидтай холбогдон, дотуур байранд ирсэн үед хоолны амталгаа хийлгэх, хоолны норм норматив, орц жорын талаар танилцуулах зэргээр хамтран ажилладаг байна. Мөн хүүхдүүд, ялангуяа ахлах ангийн хүүхдүүдийн хоолны хүртээмж хангалтгүй байна, өлсдөг гэсэн санал хүсэлт гарч байдаг талаар дурдсан.

Эцэг эх, асран хамгаалагчдын тухайд санал хүсэлтийн дэвтэр ажиллуулдаг. Эцэг, эхтэй уулзах уулзалтын өрөөтэй. Эцэг эхийн дунд группийн чатаар холбогддог. Хүүхдүүдийн дунд “Надад хэлэх үг байна” хайрцаг дотуур байранд байрлуулсан.

*Сумын сургуулийн дотуур байрны ажилтнуудтай хийсэн ярилцлагаас*

### Дотуур байрны ариун цэврийн өрөөний үйлчилгээ

Дотуур байранд усанд орох нөхцөл байдлын талаар тодруулахад асуулгад оролцогчдын 74 хувь нь халуун усанд ордог гэсэн хариултаас харахад, хөдөө орон нутгийн сургуулийн дотуур байрууд хүүхдийн усанд орох нөхцөлийг бүрдүүлж байгаа гэж харагдаж байна.

#### Хүснэгт 17. Хүүхдүүд дотуур байранд усанд ордог байдал (Хувиар, Тоогоор)

Хариултын шкал	Хариултын давтамж	Хувь
7 хоногт 1 удаа хуваарийн дагуу ордог	3069	41.6
Хүссэн үедээ усанд ордог	2359	32
Халуун усгүй	1371	18.6
Халуун усны өрөөтэй боловч усанд ордоггүй	575	7.8

Зарим дотуур байр нь халуун усны өрөөтэй боловч улирлын цаг уур, үйл ажиллагааны доголдолтой холбоотой ажилладаггүй тал байна.

Дотуур байрны угаалга, бие засах өрөөнд охид, хөвгүүдээрээ тусдаа ордог эсэхэд ихэнх нь тусдаа ялгаатай ордог гэж хариулжээ. Цөөнгүй хүүхдүүд буюу 18 хувь (1321 хүүхдийн хариулт) нь тусдаа ялгаатай ордоггүй гэсэн байна. Энд нөлөөлж байгаа нөхцөл байдал нь огт хүйсийн ялгаатай байдлаар үйлчлэх бие засах өрөөгүй, ялгаатай



орох тэмдэг тэмдэглээтэй боловч хүүхдүүд тэр бүр ялгаатай ордоггүй, мөн ялгасан тэмдэг огт байхгүй тул хүйсийн ялгаагүй бие засах өрөөнд ордог байдал харагдлаа (Хүснэгт 18).

Хүснэгт 18. Ариун цэврийн өрөө хүйсээр тусдаа эсэх, хүүхдийн хариулт (Хувиар, Тоогоор)

Хариултын шкал	Хариултын давтамж	Хувь
Дандаа тусдаа ордог	6053	82.09
Тусдаа биш, нэг байдаг	648	8.79
Тусдаа боловч ялгаатай ордоггүй	406	5.51
Ялгасан тэмдэг байдаггүй тул тусдаа ордоггүй	267	3.62

Дотуур байрны угаалга, 00-ын өрөөний цэвэрлэгээ үйлчилгээг сайн гэж үзсэн байна. Цөөнгүй хүүхэд бохир байдаг гэсэн хариултыг өгчээ. Ялангуяа, гадаа нойлтой тохиолдолд бохир, үнэртэй байдаг байна.

Бие зассаны дараа ихэнх хүүхдүүд угаадаг, энэ талаар байрны багш, заримдаа сургуулийн эмч хэлж зөвлөдөг гэсэн хариултыг дийлэнх нь өгчээ. Энэ талаар хэн нэгэн зөвлөж байгаагүй гэсэн хариултыг цөөнгүй сурагч өгсөн байна.

Бие засчихаад гараа угаах боломжтой, хичээлээ тараад хоолондоо ороход багш гараа угаагаарай гэдэг. Өмнө нь санитол ашигладаг байсан одоо больсон. Бие засах газарт саван байхгүй, хүүхдүүд өөрсдөө савангаа аваачиж угаадаг. Гэхдээ бие засах газар орох тоолондоо саван хэрэглэдэггүй. Заримдаа л ашигладаг. Гараа угаах ёстой гэдгийг багш заадаг.

.. аймаг, ... сумын ЕБС-ийн дотуур байрны 15 настай хүүхэдтэй хийсэн ярилцлагаас

Гал тогооноос ус аваад түмпэнд гараа угааж байгаа. Тийм учраас байнга угаагаад байдаггүй. Эмч гараа угаах талаар хэлж байсан байх, сайн санахгүй байна.

.. аймаг, ... сумын ЕБС-ийн дотуур байрны 14 настай хүүхэдтэй хийсэн ярилцлагаас


Гараа угаадаггүй. Дотуур байранд орж ирээд гараа угаах талаар сайн заалгаагүй. Судлаачийн зүгээс гараа байнга угааж хэвших нь хүүхдийн эрүүл ахуйн талаас их хэрэгтэй болохыг тайлбарлаж ярилцав.

.. аймаг, ... сумын ЕБС-ийн дотуур байрны 10 настай хүүхэдтэй хийсэн ярилцлагаас

Гараа тогтмол угаадаг. Сургуулийн эмч, одоо нөгөө нэг эрүүл ахуйч билүү нэг хүн тийм сэдвээр ярьж, сэдвээр ер нь орж ирээд хэлдэг. Ер нь сардаа нэг тийм сургалт хийж байна.

.. аймаг, ... сумын ЕБС-ийн дотуур байрны 13 настай хүүхэдтэй хийсэн ярилцлагаас

Зураг 10. Дотуур байрны ариун цэврийн өрөөний үйлчилгээний цэвэрлэгээ (Хувиар, Тоогоор)



Бохир байдаг гэж үзсэн хүүхдүүд 00-ийн өрөө муухай үнэртэй, бие засах газар гадаа байдаг тул бохир хэцүү байдаг, 00-ын цаасаа ихэнхдээ өөрсдөө гэрээсээ авчирдаг, угаалтуур бөглөрдөг, хааяадаа л саван, ариутгагч тавьсан байдаг, хурдан дуусдаг, гарын ариутгагч, 00-ын цаас ихэнхдээ тавьдаггүй зэргээр хариулжээ.

Байнга цэвэрхэн байна. Хааяа хөөсний баяр гээд хүүхдүүд цэвэрлэдэг. Бие засах газар таалагддаг, цэвэрлэдэг хэдий ч хүүхдүүд дандаа гадуур нь шээгээд байна. Яаж шээх талаар хэн нэгэн зааж өгөөгүй, хөдөө амьдардаг байсан болохоор ийм 00-д шээхэд их хэцүү байна. Өдөрт 3 удаа цэвэрлэдэг.

... аймгийн төвийн ЕБС-ийн дотуур байрны 10, 13 настай хүүхдийн ярилцлагаас

Гадаа нойлтой тул үнэр хэцүү, уг нь жижүүрүүд тогтмол цэвэрлэдэг ч бас хэцүү. Дотор нойлтой ч оруулдаггүй, Гадаа нойлтой тул бохир, ер нь дотроо л бие засах газартай болмоор байна.

... аймгийн ... сум, дотуур байрны 17 настай хүүхдийн ярилцлагаас


Бие засах газар, угаалгын өрөө голдуу цэвэрхэн байдаг. Үйлчлэгч болон жижүүр багш нар цэвэрлэдэг. Ариун цэврийн цаас шингэн саван тогтмол байдаг тул гараа дуртай үедээ угаах боломжтой.

Улаанбаттар хот, ... дүүргийн дотуур байрны хүүхэдтэй хийсэн ярилцлагаас

#### Дотуур байрны зөөлөн эдлэлийн хангалт, чанар


Дотуур байрны гудас, хөнжил нь дундаж түвшинд байгаа ба хуучин гудсыг шинэчлэх, зөөлөн тухтай болгох тал дээр анхаарах шаардлагатай байна.

Зураг 11. Дотуур байрны хөнжил гудасны чанар, хүүхдийн хариулт (Хувиар, Тоогоор)



Бусад гэсэн хариултыг өгсөн хүүхдүүд гэрээсээ гудас, хөнжил, цагаан хэрэглэлээ авчирдаг гэхээс гадна хариулж мэдэхгүй байна, өмнө нь хэрэглэж байсан даавуу өгдөг тул хуучирч муудсан, бохир байдаг гэсэн хариултыг нэлээд нь өгчээ.

Зураг 12. Дотуур байрны гудас, хөнжлийн чанар хүүхдийн хариулт (Хувиар, Тоогоор)



### Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

Дотуур байрны хүүхдүүд эрүүл мэндийн үзлэгт албан ёсоор хамрагддаг, дотуур байрны хүүхэд өвдсөн тохиолдолд байрны багш, жижүүрүүд сургуулийн эмчид хандах, орон нутгийн эмчид хандах гэх мэтээр арга хэмжээ авдаг байна.

Дотуур байранд тусдаа эмч байхгүй, сургуулийн эмч хариуцаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байна. Харин Сүхбаатар аймгийн төвд буюу Баруун-Урт сум 4 сургуулийн суралцагчдад зориулсан нэгдсэн дотуур байртай ба хүүхдийн тооноос хамааран бие даасан эмчтэй тул тусламж үйлчилгээ хүргэх нь давуу сайн туршлага харагдлаа.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хувьд, дотуур байрандаа амьдрах үедээ эрүүл мэндийн үзлэгт албан ёсоор жилд 1 удаа ордог гэж судалгаанд оролцогчдын 55 хувь, 2 удаа ордог гэж 20 хувь, 2-оос дээш удаа гэж 12 хувь нь хариулсан бол огт ордоггүй гэж цөөн тооны хүүхдүүд хариулжээ. Үүнээс харахад, дотуур байрны ихэнх хүүхдүүдийг албан ёсоор эрүүл мэндийн үзлэгт доод тал нь 1 удаа хамруулдаг дүр зураг ажиглагдлаа.

Зураг 13. Эрүүл мэндийн үзлэгт хамрагдалт, суралцагчдын хариулт (Хувиар, Тоогоор)

Хариултын шкал	Хариултын давтамж	Хувь
Жилд 1 удаа	4062	55.09
Жилд 2 удаа	1482	20.10
Жилд 2-оос дээш удаа	911	12.35
Ордоггүй	919	12.46

Дотуур байранд өвдөл хэнд ханддаг талаар тодруулахад дотуур байрны багшид хандана, дотуур байрны багш сургуулийн эмчийг дуудаж үзүүлдэг, зарим үед сурагчид сургуулийн эмчид өөрсдөө үзүүлдэг байна. Ихэнхдээ сургуулийн эмч эм бичиж өгөх, мөн өөрөөсөө эм өгдөг гэсэн хариултыг өглөө.

Жижүүр багшид хэлэхээр жижүүр багш сургуулийн эмчийг авчирч үзүүлнэ. Тэгээд аптекаас би эмээ авдаг.

*9 настай хүүхдийн ярилцлагаас*

Өвдөл шууд дотуур байрныбагшдаа ханддаг. Хурдан шуурхай үйлчилгээ авч чаддаг. Өмнө нь байрны эмч байсан одоо энэ жил байхгүй байгаа. Шөнө орой өвдөл жижүүрт хэлээд жижүүр багшид хэлдэг. Өвдөх нь гайгүй байвал багш өөрөө эм өгчихдөг.

*... аймгийн ... сумын 14 настай хүүхдийн ярилцлагаас*

Өвдөл жижүүр багш, байрны багшдаа хэлэхээр шууд эмнэлэг явуулдаг. Манай сургууль, дотуур байранд эмч байдаггүй. Заримдаа ээж, аав руу хэлнэ. Тэгэхээр ээж аав ирээд авдаг.

*Улаанбаатар хот, ... дүүргийн дотуур байрны хүүхдийн ярилцлагаас*

Бас хүүхдүүдийн бие тавгүйтэхэд ямар эм өгөх үү, эмч руу ярьж олж өгөхөөс эхлээд ажлууд гарнаа. Одоогоор эмчгүй байна. Одоо шинэ эмч ирэх сураг байна.

### Дотуур байрны цэвэрлэгээ, үйлчилгээ

Дотуур байрны цэвэрлэгээ үйлчилгээг байрны ээлжийн жижүүрүүд ихэвчлэн өдөр бүр хийдэг, тасгаа хүүхдүүд өөрсдөө цэвэрлэдэг байна.

Дотуур байрны цэвэрлэгээ үйлчилгээ хангалттай санагддаг. Өөрсдөө өрөөгөө цэвэрлэдэг. Асуудал тулгараад байдаггүй.

*... аймгийн ... сумын 11 настай хүүхдийн ярилцлагаас*

Цэвэрхэн. Ажлын өдөр цэвэрлэгч эгч цэвэрлэдэг. Амралтын өдрүүдэд бид нар цэвэрлэдэг. Хүндрэлтэй зүйл байхгүй. Өглөө орой коридороо угаадаг. Өглөө 06:30 гээд босдог. Өглөө жаахан орой 07:00 гээд ядаж сэрээж болдоггүй юм байхдаа гэж боддог.

*... аймгийн ... сумын 16 настай хүүхдийн ярилцлагаас*

Дотуур байрны цэвэрлэгээ үйлчилгээг үйлчлэгч эгч юм уу эсвэл дотуур байрны жижүүр хийдэг. Харин тасгаа бид нар өөрсдөө цэвэрлэдэг. Дотуур байранд цэвэрлэгээний хувьд асуудалгүй, ариун цэврийн цаас, шингэн саван тогтмол байдаг, бид гараа байнга угаах боломжтой.

*Улаанбаатар хотын .... дүүргийн дотуур байрны хүүхэдтэй хийсэн ярилцлагаас*

Хүүхдүүд дотор бие засах газартай болох, усанд орох боломжийг бүрдүүлэх, охидод зориулсан ариун цэврийн өрөө, хувцас солих өрөөтэй болмоор байна гэсэн байна.

### **Дүгнэлт**

Дотуур байрны хоолны амт, чанар стандартын дагуу шаардлага хангаж байна гэсэн хариултыг хүүхдүүд өгсөн хэдий ч цөөн тооны буюу судалгаанд оролцогчдын 20 хувь нь

нэр төрөл нь олон биш, хэмжээ нь бага, ялангуяа мах багатай, хэт их байцаа ногоо өгдөг, тогооч нарын ээлжээс хамаарч хоолны амт чанар харилцан адилгүй байдаг гэжээ.

Дотуур байрны хүүхдүүдээс хоолны амт чанарын талаар тогтмол санал асуулга авч хэвшсэн ба үүний дагуу хариу арга хэмжээ авдаг нь харагдлаа.

Дотуур байрны ариун цэврийн үйлчилгээний тухайд аймгийн дотуур байрууд халуун усанд орох боломжийг бүрдүүлэхийг хичээж ажиллаж байгаа байдал харагдлаа. Асуулгад оролцсон хүүхдүүдийн 70 гаруй хувь нь наад зах нь 7 хоногт 1 удаа усанд ордог гэсэн хариултыг өгсөн байна.

Бие засах өрөө нь охид, хөвгүүдээрээ ялгаатай байна. Цэвэрлэгээний хувьд дотуур байрны жижүүр, үйлчилгээний ажилтнууд өдөр бүр цэвэрлэдэг. Харин гадаа бие засах газартай тохиолдолд бохир, муухай үнэртэй байдаг гэсэн хариултыг ихэвчлэн өгчээ.

Хүүхдүүд саван, ариун цэврийн цаас зэргээ хувиасаа гаргадаг байна. Ихэнх дотуур байрны хувьд ариун цэврийн цаас, гар угаах шингэн, саванг ариун цэврийн өрөөнд тогтмол байрлуулдаггүй байна.

Хүүхдүүд бие зассаны дараа гараа угаах ойлголттой байгаа боловч тогтмол угаадаггүй дүр зураг ярилцлагаас харагдлаа.

Дотуур байрны зөөлөн эд хэрэглэлийн хувьд хүүхдүүд байранд орохдоо ихэнх нь өөрийн цагаан хэрэглэлээ авчирдаг, цөөн тооны хүүхэд хөнжил, гудастайгаа ирдэг ажээ.

Дотуур байрны хөнжил, гудсыг 60 гаруй хувь цэвэрхэн, зөөлөн гэж хариулсан бол 30 гаруй хувь нь хуучирсан солих шаардлагатай, нимгэн хатуу тухгүй гэсэн хариултыг өгсөн байна. Иймд гудас, хөнжил нь судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн талаас илүү хувийнх нь хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа байгаа ба хуучин гудсыг шинэчлэх, зөөлөн тухтай болгох тал дээр анхаарах шаардлагатай байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хувьд дотуур байрны хүүхдүүд эрүүл мэндийн үзлэгт жилд дунджаар 1-2 удаа албан ёсоор хамрагддаг, дотуур байрны хүүхэд өвдсөн тохиолдолд байрны багш, жижүүрүүд сургуулийн эмчид хандах, орон нутгийн эмчид хандах гэх мэтээр арга хэмжээ авдаг байна.

### **Санал, зөвлөмж**

- Цаашид дотуур байрны суралцагчдын хоолны амт чанар, хүртээмжийг дээшлүүлэх талаар судлах
- Дотуур байрны гудас, хөнжлийг шинэчлэх, цагаан хэрэглэлийг сайжруулах тал дээр арга хэмжээ авах
- Сумын дотуур байр ихэвчлэн гана бие засах газартай тул дотор болгох, хүүхэд бүр дотроо гараа угаах боломжтой байх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.
- Бие зассаны дараа гараа тогтмол савандаж угаах дадал зуршлыг бий болгоход сургуулийн эмч, нийгмийн ажилтан идэвхтэй ажиллах, ариун цэврийн өрөөнд тогтмол шингэн саван байрлуулах
- Бүх дотуур байрыг халуун устай болгох
- Дотуур байрны эмчтэй байх нөхцөл боломжийг судлах хэрэгцээ харагдлаа.

### **2.2.2 Дотуур байрны хүүхдийн хамгаалуулах үйлчилгээ**

МУ-ын БШУЯ-ны сайдын 2022 оны А/453 тоот “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”-аар хүүхдийг үл хайхрах

байдал, сэтгэл санааны хүчирхийлэл, үе тэнгийнхний дарамт, бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, эрсдэлт нөхцөл байдлаас хамгаалж, хүүхдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна гэж заасан байдаг. Мөн БШУЯ-ны сайдын 2022 оны А/214 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд суралцагчийг үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааны чиглэл батлагдсан байдаг.

Хүүхэд хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрал зэргээс нийгмийн бүхий л орчинд хамгаалагдах, өөрт хамаарах алив асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох эрхтэй юм.

Дотуур байранд хүүхдийн хамгаалуулах үйлчилгээний хүрээнд бид дотуур байрны нөхцөл байдлын талаар суралцагчдаас мэдээлэл авдаг эсэх, дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, сэтгэл зүйн байдлын талаар тодруулахыг зорилоо.

Дотуур байрны хүүхдээс сэтгэл ханамжийн судалгаа авдаг эсэх тухайд тодруулахад, 66 хувь нь жил бүр авдаг гэсэн хариултыг өгсөн байна. 23 хувь нь жил бүр тогтмол авдаггүй ч заримдаа авдаг гэсэн хариултыг өгчээ.

Үүнээс харахад, дотуур байрны хүүхдээс үйлчилгээний сэтгэл ханамжийн талаар судалгаа авдаг ч цаашид тогтмолжуулж судалгааны үр дүнгийн талаар хариу арга хэмжээ авдаг байх зохицуулалтыг хийж өгөх нь зүйтэй юм.

*Хүснэгт 19. Дотуур байрны хүүхдээс үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа авдаг эсэх (Хувиар, Тоогоор)*


Хариултын шкал	Хариултын давтамж	Хувь
Жил бүр байнга авдаг	4854	65.83
Жил бүр биш, заримдаа авдаг	1681	22.80
Судалгаа авдаггүй	839	11.38

**Дотуур байран дахь дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, сэтгэл санааны дарамт**

Дотуур байранд хүүхдийг дээрэлхэх, ялгаварлан гадуурхах, нэр хоч өгөх явдал нэлээд ажиглагддаг байна. Ялангуяа, бага ангийн хүүхдүүд бие биедээ нэр хоч өгөх, шоолох дунд ахлах ангийн хөвгүүд бие биеэ дээрэлхэх тохиолдол нэлээд байдаг байна. Энэ тохиолдолд дотуур байрны багшид ханддаг боловч тэр бүр үр дүнтэй хариу үйлдэл үзүүлж чаддаггүй байна.

Дотуур байранд **хүүхдүүд** дээрэлхэх, ялгаварлан гадуурхах, нэр хоч өгөх, цохих гэх мэт явдал чамд тохиолдож байсан талаар 57 хувь нь үгүй гэж хариулсан бол 6 хувь нь бусад хүүхдүүдийн зүгээс дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, сэтгэл санааны дарамттай нөхцөл байдал байнга байдаг гэж хариулжээ.

*Зураг 14. Дотуур байран дахь үе тэнгийнхний дээрэлхэлтийн талаарх хүүхдийн хариулт (Хувиар, Тоогоор)*



Ер нь дээрэлхэлт, ялгаварлах байдал их гардаггүй. Хүүхдүүд хоорондоо найрсаг харилцаатай. Бие биедээ зааж сургаад, бага ангийнхан бол хамт тоглодог.

..аймаг, .. сум 17 настай хүүхдийн ярилцлагаас

Бага байхад бие биеэ дээрэлхэх доромжлох тохиолдол гардаг байсан, тэгээд одоо одоо гайгүй болсон. Ер нь бага хүүхдүүдэд нэлээд байдаг, тоглож байгаа хүүхдээ цаашаа би чамтай тоглохгүй гээд хэлдэг тал бий. Жижүүр багшдаа заримдаа хэлдэг, багш болохгүй гэж хэлдэг.

Өө дээрэлхэх, шоолох зүйл гарна. Гэхдээ надад бол биш. Одоо энэ байрны хамгийн том нь болохоор надад бол нэг их мэдэгдэхгүй шүү дээ. Хүүхдүүдийг ажиглаж байхад бол гарна тэгээд л хараалын үгс хэлнэ. Тэгээд бие муутай, бялдрын хөгжил муутай хүүхдүүдээ дээрэлхэх ч юм уу тиймэрхүү юмнууд бол ер нь гарна. Ер нь харагдаж байдаг.

Хааяа гарна. Нэр хоч өгөх бол олон гарна. Алгадна, зодно. Камергүй газар очиж байгаад зоддог. Хэн нэгэнд хэлье гэхээр дахиад зодно.

... аймаг, .. сум 9 настай хүүхдийн ярилцлагаас

Заримдаа ах эгч нар намайг дээрэлхдэг миний нэр Марал-эрдэнэ гэдэг байхгүй юу, тэгээд намайг малаа гэж дууддаг.

... аймаг, .. сум 10 настай хүүхдийн ярилцлагаас

Дотуур байрны багш, ажилтнуудын зүгээс дээрэлхэх, ялгаварлан гадуурхах, нэр хоч, өгөх, цохих гэх мэт явдал тохиолдож байсан эсэхийг тодруулахад 80 гаруй хувь нь тийм асуудал байхгүй гэсэн бол 20 гаруй хувь нь байдаг гэжээ. Ялангуяа, дотуур байрны жижүүр болон ажилтнуудын зүгээс сөрөг харилцаа илүү гэж үзжээ.

*Хүснэгт 20. Дотуур байранд багш, ажилтнуудын зүгээс дарамт байдаг эсэхэд хүүхдийн хариулт (Хувиар, Тоогоор)*

Давтамж	Дотуур байрны багш	Дотуур байрны ажилтан
Байнга	225 (3.05%)	236 (3.20%)
Зарим үед	574 (7.78%)	1016 (13.78%)
Үгүй	6575 (89.16%)	6122 (83.02%)

Хүүхдүүдтэй хийсэн ярилцлагаас үзэхэд, дотуур байрны багш тэдэнтэй хүндэтгэлтэй эелдэг харилцдаг байна.

Дотуур байрны багш сайн харьцдаг. Бидэнд хичээл давтахад тусалдаг. Манай багш бидэнд хайртай. Багшийнхаа хувьд би өөрчлөх зүйл байхгүй, хүүхэдтэйгээ тулж ажилладаг. Бидэнд их санаа тавьдаг. Их мундаг багш байдаг. Өмнө нь байрны багшийг байхгүй үед өөр багш орлоход бидэнд хэцүү байсан. Дотуур байрны жижүүр эгч бидэнд байнга тусалдаг. Тогооч их амттай хоол хийж өгдөг. Өглөө замдаа таарангуут мэндэлдэг.

... аймаг, .... сум 17 настай хүүхдийн ярилцлагаас

Тогооч нар зүй бус харилцаатай, дөнгөж хичээл тараад орж ирэхэд хоолоо идээч, бүр хоолоо гуйлгаж иддэг гээд загнана. Охид тогоочийн туслах хийдэг, энэ үед их загнана. Тогооч нар харилцаандаа анхаармаар санагддаг.

... аймаг ... сумын 17 настай хүүхдийн ярилцлагаас

Хүндэтгэлтэй харьцдаг. Хааяадаа жаахан муухай ханддаг. Гэхдээ их ширүүн биш. Шаардлага биелүүлээгүйгээс болоод бидэнд муухай хандах тохиолдол бий.

аймаг ... сумын 14 настай хүүхдийн ярилцлагаас

Дотуур байрны хүүхдүүд ба ажилтан хоорондын харилцаа хандлага, харилцан ойлголцол, хүндлэлийн талаар хэр үнэлж байгаа, үүнтэй холбоотой тулгардаг асуудал

бэрхшээлийн талаар авч үзлээ. Дотуур байрны ажилтнуудын ихэнх нь эерэг хариултыг өгсөн байна. Тухайлбал, хүүхдүүдийн харилцаа хандлага маш сайн, биенээ хүндэлдэг, тавьсан шаардлагыг биелүүлдэг, харилцан ойлголцдог, ажилтны хооронд зөрчил гардаггүй, харилцаа хандлага хэвийн байдаг гэх мэт.

Харилцааны тал дээр сайн. Сайхан амарсан уу? Орой сайхан амраарай гэх мэтээр мэндэлж хүндлээд сурчихсан, давуу талтай. Харилцаа хандлага дээр асуудал байдаггүй, хүүхдүүд маань харилцаа асуудал гайгүй, харилцан ойлголцдог гэж боддог. Хүүхдүүд тавьсан шаардлагыг биелүүлэхдээ гайгүй, үл ойлголцол гарч байгаагүй, гардаггүй.

*....аймгийн ....Дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Эдгээр эерэг хариултаас гадна бас зарим нэг бэрхшээлтэй асуудлуудыг дурдаж байсны дотор ялангуяа, ахлах ангийн зарим хүүхдийн хувьд харилцааны зарим нэг асуудал гардаг гэдгийг дурдсан байна. Тухайлбал, байрны жижүүрийн шаардлагыг хүлээж авахдаа хойрго хандах, дургүйцэх, зарим тохиолдолд уурлах, нэг зүйлийг олон удаа хэлүүлэх зэрэг хандлага гаргадаг. Энэ тохиолдлуудад хүүхдүүдтэй ярилцах, дотоод журмын дагуу асуудлыг шийдвэрлэх, байрны багшид мэдэгдэх гэх мэтээр шийддэг талаар зарим ажилтан хэлсэн байна.

Хүүхдүүдийг заримдаа загнана, заримдаа аргадна. Өөр өөр орчинд өссөн болохоор харилцан адилгүй харьцаатай хүүхдүүд байдаг. Тэр болгонд нь тааруулж л харьцана.

*.. аймгийн ... сумын Дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Дотуур байрны багш хүүхэд хоорондын харилцаа гайгүй. Харин ажилтнуудтай харилцах байдал дунд зэрэг. Хүүхдүүд ажилтнуудыг ялгаж харьцах тохиолдол байна. Би өөрөө 6 наснаасаа л байранд амьдарч байсан. Тэр үед хүүхдүүд үнэхээр хүмүүжилтэй байсан. Одоо хүүхдүүд их өөр болсон.

*Улаанбаатар хотын дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Дотуур байрны ажилтан шаардлага тавих, эсвэл хүүхдийн ямар нэг хүсэлтийг хүлээн аваагүй тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчдад мэдэгдэх, гомдол санал өгөх зэрэг асуудал маш цөөн ч гэсэн гардаг гэдгийг зарим нь онцолсон байна.

Өсвөр насны хүүхдүүд их түргэн харилцаатай болчихсон. Шаардлага тавих, чанга дуугарахад хүүхэд хувьсхийгээд хүлээж авах талдаа муу болсон. Ялангуяа, 10-11 дүгээр ангийн эрэгтэй хүүхдүүдэд ажиглагддаг.

*... аймгийн ...Дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*



Хүүхдүүдээ байнга хараа хяналттай байлгахад амаргүй ээ. Хүүхдүүд гарч орох гээд их юм болно. Тэр бүрд арга эвийг нь олох болно. Хоносон жижүүр маргааш нь багшид тайлан тавьж, шаардлагатай бол багштай хамтран арга хэмжээ авна. Болохгүй бол нийгмийн ажилтан луу асуудал тавьна. Жишээ нь, ахлах ангийн хүүхэд тамхи татах тохиолдол гарсан. Хүүхэд электрон тамхи татсан 2-3 хүүхэд гарсан. Дотуур байрны багш, жижүүр, нийгмийн ажилтан, эцэг эх хамтарч арга хэмжээ авсан. Хүүхдийн хүмүүжил талд байрны багш мэргэжлийн түвшинд хүүхдэд нөлөөлж чадахаар байх хэрэгтэй. Хэт хүүхдийн аяар, зөөлөн байхаар хүүхдүүд чигээ олохгүй байна. Эрэгтэй хүүхдүүд байгаа байранд эрэгтэй багш ажиллах хэрэгтэй байна. Байрны багш тогтвортой байх, хүүхдээ таних хүүхдийн амьдрал ахуйг мэддэг байх хэрэгтэй. Хүүхдийн эцэг эхийн хүмүүжил сул байгаа тул хүүхэд энд ирээд хүмүүжилгүй байна. Эцэг эхтэй дотуур байрны багш хамтарч ажиллах чухал ч ихэнх нь малчин эцэг эх тул бэрхшээлтэй байдаг.

*Улаанбаатар хотын дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Дотуур байранд хүүхдүүд өөрсдийн эд зүйл, мөнгө төгрөгөө алдах явдал гарах нь цөөнгүй

байна. Зарим тохиолдолд багшдаа хэлэхэд багш хүүхдүүдээс асуух, камер шүүх гэх зэргээр арга хэмжээ авдаг тэр бүр эзэн нь олдоогүй талаар хүүхдүүд санаа бодлоо илэрхийллээ.

Надад ийм тохиолдол гарч байгаагүй. Хааяа гардаг юм шиг байна лээ. Байрны багшдаа хандах байх. Камертай болсон болохоор хулгай гарсан тохиолдолд шүүлгээд болох байх. Авсан байх гэсэн хүүхдээ сэжиглээд л уулздаг.

*аймаг ... сумын 11 настай хүүхдийн ярилцлагаас*

Төрсөн өдрийн бэлгээ алдаж байсан. Камер шүүж үзээд авсан хүүхдийг олсон.

*аймаг ... сумын 12 настай хүүхдийн ярилцлагаас*

Юм алга болж байсан тохиолдол байна. Заримдаа мөнгө алга болчихдог. Утас алга болсон тохиолдол байна. Зарим хүүхэд юмаа алдсан гэсэн яриа гардаг. Юмаа алга болгочихвол багшид хэлдэг, багш камер шүүгээд олдог тохиолдол байна.

*аймаг ... сумын 11 настай хүүхдийн ярилцлагаас*

Дотуур байранд хулгай мэр сэр гардаг. Хүүхдүүд ихэвчлэн бие биенийхээ мөнгийг заримдаа авчихдаг. Энэ үед жижүүр болон багшид хэлдэг. Олддог эсэхийг нь би сайн мэдэхгүй байна.

Би нэг удаа утасны кейсийн ард хийсэн мөнгөө алдаж байсан. Олоогүй.

*Улаанбаатар, хот, ... дүүргийн ЕБС-ийн дотуур байрны хүүхэдтэй хийсэн ярилцлагаас*

Дотуур байранд хүүхдийн эрхийн зөрчил үүссэн тохиолдолд ямар хариу арга хэмжээ авах талаар нэгдсэн зураглал байдаг эсэх, үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг талаарх асуултад хүүхдийн эрхийн зөрчил үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах зураглал тэр бүр байдаггүй талаар ярилцлагад оролцогчид нийтлэг хариулжээ. Ийм зураглал байгаа гэж зарим оролцогч хариулсан ч тодорхой хэлээгүй, бүрхэг байна. Мөн зарим оролцогч нь зөрчлийн эсрэг хариу арга хэмжээ авах зураглал гэж мэдэхгүй, тэр талаар ойлголцогч байна гэжээ.

Дотуур байранд хүүхдийн эрхийн зөрчил үүссэн тохиолдолд ямар хариу арга хэмжээ авах зураглал байгаа. Эрхийн зөрчил үүсэн тохиолдолд өөртэй нь ярилцаж, дараа нь аав ээж, багш нар, нийгмийн ажилтан, сэтгэлзүйч гээд шат дараалан 3 сургуулиараа хамтран ажилладаг.

... аймгийн ... сумын Дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас

Хүүхдийн эрхийн зөрчил үүсэх тохиолдол гарах нь цөөн байдаг талаар тэд нийтлэг хэлсэн бөгөөд хэрэв ямар нэг зөрчил гарвал, тухайлбал хүүхдүүд муудалцах, биенээ шоглох гэх асуудал мэр сэр гарвал хамгийн түрүүнд байрны багш, нийгмийн ажилтанд мэдэгдэж арга хэмжээ авч, шаардлагатай бол эцэг эх, АУБ ханддаг талаар оролцогчид хэлжээ. Мөн сургуулийн сэтгэл зүйчтэй тохиолдолд хамтран ажилладаг талаар дурдсан байна.

Дотуур байрнууд бүрэн камержуулсан байдаг тул зөрчил гарахаас сэргийлэхэд тустай тал дээр оролцогчид санал нэгтэй хариулсан байна.

Камержуулсан, эрэгтэй эмэгтэй тусдаа тул аюулгүй байдал хангагдсан гэж үздэг.

... аймгийн ... сумын Дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас

Хонохдоо орой 10 цагт охидын давхрыг цоожилдог. Өрөөнд камер байсныг өнгөрсөн жил хүүхдийн эрхтэй холбоотой байхгүй болгосон. Үүнтэй холбоотой үдэш орой болтол хүүхэд утсаа хараад унтахгүй байгааг тэр бүр хянаж чадахгүй сул талтай. Хүүхдүүд эцэг эхээрээ хэлүүлж утсаа авсан нь шөнө 2, 3 цаг хүртэл унтахгүй байх тохиолдол байна. Гэхдээ бид дотоод журам зөрчсөн хэмээн багшид мэдүүлж, хамтран зөвлөж сануулах арга хэмжээ авсан тохиолдол бий. Хүүхэд тэгээд гайгүй болчихдог.

Улаанбаатар хотын сургуулийн дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас

Дотуур байрны хүүхдүүд/тэдний эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс үйлчилгээний талаар ажилтнуудтай холбоотой ихэвчлэн гаргадаг хүсэлт, гомдол; үүнийг хэрхэн шийдвэрлэдэг талаарх асуултад ярилцлагад хамрагдагчид ихэнх нь гомдол, санал ирдэггүй, одоогоор ирээгүй байна гэсэн хариултыг өгчээ. Зарим тохиолдолд хүүхэд өвдөх, хүүхэд ямар нэг зөрчил гаргах (үеийнхэнтэйгээ муудалцах, мөнгө шаардлагатай болох гэх мэт) эцэг эхчүүдтэй холбогдож ярилцдаг. Шаардлагатай бол дуудаж уулздаг хэмээн дурдсан байна.

Эцэг эх, асран хамгаалагчдын тухайд санал хүсэлтийн дэвтэр ажиллуулдаг. Эцэг эхтэй уулзах уулзалтын өрөөтэй. Эцэг эхийн дунд групп чатаар холбогддог. Хүүхдүүдийн дунд “Надад хэлэх үг байна” хайрцаг дотуур байранд байрлуулсан.


Сумын сургуулийн дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас

Дотуур байрны ажилтны зүгээс хэлж, анхааруулж байсан зүйлийн дотор эцэг эх, асран хамгаалагчдын хариуцлага, ухамсар хангалтгүй байгаа, хүүхдэдээ тавих анхаарал халамж хангалтгүй, сургууль болон дотуур байрны ажилтнуудтай хамтран ажиллах тал дээр дутмаг байгаа зэрэг асуудлууд дурдагджээ.

#### Дотуур байран дахь хүүхдийн сэтгэл санааны байдал

Дотуур байрандаа баяр баясгалантай байж чаддаг уу гэсэн асуултын хариултаас харахад хүүхдүүдийн ихэнх нь тийм гэсэн хариултыг өгчээ.


Зураг 15. Дотуур байран дахь хүүхдийн сэтгэл санааны баяр баясгалантай байдал (Хувиар, Тоогоор)



Энд нөлөөлж байгаа хүчин зүйлийг нэгдүгээрт, найз нөхөдтэй хамт байх, хоёрдугаарт, дотуур байр тав тухтай, гуррав дугаарт, дотуур байранд олон зүйлийг сурч мэдэх боломжтой, дараагаар нь дотуур байрны багшийн харилцаа ханддлага сайн, дотуур байранд олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулагддаг гэдгийг дурджээ.

Дотуур байранд ганцаардаж уйтгарладаг эсэхэд 50-аас дээш хувь нь үгүй, 30 гаруй хувь нь заримдаа гэж хариулсан бол цөөнгүй хүүхдүүд уйтгарладаг гэсэн хариултыг өгсөн байна.

Зураг 16. Дотуур байран дахь хүүхдүүдийн сэтгэл санааны уйтгар гунигтай байдал (Хувиар, Тоогоор)



Сэтгэл санааны уйтгартай байдалд нөлөөлж байгаа хүчин зүйлийг юуны өмнө гэр бүлийнхнээсээ тусдаа байх гэж нэрлэсэн байна. Мөн үе тэнгийнхэн таагүй харилцах нь нөлөөлдөг гэжээ. Дараагийн хүчин зүйлийг дотуур байрны орчин нөхцөлийн тав тухгүй байдал гэжээ.

Цаашид дотуур байрандаа үргэлжлүүлж амьдрах хүсэлтэй эсэхийг нь сонирхоход, судалгаанд оролцсон хүүхдүүдийн 78 хувь нь үргэлжлүүлж амьдарна гэсэн бол дотуур байранд амьдрахгүй гэж 6 хувь нь, 16 хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг өгчээ.

### Дүгнэлт

Дотуур байранд үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт зарим талаар байдаг байна. Хүүхдүүд бие биеэ цохих, нэр хоч өгөх, шоолох, бага хүүхдүүдээ том ангийнхан нь дээрэлхэх байдал гардаг байна.

Дотуур байрны багштай харьцуулахад, ажилтан ба хүүхдүүд хооронд үл ойлголцол зөрчил гарах явдал байдаг байна. Ажилтнуудын ярилцлагаас дүгнэхэд дотуур байрны жижүүр, үйлчлэгч, тогооч нарын тавьсан шаардлагыг үл ойшоох, зарим талаар тогоочийн ажлын ачааллаас хамааран хүүхдүүдтэй үл ойлголцох асуудал үүсдэг байж болзошгүй байна. Тогооч өглөө 8 цагаас эхлээд орой 20 цаг хүртэл 1-2 хүн ээлжгүй ажиллах, заримдаа үдийн хоолыг давхар хариуцах зэрэг нь илүү их ачаалал үүсгэдэг, үүнээс шалтгаалж ахлах ангийн суралцагчдыг туслуулах зэрэг нь харилцааны янз бүрийн зөрчлийг үүсгэх магадлалтай байна.

Мөн хоолны амт чанар, хүртээмжийн талаар хүүхдүүд болон эцэг эх, асран хамгаалагчид нь санал гомдол гаргадаг зэрэг нь зарим үед харилцааны зөрчлийг үүсгэдэг байх талтай байна.

Дотуур байранд хүүхдүүд мөнгө, хувийн эд зүйлээ алдах тохиолдол бас цөөнгүй байна. Энэ тохиолдолд дотуур байрны багш, дотуур байрны жижүүртэй ханддаг ба ихэндээ багш камер шүүдэг байна.

Цаашид дотуур байрны хүүхэд хамгааллын эерэг соёлыг улам дэмжих төдийгүй үе тэнгийн дээрэлхэлт, бие биеэ сэтгэл санааны хувьд дарамтлах, таагүй харилцах явдлыг бууруулахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх нь үр дүнтэй байна.

Дотуур байрны ажилтнуудын харилцаа хандлагыг нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, чадварыг нь дэмжих ажлыг үе шаттай явуулахаас гадна тогоочийн ажлын ачааллыг зохистой болгох тал дээр судалгаа хийж, анхаарч ажиллах хэрэгцээтэй байна.

### **2.3 Дотуур байрны ажилтнуудын ажлын байран дахь хүүхэд хамгааллын асуудал**

Дотуур байрны жижүүр, тогооч, үйлчлэгчид сургуулийн хүүхэд хамгааллын бодлоготой танилцаж, хүлээн зөвшөөрснөө илэрхийлж гарын үсгээ зурдаг ба зарим дотуур байрны хувьд жилд, эсвэл улирал бүр танилцуулан гарын үсэг зуруулдаг гэж онцолжээ.

Гарын үсэг зурдаг. Хүүхдийн эрхийг дээгүүр тавьж ажилладаг. Эцэг эхээсээ хол учраас ойлгож л харьцдаг. Хурал зөвлөгөөн дээр хүүхдийн эрх хамгаалах тухай үргэлж хэлдэг. Сар бүр хүүхэд хамгааллын төлөвлөгөөг гаргадаг.

*...аймгийн төвийн сургуулийн дотуур байрны жижүүрүүдтэй хийсэн ярилцлагаас*

Мөн сургуулийн нийгмийн ажилтан танилцуулдаг, нийгмийн ажилтантай хамтран ажилладаг, сургуулийн дотоод дүрэм журамтай танилцуулдаг ч гарын үсэг зуруулаагүй гэж зарим оролцогчид дурдсан байна. Ёс зүйн гэрээ байгуулдаг, захиралтай гэрээ байгуулдаг, хүүхэд хамгааллын төлөвлөгөө гаргаж, бүх ажилтанд танилцуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулсан байгаа гэх мэт хэлжээ. Харин энэ талаар огт мэдэхгүй, гарын үсэг зуруулаагүй гэж хариулсан байдал ялангуяа тогооч, туслах тогоочдын хувьд байна.

Цөөн сургуулийн хувьд хүүхэд хамгааллын бодлогыг танилцуулж гарын үсэг зуруулдаггүй байдал харагдлаа.

Хүүхэд хамгааллын бодлоготой холбоотой бодлогын танилцуулга, хүүхэдтэй ажиллах талаар гарын үсэг зурсан юм байхгүй. Ажлын гэрээ эхлээд 6 сараар хийж, багш ажилчдын хурлаар орж сунгасан.

*Улаанбаатар хот, сургуулийн дотуур байрны үйлчлэгч, байрны жижүүртэй хийсэн ярилцлагаас*

Эцэг эхчүүдээс жижүүр, үйлчлэгч нартай холбоотой санал гомдол ирж байсан тохиолдол цөөн, гэхдээ ах дүүсээр нь, эсвэл хот айлаар нь нэг өрөөнд оруулж өгөх хүсэлт нэлээн ирдэг. Ажлын сайн талын зэрэгцээ бэрхшээлтэй асуудлууд, хүндрэл бэрхшээл гайгүй байдаг, хүүхдүүдтэй ажиллах гэгээлэг, сайхан байдаг, орчин нөхцөлийн талаар сургуулийн зүгээс анхаарч ажилладаг гэх зэргээр эерэг, таатай талуудыг нэрлэсэн байна.

Ажлын орчны хувьд асуудалгүй сайхан. Тогоочийн нормын хувцсыг сургууль тавьж өгдөг. Хүүхдүүдтэйгээ дотно, илэн далангүй ярилцаж байгаад ядарснаа мартдаг нь сайхан байдаг. Хамт олонтой байна гэдэг сайхан.

*Аймгийн төвийн сургуулийн дотуур байрны тогоочтой хийсэн ярилцлагаас*

Эдгээр сайн талуудыг дурдсаны зэрэгцээ ажлын нөхцөл, ажлын чиг үүрэгтэй шууд холбоотой бэрхшээл асуудлууд байдгийг хэлсэн байна. Тухайлбал, тогоочдын хувьд ажлын ачаалал ихтэй байдаг, өглөө маш эрт ирээд, шөнө орой болтол ажилладаг талаар голчлон дурдсан байна. Тухайлбал, туслах тогоочтой хамт хоёулхнаа ажилладаг бөгөөд угаагчийн орон тоо шаардлагатай байгаа талаар нэмж хэлсэн байна. Мөн дараах бэрхшээл, асуудлуудыг нэрлэжээ. Үүнд:

- Олон цагаар зогсоо ажилладаг
- Хүний нөөц дутмаг
- Олон хүүхдэд 1-2 тогооч үйлчилдэг нь ачаалал ихтэй байдаг, илүү цаг бараг тооцоолж өгдөггүй
- Ажлын өдөр, амралтын өдөр гэлтгүйгээр хүүхдүүд байгаа бол бид ажиллаж л байдаг. Харин илүү цагийн мөнгийг сайн тооцож өгдөг баймаар байна.
- 50 хүүхдэд 1 тогооч гэж заасан байдаг. Гал тогоо тусдаа үйлчлэгчтэй байсан боловч одоо байртай дундаа 1 үйлчлэгчтэй болсноор ачаалал ихэссэн. 6 өдөр ажиллаж байна. Өглөө 8-аас ирдэг.

Ярилцлагад хамрагдсан дотуур байрны жижүүрүүдийн хувьд дараах бэрхшээлүүдийг дурдсан:

- Гар утасны асуудал, шөнө дөл болтол гар утсаа үздэг. Утсыг нь тодорхой цагуудад хурааж аваад буцааж өгөх журам хэрэгжүүлсэн ч хүүхдүүд маш дургүй байдаг.
- Хүүхдүүд, ялангуяа ахлах ангийн охид, хөвгүүд дотуур байрнаас гарах, дэлгүүр орох, бусад сургуулийн хүүхдүүдтэй уулзах гэх мэтээр хараа хяналтаас гарчих гээд байдаг нь бидэнд бэрхшээлтэй байдаг.
- Хүүхдүүдэд шаардлага тавихаар хүүхдийн эрхийг зөрчлөө, сэтгэл зүйн дарамт учруулаа гэх зэргээр өмнөөс тайлбар тавьж, сургуулийн захиргаанд мэдэгддэг.
- Бие засах газрын асуудал нэн тулгамдаж байна. Байр дотроо бие засах газартай ч ялангуяа өвлийн цагт насос нь эвдрэх гэх зэргээр ажиллагаагүй болчихоод байдаг нь хүүхдүүдэд, тэр тусмаа бага ангийн хүүхдүүдэд том бэрхшээл үүсгэдэг. Үүнтэй холбоотой асуудлууд их гардаг.
- Үйлчлэгчгүй тохиолдолд ээлжийн жижүүрүүд хүүхдүүдтэй хамтран бүх цэвэрлэгээгээ хийдэг.
- Хүүхдүүдийн аюулгүй байдлыг бүрэн хангаж, эрүүл мэнд, цаашлаад амь насыг хариуцдаг ажил болохоор тэр нь жаахан хэцүү.
- Дотуур байранд эмч байхгүй нь бэрхшээлтэй. Хүүхэд өвдсөн тохиолдолд сумын эмчид ханддаг. Ялангуяа, амралтын өдрүүдэд хэцүү.
- Бид “байрны багш” гэсэн нэртэй ч хүүхдүүд жижүүр, үйлчлэгч гэсэн байдлаар хандах нь нийтлэг байдаг.
- Ялангуяа одоо цагт хүүхдүүдтэй харилцах зарим талаар бэрхшээлтэй гэдэг юм уу хэцүү байдаг учраас сургуульд нийгмийн ажилтнаас гадна сэтгэл зүйч ажиллуулах шаардлагатай байна.

..Тэр тусмаа хойд аав ээжтэй, ар гэрийн асуудалтай хүүхдүүд бүр их элэг барьдаг. Хүүхэд хамгааллын багийнхан ирэхээрээ хүүхдүүдэд та нар ийм ийм эрхтэй, ингэвэл та нарыг дарамталж байгаа гэсэн үг гээд тайлбарлачихдаг. Хүүхдүүдтэй яаж харилцах бас их чухал юм шиг байгаа юм. Судалгаа авахаараа дандаа л яаж дарамтлуулж байна, яаж дээрэлхүүлж байна гэж л асуугаад байдаг.

.. аймгийн ...сумын дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас

Хамгийн том бэрхшээл нь дотуур байрны эмч гэж байдаггүй нь хэцүү. Дуудлага өгөхөд дороо ирдэг ч тэр бүр ирэхгүй байх нь бий. Ийм үед өөрөө хүүхдийг аваад явдаг. Мөн бас нэг бэрхшээл нь бага ангийнхныг сургуулийн нөгөө байранд хүргэж өгөхөд машин зам гарах шаардлагатай байдаг. Энэ хооронд зөөх унаа хэрэгтэй байгаа. Хүүхдүүд хичээлдээ яарах зэрэгт хувцас хунараа дутуу өмсөх гэх мэтээр даарах, ханиад хүрэх, өвдөх эрсдэлтэй. Сургуулийн унаа уг нь байгаа гэхдээ их хүйтэнд л зөөдөг. Бага сургууль нэлээн хойшоо их хол байдаг учраас машин зам гардаг нь нэг бэрхшээл болдог.

... аймгийн ...сумын дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас

Мөн ярилцлагад хамрагдсан угаагч, үйлчлэгчдийн хувьд хүүхдүүдийг усанд оруулах, хувцсыг нь угаах тохиолдол их байдгийг дурдсаны зэрэгцээ эхэндээ зарим хүүхэд бие засах газрыг зохистой ашиглаж чаддаггүй, зааж зөвлөсний эцэст буюу 1-2 сарын дараа сурдаг гэсэн хариултыг өгчээ. Энэ нь ажлын ачаалал болдог байна.

*Дотуур байрны багштай хүүхэд, хөгжил, хамгааллын чиглэлээр хэрхэн хамтарч ажилладаг* талаар:

Хүүхэд хамгааллын чиглэлээр:

- Байрны багштайгаа хамтарч ажилладаг. Бүх л чиглэлээр хамтарч уялдаж ажилладаг.
- Байнгын хамтарч хүүхдийн аюулгүй байдалд анхаарал тавьдаг.
- Дотуур байрны хүүхдүүдийн эрх, хамгаалал хамтарсан багийн үйл ажиллагаа сэдэвт сургалтуудыг тогтмол явуулдаг
- Байрны багшийн саналыг сонсдог. Хүүхэд хамгааллын талаар “гараас гарт” гэх мэтээр хамтарч ажилладаг.
- Зарим тохиолдолд байрны багш нь жижүүр багшийн хамт хонож хүүхдийн аюулгүй байдалд санаа тавьдаг гэх мэт хариултуудыг нийтлэг өгсөн байна.
- Ажлаас буугаад явсан ч багштай холбоотой ажилладаг. Хүүхдүүдээ бүртгэж эцэг эх болон багштай холбогддог. Эхлээд багш, эцэг эх цаашлаад дараагийн шатны хүмүүстэй холбогддог.
- Хүүхдүүдийг ажиглаж хооллолт дээр нь анхаарч мэдээлдэг.
- Дотуур байр бүрэн камержсан байдаг нь хүүхдийн аюулгүй байдлыг хангахад сайн нөлөөтэй.

Ер нь хүүхэд хамгааллын чиглэлээр байрны багш, жижүүр, үйлчлэгч, тогооч зэрэг дотуур байрны ажилтан сургуулийн удирдлага, бусад багш, нийгмийн ажилтан, эцэг эх, асран хамгаалагчидтай байнга холбоотой ажиллаж, ажиглах, тэмдэглэх, зөвлөх, шаардлага тавих гэх мэтээр тасралтгүй ажилладаг нь ярилцлагын явцад тэмдэглэгдсэн байна.

Хүүхэд болгон дээр чинь судалгаа авна, тэгээд ингэж байна тэгж байна гээд бид хэд чинь тэгээд ар гэрийнхэнтэй нь холбогдоно, ангийн багштай нь холбогдоно, харилцан ярилцана, ер нь тэгээд л хүүхдүүдийнхээ өөрийн зан онцлогт тохируулаад л нэлээн судалгаа авч ажилладаг шүү дээ.

*...аймгийн дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Ажилтайгаа холбоотой сургалтад хамрагддаг эсэх, хамгийн сүүлд сургалтад хамрагдсан талаар ажлын байр болон ажлын чиг үүрэгтэй холбоотой сургалтад “зарим үед” хамрагддаг тэр дундаа эрүүл мэндийн төвөөс сургалт зохион байгуулдаг. Ариутгал, цэвэрлэгээний талаар сургалтууд ихэвчлэн явуулдаг очиж суудаг (жижүүр), ариутгалын бодисыг хэрхэн хэрэглэх талаар зааж өгдөг (хоол зүйч), тэгш хамруулах боловсрол, боловсролын багц хууль гэх мэт сургалтуудыг нэрлэсэн.

Сэтгэл зүйн сургалт явдаг. Ерөнхийдөө хүүхэд, хүүхдийн онцлогийн талаар. 2 өдөр “Сэтгэл хөдлөлөө удирдах чадвар” гэсэн сургалт явагдсан.

*...аймгийн дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Дотуур байрны тогооч, жижүүр багш нарын хувьд 7 хоног, 3 эсвэл 2 хоногийн сургалтад заримдаа оролцдог, ингэхдээ ажлаа зохицуулаад хамрагдахыг хичээдэг талаар дурдаж байсан. Эдгээр сургалтууд нь эрүүл зөв хооллолт – аймагийн БШУГ-аас зохион байгуулсан, эцэг эхтэй ажиллах, үдийн хоолтой холбоотой, хоолны орц норматив, аймаг сумдын дотуур байрны багш, жижүүрүүдийн хооронд туршлага солилцох аян, хүүхэдтэй харилцах, эрсдлээс хамгаалах сургалт, хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт гэх мэт.

Хүүхэд болгон дээр чинь судалгаа авна, тэгээд ингэж байна тэгж байна гээд бид хэд чинь тэгээд ар гэрийнхэнтэй нь холбогдоно, ангийн багштай нь холбогдоно, харилцан ярилцана, ер нь тэгээд л хүүхдүүдийнхээ өөрийн зан онцлогт тохируулаад л нэлээн судалгаа авч ажилладаг шүү дээ.

*...аймгийн дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Хүүхэд хамгаалал, тэгш хамруулах сургалтад хамруулсан. Сая 10 сард сургалтын хөтөлбөр, боловсролын тухай хууль танилцуулсан. Улиралд 1-2 удаа хамруулдаг. Сая 7 хоногт тогооч нар сургалтад хамрагдсан. Тогоочдын холбооноос зохион байгуулсан.

*...аймгийн төвийн сургуулийн дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Тогоочийн сургалтад хамрагддаг. Аймагт л хийдэг. Хотод сургалт нэг удаа ч зохион байгуулагдаад байдаггүй. Үйлчлэгч, жижүүр сургалтад хамрагдаагүй.

*... аймгийн ...сумын сургуулийн дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Зарим сургуулийн дотуур байрны ажилтан сургалтад хамрагдаж байсан гэхдээ олон жилийн өмнө, дотороо хааяа сургалт мэдээлэл авдаг (удирдлага, нийгмийн ажилтнууд) гэжээ.

Ямар нэг сургалтад хамрагдаж байгаагүй, сайн мэдэхгүй байна гэсэн хариултыг бас цөөнгүй өгсөн байгаа нь анхаарал татаж байна.

Тогооч нарын хувьд мэргэжлийн чиглэлийн сургалтад хамрагддаг талаараа тодорхой хэлж байсны дээр үр өгөөжтэй, ур чадвараа дээшлүүлэхэд хэрэгтэй байдаг талаар дурдаж байсан. Тогооч нарын холбооноос сургалтууд зохион байгуулагддаг талаар тэд хэлж байсны зэрэгцээ зарим нь ачаалал ихтэй байдаг тул оролцдоггүй гэсэн хариултыг өгсөн байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээрх сургалтад жил бүр хамрагддаг эсэх, хаанаас зохион байгуулдаг, үр дүнг нь хэрхэн үнэлж буйг тодруулхад энэ чиглэлийн сургалтын талаар зарим ажилтан бүрхэг ойлголттой байна.

Зарим аймаг, сумдын хувьд хүүхэд хамгаалалтай холбоотой сургалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулдаг гэсэн бөгөөд ихэвчлэн багш нар, нийгмийн ажилтнуудын дунд зохион байгуулагддаг талаар оролцогчид дурдсан байна. Тухайн сургалтад хамрагдсан багш нар сургуульдаа ирээд бусад ажилтнуудад мэдээлэл өгдөг тухай хэлсэн байна. Ярилцлагад хамрагдагчдын хариултаас үзэхэд дотуур байрны тогооч, үйлчлэгч, жижүүр буюу байрны багш нар нь энэ чиглэлийн сургалтад төдийлөн хамрагддаггүй, эсвэл тэднийг хамруулдаггүй талаар цөөнгүй тэмдэглэжээ. Иймээс энэ чиглэлийн сургалтад хамрагдах хэрэгцээ сонирхолтой байгаагаа зарим оролцогч илэрхийлжээ.

Хүүхэд хамгааллын талаар сургалтанд байрны багш, нийгмийн ажилтан, сумын байгууллагуудаас хүмүүс ирж зохион байгуулдаг. Сая намраас хойш 2-3 удаа болсон. Гэхдээ хүүхдүүдэд зориулсан.

*.. аймгийн ...сумын сургуулийн дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Бидэнд зориулсан сургалтыг нийгмийн ажилтан эрх зүйн чиглэлээр, хүүхэд хамгааллын чиглэлээр явдаг. Багш нараас гадна гаднаас хүмүүс ирж сургалт зохион байгуулдаг. Гаднаас ирсэн хүмүүсийн сургалт гайгүй болдог. Жижүүр хийж байх хугацаандаа хүүхэд хамгааллын сургалтад 2 л удаа сууж байсан. Одоо толгойд үлдсэн юм алга.

*Улаанбаатар хотын сургуулийн дотуур байрны жижүүртэй хийсэн ярилцлагаас*

Хариуцаж буй ажилтай холбогдуулан сургуулийн зүгээс өгдөг дэмжлэг, зөвлөгөөний талаарх саналыг ярилцлахад сургуулийн буюу удирдлагын зүгээс ажлын орчин нөхцөлийн талаар санаа тавьж анхаардаг, ажил хөнгөвчлөх зорилгоор тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж цахилгаан тоног төхөөрөмжөөр хангасан, төсөл хөтөлбөрийн хүрээнд гал тогоог тохижуулж өгсөн, бүрэн засвар хийсэн, хэрэгтэй, шаардлагатай зүйлийн талаар тогтмол асууж анхаардаг гэдэг хариулыг дотуур байрны тогооч, туслах тогоочид нийтлэг хариулсан байна.

Сургуулийн захирал өдөр бүр шахам дотуур байранд ирж, юу болж байна, юу болохгүй байгаа талаар тодруулж асуугаад, аль болох хурдан хугацаанд шийдвэрлэж өгөхийг хичээдэг, арга хэмжээ авдаг. Жишээлэхэд, саяхан ширээ сандлыг шинэчилсэн.

*...аймгийн дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Түүнчлэн сургуулийн удирдлагын зүгээс аюулгүй байдлын талаар зөвлөгөө, зөвлөмж өгдөг, санаа тавьдаг, боломжийн хэрээр тусалдаг, хэрэгтэй зүйлд дэмжлэг өгдөг, тал талаасаа дэмжээд ажиллахад болж байна гэж хариулжээ. Дотуур байрны үйлчлэгчдийн хариулсан байдлаас үзэхэд шаардлагатай хувцас хэрэглэл, цэвэрлэгээний материал, хэрэгслээр хангаж, заавар зөвлөгөө өгдөг тухай дурджээ.

Дэмжлэгийн тал дээр захирал нярав, нягтлан 3 хамтран ажиллаад бид нарт заавар зөвлөгөөгөө өгөөд, ямар нэг бэрхшээл гарахад бид захирал, нярав, эмчдээ хэлээд, тэд хамтран тухайн нөхцөлд нь тааруулаад арга хэмжээ авчихдаг. Ямар ч байсан дэмжлэг үзүүлээд байдаг.

*...аймгийн дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*



Сургуулийн зүгээс үзүүлдэг тогтмол дэмжлэг байдаг. 8 цагийн жижүүрийг бид сараар ээлжлэн хийдэг. Бусад 2 жижүүр маань 12 цагаар ээлжлэн гарчихдаг. Энэ нь бидэнд их эвтэйхэн байдаг.

*Улаанбаатар хотын дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Харин дэмжлэг үзүүлдэггүй, нийгмийн ажилтан зэрэг хүмүүс ажилладаггүй, зөвхөн ажлын чиглэл өгдөг, уг ажлыг хариуцаад удаагүй тул сайн мэдэхгүй байна, хэмээн зарим оролцогч шүүмжлэлтэй хандсан байна.

Цаашид дотуур байранд цаашид ажиллах хүсэлтэй эсэх талаар ярилцлахад дотуур байрны ажилтны ихэнх нь хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна. Ялангуяа, байрны жижүүр, тогоочид хүүхдүүдтэй ажиллах ажилдаа сэтгэлээсээ ханддаг, энэ ажилдаа дуртай гэдгээ дурдсан бөгөөд тэдний бараг 60 орчим хувь нь тухайн сургууль, сургуулийн дотуур байрандаа ажиллаад олон жил болчихсон учраас тэтгэвэрт гартлаа эндээ ажиллана гэсэн хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Энэ хариултыг ялангуяа сумын сургуулийн дотуур байрны ажилтан илүү өгсөн байгаа нь анхаарал татаж байна.

Ажиллах гэж орсон учраас цаашид ажиллаад явна. Би тэтгэвэрт гартлаа ажиллана. Өмнө цэцэрлэгийн багш байж байгаад энэ ажилд орсон. Ажилдаа сэтгэл хангалуун байдал гайгүй. Хүүхдүүдтэйгээ болоод байдаг учраас ажлаас гаръя гэсэн бодол байдаггүй. Тиймээ ажиллана, хүүхдүүдийн хандлага харилцаа сайн байдаг гэгээлэг ажилдаа дуртай байдаг.

*... аймгийн дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Цаашид тэтгэвэрт гартлаа байрандаа ажиллана. Хүүхдүүдтэй шуугилдаад ажиллах сайхан юм их байна. Одоо би туршлагатай бол хэцүү гэх зүйл гайгүй. Хүүхдүүдээ байнга хараа хяналттай байлгахад амаргүй ээ. Хүүхдүүд гарч орох гээд их юм болно. Тэр бүрд арга эвийг нь олох болно.

*Улаанбаатар хотын дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Оролцогчид цаашид ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ тэдний ажлын ачаалал, цалин хөлс, нэмэгдэл зэрэг дээр анхаарч өгөх хүсэлтийг гаргах нь нийтлэг байна. Ялангуяа, дотуур байрны тогоочдын хувьд ажлын ачаалал ихтэй, туслах ажилтан хомсдолтой, цалин мөнгөний хүрэлцээ муу байгаа талаар ихэнх нь хэлсэн байна.

### **Дүгнэлт**

Дотуур байранд ажиллах хүний нөөцийг ажилд авахдаа тодорхой шаардлага, шалгуур тавьж авдаг байна. Ялангуяа, дотуур байрны жижүүрийг өмнө нь багшийн ажлын туршлагатай, сургуулийн орчинд ажиллаж байсан хүнийг авах хандлага дотуур байруудад бий болжээ.

Ажилтнуудад “Хүүхэд хамгааллын бодлого”-ыг танилцуулан албан ёсоор гарын үсэг зуруулдаг байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр байрны багш, жижүүр, үйлчлэгч, тогооч зэрэг дотуур байрны ажилтан сургуулийн удирдлага, бусад багш, нийгмийн ажилтан, эцэг эх, асран хамгаалагчидтай байнга холбоотой ажиллаж, ажиглах, тэмдэглэх, зөвлөх, шаардлага тавих гэх мэтээр тасралтгүй ажилладаг.

Ярилцлагад хамрагдсан тогооч, жижүүр багш нарын хувьд 7 хоног, 3 эсвэл 2 хоногийн хугацаатайгаар “хүүхэд хамгаалал”, “сэтгэл зүй, харилцаа”, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтад оролцдог байна. Гэвч тогооч нартай харьцуулахад

жижүүр, багш нарын орон нутгийн түвшний сургалтад хамрагдах нь дутагдалтай байна. Зөвхөн сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн зохион байгуулсан нэг өдрийн сургалтад хамрагддаг тал харагдлаа.

Дотуур байрны ажилтнуудыг тэгш оролцоотойгоор хүүхэд хамгаалал, мэргэжлийн ур чадварын сургалтад хамруулах, сургалтын үр дүнг дээшлүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг эрчимжүүлэх нь зүйтэй байна.

#### **2.4 Эцэг эх, асран хамгаалагчдын дэмжлэг үйл ажиллагаа**

Дотуур байранд сурагчид 1 - 10 жил амьдарч байгаа ба гэр бүлийн 2- 4 хүүхэд хамт амьдарч буй тохиолдол цөөнгүй байна.

##### *Сургуулийн дэмжлэг үйл ажиллагаа*

Дотуур байранд хүүхдээ оруулахдаа тулд эцэг эх, асран хамгаалагчид:

- Дотуур байрны багш ба захирал
- Сургуулийн захирал
- Байрны багш
- Өмнөх жил байранд байсан бол шууд ордог
- Өргөдөл бичээгүй ярилцаад
- Өргөдөл бичдэг
- Ах, эгч нь байдаг болохоор дагуулаад л байрны багштай яриад өгдөг
- Манай хүн л оруулсан байх аа би мэдэхгүй гэх мэт хариултууд хамгийн олон давтагдсан байна.

Манай том хүүхэд одоо оюутан. Тэр маань 1-р ангид манай эгчийн гэрт байсан. Дараа жилээс дүү нь хичээлд орсон. 2 хүүхэд нэг айлд байх хэцүү байсан. Тэгээд 2 хүүхдээ байранд байлгахгаар шийдээд, байрны багштай уулзаж ярьсан. Дараа нь нэг өрөөнд тогтмол амьдардаг болсон. 9 сарын 1-нд байрандаа ирээд л шууд өөрсдийн өрөөндөө ордог.

..... аймгийн ..... сумын ..... ээжийн ярианаас

Багийн дарга л санаачилгаараа ярьсан, танай хүүхдийг байранд оруулъя гээд. Аав ээж 2 нь салаад 2 тийшээ болоод хүүхдүүд чинь хаягдаад эзэнгүй болчихлоо байранд оруулая гэж яриад би тэгээрэй гэж хэлсэн.

..... аймгийн нэгэн ээжийн ярианаас

Үүнээс үзэхэд дотуур байранд хүүхдээ оруулахдаа эцэг эх, асран хамгаалагчид нь сургуулийн захирал болон байрны багштай ярилцаж оруулдаг ба зарим тохиолдолд хүүхдийн амьдарч буй сум болон багийн дарга нар тухайн айлын амьдралыг мэдэж хүүхдийн эрхийг хамгаалахын тулд нь байранд оруулах тохиолдол байдаг байна.

Эцэг эх, асран хамгаалагчидтай ярилцах явцад дотуур байранд хүүхэд байх давуу талуудыг хамгийн олон давтамжтай илэрхийлсэн байна. Үүнд:

- Хүүхэд бие даах чадвартай болдог
- Цэвэрхэн дулаахан орчинд тайван амьдардаг
- Чирэгдэл багатай. Харуул хамгаалалттай. Хоол ундтай. Хичээлийг нь хийлгэдэг. Дулаахан.
- Амар байдаг. Орой үдэш гаргадаггүй. Амрах цагт нь амраадаг
- Өөрийн дураар, хоол унд сайтай, дэмий тэнэхгүй. Айлд байхаас илүү амар,
- Сэтгэл амар, хүүхдэд аюулгүй

- Бие даагаад, хичээлээ хийгээд, аягаа угаагаад сурч байна, даалгавраа надаас хамааралгүй хийж байна. Хувцсаа ялгаад өөрөө өмсөөд сурч байна.
- Сэтгэл санаа зовох нь бага, амар тайван байдаг.
- Гэртээ байгаа юм шиг л амьдардаг.
- Нийтэч болдог, бусадтай эвтэй харилцаатай болно.
- Дотуур байр нь хараа хяналт сайтай байна. Орой 6 цагаас хойш ирэхгүй байвал над руу ярьдаг багш нар нь хариуцлагатай байдаг гэх мэтээр хариулсан байна.

Хөдөөгийн бид нарт хүүхдээ харуулах найдвартай хүн багш нар байх юм даа гэж боддог. Суман дээр нэг гэртэй ч хоол унд юу ч хийж идэх юм, орой үдэш гараад явчихаар хараад хянах зөвлөх хүнгүй тэндээс бид нар санаа зовохоос өөр зүйлгүй утсаар л ярихаас хэтрэхгүй тэгснээс сургуулийнхаа дотуур байранд байх нь найдвартай амар санагддаг.

... аймгийн ..... сумын ээжийн ярианаас

Та дотуур байрны дараах зүйлсийг сайжруулаасай гэж эцэг, эх, асран хамгаалагчид үзсэн байна үүнд:

- Өрөөний разеткануудыг нь солих.
- Өрөөний тавилга нэмэх – хувцас хийх шкаф байдаггүй, тухтай суух сандал ширээ бага хүрэлцдэггүй.
- Хүүхдийн тав тухад анхаарах, нэг өрөөнд олон хүүхэд байгааг багасгах.
- Хоолны үйлчилгээг сайжруулах, ажилтнуудын хандлага муутай. Жижүүр багш нь эцэг, эх шиг нь харилцдаг байх.
- Эмч, эмийн үйлчилгээг сайжруулах.
- Би байнга очоод байдаггүй болохоор мэдэхгүй.
- Халуун устай болчихвол ядаж халуун усанд ороод тухтай байна.
- Хоолыг нь сайжруулаасай гэж боддог. Хоол муу мэргэжлийн тогооч байхгүй.
- Хүүхэд юм ярьж ирдэггүй учраас мэдэхгүй байна.
- Халуун усыг нь янзлаасай, эвдэрчихсэн, паар нь халдаггүй учраас янзлах хэрэгтэй хүйтэвтэр байдаг.

Үдээс хойш хичээл тараад ирж байгаа хүүхдүүд хичээлээ давтаж чаддаггүй тог тасалдаг. Хичээл давтаад юм уу ангийнхантайгаа хамт байж байгаад ирэхэд хоол нь хүйтэн, заримдаа дан шөл үлдсэн байдаг.

... аймгийн нэгэн ээжийн ярианаас

Хүүхдээ дотуур байранд амьдарч байх хугацаанд нь үйл ажиллагааг нь дэмжих зорилгоор эцэг эх, асран хамгаалагчид нь амьдарч буй өрөө тасгийг нь тохижуулах, камержуулах, гэрэл солих, өрөөг нь хулдааслах, цонхыг нь дулаалах, ширээ сандал хөшиг, дэвсгэр, өрөөг нь тохижуулах зорилгоор 50.000 төгрөг хураалгадаг гэх мэт зүйлээр тусалцаа үзүүлдэг байна.

Хүүхэд хөгжлийн төв нь жижиг санагдсан. Том өрөөнд байвал. Хүүхэд хөгжүүлчих төв байж чадахгүй байна уу даа гэж бодсон. Дандаа бичүүлэх биш тоглуулж байвал гэж санагдсан.

....аймгийн .... сумын аавын ярианаас

Дотуур байранд амьдарч буй хүүхдүүдийн хувьд эцэг, эх асран хамгаалагчид нь 100 хувь дүрэм журам зөрчиж ямар нэг асуудалд орж байгаагүй байна.

Дотуур байрнаас зохион байгуулж буй үйл ажиллагааны хувьд:

Олон ажил зохион байгуулдаг бүхий л уралдаан тэмцээн, урлагийн үзлэг, наадам, шинэ жилийн баяр, шүлгийн уралдаан, тэмцээн, бүжиг, шагай, шатар, даамны тэмцээнд тухай хүүхдийнхээ ярианаас сонсдог талаар өгүүлсэн байх ба эцэг эхэд тийм тийм ажил зохион байгуулна гэж мэдээлэл өгдөггүй байна.

Хүүхдүүд нь ямар ажилд оролцох тухайгаа эцэг эх асран хамгаалагчдадаа ярьдаггүй буюу хааяа асуухаар тодорхой юм хариулдаггүй гэж хүүхдүүдийнхээ талаар хариулснаас үзвэл эцэг эх, асран хамгаалагчид нь хүүхдүүдтэй харилцан ярилцаж байх шаардлагатай илэрхийлж байна.

Хүүхэд нь хэдэн наснаас дотуур байранд амьдрах нь боломжтой талаар

- 1-р ангиас гэж 22.2 хувь нь
- 2-3-р ангиас гэж 33.3 хувь нь
- Дунд ангиас гэж 11.1 хувь нь ахлах ангиас гэж 7.5 хувь нь үздэг байна.

...Малчин өрхийн хүүхдүүд байгаа учир анх сургуульд ороход нь л өгвөл зүгээр байгаа юм тэгээд ах эгч нь хамт байдаг бол амьдраад байна. Хэрэв тийм ах эгч байхгүй бол хувцсаа угаах, дотуур хувцсаа солих гээд асуудал их үүснэ. Манай хүүхэд эгч нь байгаа болохоор 1-р ангиас дажгүй яваад байгаа тэрнээс бас санаа зовох юм ихтэй...

.... аймгийн .... төвийн ээжийн ярианаас

Эцэг, эх асран хамгаалагчид нь 6 нас бол арай балчир байдаг ч гэсэн дотуур байранд оруулахаас өөр арга байдаггүй бие дааж сурдаг ба багш нь хичээлийг нь зааж өгдөг болохоор сураад явдаг уул нь 7-8 насан болон түүнээс дээш насанд бол боломжийн гэж үзсэн байна.

... Хөдөө амьдардаг хүүхдээ сумын төв дээр айл байхгүй болохоор сургуульд өгөхгүй бол цаашдаа ирээдүйгүй болно. 1-р ангид нь өгсөн. Багш нь олон жижиг хүүхдүүдтэй хэцүү байдаг. Том болсон хойно нь суулгамаар юм байна лээ. Тоглох насан дээрээ байгаа болохоор 6-7 настай хүүхдүүдийг том хүүхдүүд ойлгохгүй, зоддог байдал ажиглагдсан...

.... аймгийн .... төвийн ээжийн ярианаас

Дотуур байранд хүүхэд ямар нэг зүйлээ алдах нь камержуулсантай холбоотой мөн өдөр бүрийн багш нарын яриа зэрэгтэй холбоотой хэдийгээр буурсан ч гэсэн мөнгө алдах, зарим хувцсаа алдах тохиолдол байгаа ба манай хүүхэд өөрөө салангаас, хямгадах чадваргүй болохоороо алддаг ч багш нар нь олоод өгдөг, оо, саван, 00 цаас, дэвтэр, утасны чихэвч гэх мэтээ алдах цөөнгүй тохиолдол байгаа талаар дурдсан байна.

Дотуур байрны үйлчилгээд сэтгэл ханамжтай байдаг талаар эцэг эх асран хамгаалагчид сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн байна.

Дотуур байранд сэтгэл хангалуун байдаг. Би өөрөө ч амьдарч байсан. Би бол байрыг хүндэлдэг.

.....аймгийн .... сумын ээжийн ярианаас

Дотуур байранд амьдарч буй хүүхдийнхээ ариун цэврийн өдөр тутмын хэрэглээний зүйлсийг эцэг эх, асран хамгаалагчид нь 2 сар тутамд юм уу дууссан гэж хэлсэн үед нь авч өгдөг, 9-р сарын 1-нд бүтэн жилийн хэрэглээг нь багшид нь хүлээлгэж өгдөг, мөн

өрөөгөө дотуур байрны цэвэрлэгээнд зориулж цэвэрлэгээний бодис авч өгдөг, сургуулиас ч өгдөг гэж хариулсан байна.

Дотуур байранд амьдарч буй бага насны хүүхэд өөрийн хувцас, дотуур хувцсаа хэрхэн цэвэрлэдэг талаар сайн мэдэхгүй байна гэж 15 орчим хувь нь хариулсан бол гэртээ ирэхэд угаадаг, жижүүр нь угааж өгдөг, өрөөний том хүүхдүүд нь угааж өгдөг, өөрөө угаадаг, жижиг угаалгын машин өгсөн өөрөө угаадаг бага ангийн хүүхдүүдийн дотуур хувцсыг 7 хоногийн 3 дахь өдөр жижүүр багш угааж өгдөг гэж хариулсан байна.

Дотуур байрны багш, ажилтнуудтай хагас бүтэн сайн өдөр хүүхдээ авахдаа уулздаг, ямар байна ямар нэг асуудал гарсан эсэх гээд хурлын талаар, хоолны талаар, багштай байнга холбоотой байдаг оройтлоо хаана явна тань руу ярьсан уу гэх мэтийн асуудлаар уулздаг, харин эмчтэй нь бараг уулздаггүй харин шүдний өвчлөл, болон харшилтай хүүхэдтэй учир эмчтэй уулздаг гэж хариулсан байна.

Дотуур байрны бие засах газар цэвэрхэн байдаг ба өнгөрсөн жил л орж үзэхэд цэвэрхэн байсан энэ жил орж танилцаж чадаагүй, гадаа модон 00 нь бохир, дээшээ өрөөнд нь оруулдаггүй болохоор сайн мэдэхгүй байна гэж ихэнх эцэг эх асран хамгаалагч хариулжээ.

Дотуур байрны хоолны газрын эрүүл ахуй, орчны тохижилтын талаар хүссэн үедээ ус, цай уух боломжтой зарим нь гал тогооны өрөөнд орж уудаг талаар, зарим нь коридорт ус цэвэршүүлэгч байгаа тэндээс уудаг талаар, зарим нь өрөөндөө данхтай цайтай байдаг тэндээсээ уудаг гэж хариулсан бол мөн зарим нь тэр талаар хүүхдээсээ асууж байгаагүй мэдэхгүй байна гэсэн хариултыг ихэвчлэн аавтай нь ярилцах явцад өгсөн байна.

Хүүхдийнх нь амьдарч буй өрөө нь ямар нэг үнэргүй гэж хариулсан нь ихэвчлэн ээж, эмээ нь байгаа бол чийг үнэртдэг, ариун цэврийн өрөөтэй ойролцоо болохоор элдэв үнэр үнэртдэг гэж хүүхэд хэлсэн гэж ээжүүд хариулсан байна.

## **Дүгнэлт**

- Дотуур байранд хүүхдээ оруулахдаа өргөдөл өгөх юм уу эсвэл сургуулийн захирал, дотуур байрны багштай уулзаад оруулах боломжтой байдаг байна. Сум орон нутгийн удирдлага болон багийн ахлагч нар иргэдийнхээ амьжиргаа, гэр бүлийн байдлыг сайн мэддэг учраас хүүхдийн сургуулиас завсардуулахгүйн тулд дотуур байранд оруулах санал гаргаж оруулдаг тохиолдлууд байгаа нь тэд ажил үүргээ биелүүлж байгааг харуулж байна.
- Эцэг эх, асран хамгаалагчид нь сургуулийн удирдлага дотуур байрны багштай гэрээ байгуулдаг боловч энэ нь олон хувилбартай эрх, үүргийг тусгасан байдаг байна. Эцэг эх, асран хамгаалагчид нь гэрээнд байгаа эрх, үүргээ сайн мэдэхгүйн улмаас биелүүлэхгүй тохиолдол байна.
- Дотуур байранд хүүхэд нь бие даах чадвартай болдог, эцэг эх асран хамгаалагчдад нь чирэгдэл бага, хүүхдэд аюулгүй байдаг учир тэд хүүхдүүдээ өгөх дуртай байдаг байна.
- Хүүхдээ дотуур байранд хүргэж өгөх ба авахдаа заавал гарын үсэг зурж хэвшсэн гэж хариулсан байна.
- Дотуур байранд амьдарч байхдаа дотуур байрны дүрэм журмыг зөрчиж байгаагүй гэж хариулсан байна.

- Дотуур байрны үйл ажиллагааг дэмжихийн тулд эцэг эхийн зөвлөл байгуулан өрөөг нь тохижуулах, цагаан идээгээр туслах камержуулах зэрэг ажилд дэмжлэг үзүүлдэг байна.
- Дотуур байрнаас зохион байгуулж байгаа ажлыг сайн мэдэхгүй байх тохиолдол байна. Энэ нь багш үйл ажиллагаагаа танилцуулаагүй гэж мөн хүүхдүүдтэйгээ сайн ярилцдаггүйгээс мэдэхгүй байх тохиолдол байдаг байна.
- Эцэг эх, асран хамгаалагч нь ариун цэврийн хэрэглэл материалаар хангаж өгөх үүргээ тогтмол биелүүлдэг байна.
- Дотуур байрны багштай эцэг эх, асран хамгаалагчид нь утсаар ярих, facebook групп нээх зэргээр холбоотой байж мэдээлэл авах, солилцох тохиолдол байна.
- Эмчтэй төдийлөн харилцдаггүй харин шүд өвдөх гэх мэт үед л харилцдаг байна.
- Хүүхдийнхээ амьдарч буй өрөөнд дотуур байрны дүрмийн дагуу орж үзээгүй харин багшийн өрөөнд юм уу жижүүрийн өрөөнд хүүхэдтэй уулздаг, эцэг эхийн өрөөтэй бол тэнд нь хонож уулздаг, мөн хоолны өдөрлөг гэх мэт өдөрлөгүүдийн үед хоол гал тогоо, ариун цэврийн өрөөнд нь орж танилцдаг гэх хариулсан байна.

#### **Дотуур байран дахь хүүхэд хамгааллын нөхцөл байдал**

- Дотуур байранд үе тэнгийн дээрэлхэл зарим талаар байдгийг хүүхдүүд дурдсан байна. Ихэнхдээ бие биеэ цохих, шоолон нэр хоч өгөх нь нийтлэг байна.
- Дотуур байрны багш, ажилтан ба суралцагчдын хоорондын харилцаа хандлага ерөнхийдөө эерэг байна. Зарим талаар байрны ажилтнуудтай харилцааны зөрчилд орох явдал байдаг байна. Тухайлбал, тогооч, жижүүрүүдтэй үл ойлголцох байдал гардаг гэжээ. Энэ нь зарим тохиолдолд тогоочийн ажлын ачаалалтай холбоотой байж болзошгүй байна.
- Дотуур байранд хүүхдүүд хувийн эд зүйлсээ хулгайд алдах байдал гардаг аж. Энэ үед байрны жижүүр багшид ихэвчлэн ханддаг ба камер шүүх, бусад суралцагчдаас асуух гэх мэт арга хэмжээ авдаг ч шийдэгдэхгүй байх тохиолдол элбэг ажээ. Суралцагчтай хийсэн ярилцлагаас харахад, өрөө тасгаа цоожлох боломж муутай байдаг нь мөн энд нөлөөлдөг магадлалтай байна.
- Дотуур байрны багш, жижүүрийг ажилд авахдаа сургуулийн орчинд ажиллаж байсан, багш мэргэжилтэй хүнийг авах хандлага бий болжээ.
- Багш, ажилтнуудад “хүүхэд хамгааллын бодлого” танилцуулж гарын үсэг зуруулдаг. Мөн дотуур байран дахь хүүхэд хамгааллын асуудалд сургуулийн удирдлага анхаарал хандуулдаг, багш ажилтнуудыг мэргэжлийн ур чадвар олгох, хүүхэдтэй харилцах болон хүүхэд хамгааллын чиглэлээр сургууль дотроо, сургуулиас гадна сургалт зөвлөгөөнд хамруулдаг сайн туршлагауд байна. Дотуур байрны багш, тогооч зэрэг хүмүүс сургалтад түлхүү хамрагдах бол байрны жижүүрүүд сургуулиас гадна явагдаж байгаа сургалтуудад тэр бүр хамрагддаггүй талаараа ярилцлагад оролцогчид дурдсан байна.

#### **Эцэг эх, асран хамгаалагчдын дэмжлэг, үйл ажиллагаа**


- Дотуур байранд хүүхдээ оруулахдаа өргөдөл өгөх юм уу эсвэл сургуулийн захирал, дотуур байрны багштай уулзаад оруулах боломжтой байдаг байна. Сум орон нутгийн удирдлага болон багийн ахлагч нар иргэдийнхээ амьжиргаа, гэр бүлийн байдлыг сайн мэддэг учраас хүүхдийн сургуулиас завсардуулахгүйн тулд дотуур байранд оруулах санал гаргаж оруулдаг тохиолдлууд байгаа нь тэд ажил үүргээ биелүүлж байгааг харуулж байна.

- Эцэг эх, асран хамгаалагчид нь сургуулийн удирдлага дотуур байрны багштай гэрээ байгуулдаг боловч энэ нь олон хувилбартай эрх, үүргийг тусгасан байдаг байна.
- Дотуур байранд хүүхэд нь бие даах чадвартай болдог, эцэг эх асран хамгаалагчдад нь чирэгдэл бага, хүүхдэд аюулгүй байдаг учир тэд хүүхдүүдээ өгөх дуртай байдаг байна.
- Хүүхдээ дотуур байранд хүргэж өгөх ба авахдаа заавал гарын үсэг зурж хэвшсэн гэж хариулсан байна.
- Дотуур байранд амьдарч байхдаа дотуур байрны дүрэм журмыг зөрчиж байгаагүй гэж хариулсан байна.
- Дотуур байрны үйл ажиллагааг дэмжихийн тулд эцэг эхийн зөвлөл байгуулан өрөөг нь тохижуулах, цагаан идээгээр туслах камержуулах зэрэг ажилд дэмжлэг үзүүлдэг байна.
- Дотуур байрнаас зохион байгуулж байгаа ажлыг сайн мэдэхгүй байх тохиолдол байна. Энэ нь багш үйл ажиллагаагаа танилцуулаагүй гэж мөн хүүхдүүдтэйгээ сайн ярилцдаггүйгээс мэдэхгүй байх тохиолдол байдаг байна.
- Эцэг эх, асран хамгаалагч нь ариун цэврийн хэрэглэл материалаар хангаж өгөх үүргээ тогтмол биелүүлдэг байна.
- Дотуур байрны багштай эцэг эх, асран хамгаалагчид нь утсаар ярих, фэйсбүүк групп нээх зэргээр холбоотой байж мэдээлэл солилцох авах тохиолдол байна.
- Эмчтэй төдийлөн харилцдаггүй харин шүд өвдөх гэх мэт үед л харилцдаг байна.
- Хүүхдийнхээ амьдарч буй өрөөнд дотуур байрны дүрмийн дагуу орж үзээгүй харин багшийн өрөөнд юм уу жижүүрийн өрөөнд хүүхэдтэй уулздаг, эцэг эхийн өрөөнтэй бол тэнд нь хонож уулздаг, мөн хоолны өдөрлөг гэх мэт өдөрлөгүүдийн үед хоол гал тогоо, ариун цэврийн өрөөнд нь орж танилцдаг гэх хариулсан байна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ: ДОТУУР БАЙРНЫ БАГШ, АЖИЛТНЫ АЖЛЫН НӨХЦӨЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ


2023-2024 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 728 дотуур байрны багш ажиллаж байна. Үүнээс 390 багш манай судалгаанд хамрагдсанаас дотуур байрны 106 багш судалгаанд биечлэн, 284 багш цахимаар оролцсон байна.

Зураг 17. Судалгаанд хамрагдсан багш нар (насаар)




Дотуур байрны багш нарын 50 хувь нь 30-40 насны залуу багш нар байна.

Зураг 18. Судалгаанд хамрагдсан багш нар (хүйсээр)



Хүснэгт 21. Судалгаанд хамрагдсан багш нар (улсад ажилласан жилээр)




Дотуур байрны багш нарын 85 хувийг эмэгтэй багш нар эзэлж байгаа бол судалгаанд оролцогчдын ажилласан жил ижил хувьтай байна.

### 3.1 Дотуур байрны багшийн мэргэжил дээшлүүлсэн байдал

Энэ хэсэгт дотуур байрны багшийн мэргэжил дээшлүүлсэн байдал, сургуулийн удирдлага, орон нутгийн зүгээс багшийг хэрхэн дэмжиж байгаа талаарх үр дүнг харуулахыг зорилго.



Зураг 19. Багш нарын мэргэжил дээшлүүлсэн байдал




- Хүүхэд хөгжил, хамгаалал
- Багшийн ур чадвар
- Хүүхдийн эрүүл мэнд, амьдралын зөв дадал хэвшил

Дотуур байрны багш нарт зориулсан сургалт нь хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр ихэвчлэн зохиогддог байна. Дотуур байрны ажилтнуудтай хийсэн ярилцлагаас мөн жил бүр хичээлийн жилийн эхэнд дотуур байрны багш

нарт зориулсан сургалт явагддаг гэсэн байна. Харин 4.1 хувь нь багшийн ур чадвартай холбоотой, 7.9 хувь нь бусд чиглэлээр гэсэн хариултыг багш нар өгчээ.

Зураг 20. Сургуулийн удирдлагаас багшийг дэмждэг эсэх



- Дэмжлэг бараг байдаггүй
- Дэмждэг боловч хангалттай биш
- Хангалттай дэмждэг

Хэдийгээр жил бүр дотуур байрны багш нарт улсаас сургалт явуулдаг боловч сургуулийн зүгээс дэмжлэг хангалттай биш байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Хүснэгт 22. Сургуулийн удирдлагаас багшийг дэмждэг эсэх

Correlations				
	Дотуур байрны багшид зориулсан албан ёсны ямар сургалтад ихэвчлэн хамрагддаг вэ?	Дотуур байранд хүүхэд эрх хамгаалал, хөгжлийн төлөвлөгөөг хэрхэн боловсруулдаг вэ?	Дотуур байранд хүүхдэд зориулсан хүүхэд хөгжил, хамгааллын сургалт, зөвлөгөө хэр явагддаг вэ?	Дотуур байранд хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд нөхцөл байдлын тандалт судалгаа жил бүр хийдэг үү?
Сургуулийн удирдлагын зүгээс таныг хүүхэд хөгжил, хамгааллын ур чадварын чиглэлээр хэр зэрэг дэмждэг вэ?	-0.055	.194**	.238**	0.067
Дотуур байрны багшид зориулсан албан ёсны ямар сургалтад ихэвчлэн хамрагддаг вэ?		-0.025	-.131**	0.013
Дотуур байранд хүүхэд эрх хамгаалал, төлөвлөгөөг хэрхэн			.175**	0.090

боловсруулдаг вэ?


Дотуур байранд хүүхдэд зориулсан хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр сургалт, зөвлөгөө хэр явагддаг вэ?	.220**
---	--------

\*\* . Correlation is significant at the 0.01 level (2-tailed).

Дээрх хүснэгтээс харахад, хсургуулийн удирдлагын зүгээс хүүхэд хөгжил, хамгааллын төлөвлөгөө боловсруулах, сургалт зөвлөгөө явуулахад удирдлагын зүгээс илүү дэмжлэг үзүүлдэг байна.

Хүүхэд хөгжил хамгааллын чиглэлээр сургалт зөвлөгөө явагддаг гэж хариулсан багш нар хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөхцөл байдлын тандалт судалгааг илүү хийдэг нь харагдаж байна.

Зураг 21. Дотуур байрны багшийн оролцоо




Багшийн мэргэжил дээшлүүлэх чиглэлээр сургуулийн зорилгодоо тусган ажиллах, сургалт, үйл ажиллагаанд багшийг оролцуулах, мэргэжил дээшлүүлэх боломжоор хангаж ажилладаг гэж судалгаанд хамрагдсан сургуулийн удирдлагын 90-ээс дээш хувь нь хариулсан байна

### 3.2 Дотуур байрны багшийн үйл ажиллагаа, албан тушаалын тодорхойлолт

2008 онд батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны багшийн ажлын байрны тодорхойлолт”, 2019 онд батлагдсан Монгол улсын стандарт MNS 6781:2019 “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ”-д дотуур байрны багшид тавигдах шаардлага, гүйцэтгэх үүргийг зааж өгсөн байдаг.


Зураг 22. Судалгаанд хамрагдсан багш нар (боловсролын түвшнээр)



Дотуур байрны орчин, үйлчилгээний стандартын 7.4-д дотуур байрны багш нь багш эсвэл нийгмийн ажилтан мэргэжилтэй 5-аас доошгүй жил хүүхэдтэй ажилласан туршлагатай байна гэж заасан байдаг. Судалгаанд хамрагдсан багш нарын 5.6 хувь нь бүрэн дунд, тусгай боловсролтой байгаа нь хүний нөөцийн хомсдол байгааг харуулж байна. Судалгаанд


хамрагдсан дотуур байрны багшийн мэргэжлийг авч үзэхэд 5 хувь нь бусад мэргэжлийн хүмүүс байна.

Зураг 23. Хүүхдийг дотуур байранд анх орж ирэхэд байрны дүрэм, үйлчилгээний талаар танилцуулдаг эсэх




Дотуур байрны сурагчдыг хүлээн авсан өдөр эмчийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэж сургуулийн эмч эсвэл дотуур байрны багш хадгалдаг байна.

Зураг 24. Дотуур байрны хүүхэд эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг байдал




Зураг 25. Дотуур байрны хүүхдийн эрүүл хоол хүнс хэрэглэхтэй холбоотой эцэг эх, асран хамгаалагчдаас дэмжлэг авдаг эсэх




Дотуур байрны багш дотуур байрны эрүүл ахуй, хоол үйлдвэрлэлийн талаар хяналт, шаардлага тавьж ажилладаг байна. Харин эцэг эх, асран хамгаалагчаас сурагчид эрүүл хоол хүнс хэрэглэхтэй холбоотой тусламж дэмжлэгийг бараг авдаггүй байна.

Зураг 26. Хүүхэд хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад оролцогчид



Сургууль нь жилийн төлөвлөгөөндөө дотуур байрны хүүхдэд зориулсан хүүхдийн хөгжлийн төлөвлөгөөг гаргадаг байна. Тухайн төлөвлөгөөг дотуур байрны багш ганцаараа боловсруулдаг гэж 35.6 хувь нь хариулсан байна.

Зураг 27. Сургуулийн жилийн төлөвлөгөөнд дотуур байрны багш, ажилтнуудын оролцоо, хувиар




Харин сургуулийн бодлого тодорхойлох, шийдвэр гаргахад дотуур байрны багш ажилтнуудыг оролцуулдаг гэж сургуулийн удирдлагын зүгээс үзсэн байна. Мөн сургуулийн удирдлага дотуур байрны багштай тогтмол уулздаг байна.


Тухайн төлөвлөгөөнд тусгадаг, дотуур байрны багшийн ажлын байрны тодорхойлолтод заасан нэг том зорилт нь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх юм. Энэ чиглэлээр дотуур байрны сурагчдад зориулсан сургалт, зөвлөгөөг тогтмол явуулдаг гэж 64 хувь нь хариулсан бол хааяа явуулдаг гэж 33 хувь нь хариулсан байна.

Эцэг эх, асран хамгаалагчтай ямар чиглэлээр хамтран ажилладаг талаар асуухад дийлэнх буюу 67 хувь нь хүүхдийн хөгжил, төлөвшил, оролцооны чиглэлээр хамтран ажилладаг гэж хариулсан байна. Харин хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр 17 хувь, эрүүл мэнд хоол хүнсний чиглэлээр 16 хувь нь хамтран ажилладаг гэж хариулжээ.

Зураг 28. Дотуур байрны багш хүүхдийн гэрийн даалгаварт тусалдаг эсэх




хүүхдүүдэд тусалдаг гэж хариулсан багш нарын хувьд хүүхдийн тоо их, ганцаараа ажилладаг учир зөвхөн бага ангийн сурагчдад тусалдаг, мөн дунд, ахлах ангийн хүүхдүүдэд цаг зав гардаггүй, хичээл нь хүнд учир зааж өгч чаддаггүй, дунд, ахлах ангийн хүүхдүүд тусламж хүсдэггүй гэж хариулсан байна.




Зураг 29. Дотуур байранд хүүхдүүд үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт, нэр хоч өгөх явдалд өртөх эрсдэл байдаг эсэх

Зураг 30. Тандалт судалгаа авдаг эсэх




Зураг 31. Дотуур байранд ирдэг санал гомдол



Дотуур байранд амьдардаг хүүхдүүдийн хувьд үе тэнгийнхний дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтад өртдөг эсэх талаар дотуур байрны багш тандалт судалгаа авч, сургалт, зөвлөгөө зохион байгуулдаг ч хүүхдүүдийн дунд үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэл байсаар байна. Мөн дотуур байранд ирдэг санал гомдлын 14 хувийг энэ чиглэлийн санал гомдол эзэлж байна гэдгийг дурджээ.


Зураг 32. Дотуур байрны багшаар ажиллахад тулгардаг бэрхшээл




Дотуур байрны судалгаанд хамрагдсан багш нарын 50-аас дээш хувь нь цалин хөлс, ажлын байрны дагуу үүрэг хариуцлагатай холбоотой хүндрэл, бэрхшээл хамгийн их учирдаг гэж хариулсан бол огт бэрхшээл учирдаггүй гэж 9 хувь нь хариулсан байна.

Харин сургуулийн удирдлагын зүгээс багшийн гүйцэтгэлийг тогтмол хянаж, гүйцэтгэлийн үр дүнг байнга үнэлдэг гэж 76 хувь нь хариулсан байна.

Зураг 33. Багшийн гүйцэтгэлийг үнэлдэг эсэх




Зураг 34. Цаашид дотуур байрны багшаар ажиллах хүсэлтэй эсэх



Цаашид багшаар ажиллах хүсэлгүй гэж хариулсан багш нарын ихэнх хувь нь багшийн цагийн ачаалал их, илүү цагаар ажилладаг, цалин бага ч хариуцлага өндөртэй учир цаашид ажиллах хүсэлгүй гэж хариулсан бол, зарим багш нарын хувьд мэргэжлийнхээ дагуу ажиллах хүсэлтэй, эцэг эх, сургуулийн удирдлагаас дарамт их учир ажиллах хүсэлгүй гэж хариулсан байна.

Зураг 35. Сургуулийн менежментийг сайжруулснаар гарах өөрчлөлт



Дотуур байрны менежментийг сайжруулснаар дотуур байрны багшийн хөгжил, хандлагад өөрчлөлт гарна гэж 44 хувь нь үзсэн бол багшийн хөгжил, хандлагын чиглэлээр дэмжлэг хэрэгтэй байна гэж 66 хувь нь үзжээ.

### 3.3 Дотуур байрны ажилтны эрхэлдэг ажил, бэрхшээл

**Ажилд ороход ажлын байрны онцлог, үүрэг хариуцлагын талаар шалгуур тавьсан эсэхийг** тодруулж асуухад дотуур байрны тогоочдын хувьд ихэвчлэн сонгон шалгаруулалтаар тухайн ажлын байранд тэнцсэн байгаа гэдгийг хэлсний дээр ялангуяа, мэргэжил, ур чадварын шалгалт авсан, эрүүл мэндийн шинжилгээнд хамруулсны дээр зарим тохиолдолд ярилцлага авсан гэж хариулжээ. Түүнчлэн мэргэжлийн үнэмлэх, ажлын туршлагыг чухалчилсан талаар зарим нь тодотгож хэлсэн.

Тогооч өөрөө эрүүл байх ёстой. Багаар ажиллах чадвартай, хүүхдэд ээлтэй зэрэг шаардлага тавьдаг.

Сумын сургуулийн дотуур байрны тогоочтой хийсэн ярилцлагаас

Харин дотуур байрны жижүүрийн хувьд хүүхэдтэй харилцах харилцаа, хандлага дээр голчлон анхааруулж, ёс зүйн талаар дүрэм журмыг танилцуулж, багаар ажиллах, ачаалал даах зэрэг шаардлага тавьж байснаас гадна ярилцлага хийж байсан гэдгийг

тэдний ихэнх нь хэлсэн байна. Мөн тухайн сургуульд багшилж байсан, сургуульд ажиллаж байсан, сургуулийн орчин, хүүхдийн онцлогийг сайн мэддэг хүмүүсийг жижүүрийн орон тоон дээр ажиллуулдаг гэсэн хариултыг цөөнгүй хүн өгчээ.

Жижүүрийн хувьд хүүхэдтэй харьцах харилцаа бусадтай ёс зүйтэй харьцах харилцаан дээр л гол нь их шалгуур тавьдаг.

*Сумын сургуулийн жижүүрийн ярилцлагаас*

Үйлчлэгчдийн хувьд эрүүл мэндийн үзлэгт орж, хүүхдүүдтэй харилцах тал дээр анхааруулж, дотоод дүрэм журмыг танилцуулсан гэж хариулсны зэрэгцээ өөрсдийн бичсэн өргөдөлд үндэслэн ажилд авсан талаар мөн дурдсан байна. Харин тодорхой шаардлага тавиагүй талаар зарим үйлчлэгч, байрны багш дурдсан байна.

***Дотуур байрны хүүхдүүд/тэдний эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс үйлчилгээний талаар ажилтнуудтай холбоотой ихэвчлэн ямар хүсэлт, гомдол гаргадаг вэ? Үүнийг хэрхэн шийдвэрлэдэг вэ гэж*** асуухад ихэнх нь гомдол, санал ирдэггүй, одоогоор ирээгүй байна гэсэн хариултыг өгчээ. Зарим тохиолдолд хүүхэд өвдөх, хүүхэд ямар нэг зөрчил гаргах (үеийнхэнтэйгээ муудалцах, мөнгө шаардлагатай болох гэх мэт) эцэг эхчүүдтэй холбогдож ярилцдаг. Шаардлагатай бол дуудаж уулздаг хэмээн дурдсан байна. Зарим дотуур байрны хувьд хоолны амт чанар, орц, норм хүртээмжийн талаар санал хүсэлт ирдэг гэж тогооч нар хэлсэн бөгөөд энэ тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчидтай холбогдон, дотуур байранд ирсэн үед хоолны амталгаа хийлгэх, хоолны норм норматив, орц жорын талаар танилцуулах зэргээр хамтран ажилладаг байна. Мөн хүүхдүүд, ялангуяа, ахлах ангийн хүүхдүүдийн хоолны хүртээмж хангалтгүй байна, өлсдөг гэсэн санл хүсэлт гарч байдаг талаар дурдсан.

Эцэг эх, асран хамгаалагчдын тухайд санал хүсэлтийн дэвтэр ажиллуулдаг. Эцэг эхтэй уулзах уулзалтын өрөөтэй. Эцэг эхийн дунд группын чатаар холбогддог. Хүүхдүүдийн дунд “Надад хэлэх үг байна” хайрцаг дотуур байранд байрлуулсан.

*Сумын сургуулийн дотуур байрны ажилтантай хийсэн ярилцлагаас*

Жижүүр, үйлчлэгч нартай холбоотой санал гомдол ирж байсан тохиолдол цөөн, гэхдээ ах дүүсээр нь, эсвэл хот айлаар нь нэг өрөөнд оруулж өгөх хүсэлт нэлээн ирдэг.

***Дотуур байрны ажилтнуудад тулгардаг бэрхшээлийн талаар*** асуудлууд, хүндрэл бэрхшээл гайгүй байдаг, хүүхдүүдтэй ажиллах гэгээлэг, сайхан байдаг, орчин нөхцөлийн талаар сургуулийн зүгээс анхаарч ажилладаг гэх зэргээр эерэг, таатай талуудыг хэлсэн байна.

Ажлын орчны хувьд асуудалгүй сайхан. Тогоочийн нормын хувцсыг сургууль тавьж өгдөг. Хүүхдүүдтэйгээ ойрхон, илэн далангүй ярилцаж байгаад ядарснаа мартдаг нь сайхан байдаг. Хамт олонтой байна гэдэг сайхан.

*Аймгийн төвийн сургуулийн дотуур байрны тогоочтой хийсэн ярилцлагаас*

Эдгээр сайн талуудыг дурдсаны зэрэгцээ ажлын нөхцөл, ажлын чиг үүрэгтэй шууд холбоотой бэрхшээл асуудлууд байдгийг хэлсэн байна. Тухайлбал, тогоочдын хувьд ажлын ачаалал ихтэй байдаг, өглөө маш эрт ирээд, шөнө орой болтол ажилладаг талаар голчлон дурдсан байна. Тухайлбал, туслах тогоочтой хамт хоёулхнаа ажилладаг бөгөөд угаагчийн орон тоо шаардлагатай байгаа талаар нэмж хэлсэн байна. Мөн дараах бэрхшээл, асуудлуудыг нэрлэжээ. Үүнд:

- Олон цагаар зогсоо ажилладаг
- Хүний нөөц дутмаг
- Олон хүүхдэд 1-2 тогооч үйлчилдэг нь ачаалал ихтэй байдаг, илүү цаг бараг тооцоолж өгдөггүй
- Ажлын өдөр, амралтын өдөр гэлтгүйгээр хүүхдүүд байгаа бол бид ажиллаж л байдаг. Харин илүү цагийн мөнгийг сайн тооцож өгдөг баймаар байна.
- 50 хүүхдэд 1 тогооч гэж заасан байдаг. Гал тогоо тусдаа үйлчлэгчтэй байсан боловч одоо байртай дундаа 1 үйлчлэгчтэй болсноор ачаалал ихэссэн. 6 өдөр ажиллаж байна. Өглөө 8-аас ирдэг гэсэн харитлыг онцолсон байна.

Ярилцлагад хамрагдсан дотуур байрны жижүүрүүдийн хувьд дараах бэрхшээлүүдийг дурдсан:

- Гар утасны асуудал, шөнө дөл болтол гар утсаа үздэг. Утсыг нь тодорхой цагуудад хурааж аваад буцааж өгөх журам хэрэгжүүлсэн ч хүүхдүүд маш дургүй байдаг.
- Хүүхдүүд, ялангуяа ахлах ангийн охид, хөвгүүд дотуур байрнаас гарах, дэлгүүр орох, бусад сургуулийн хүүхдүүдтэй уулзах гэх мэтээр хараа хяналтаас гарчих гээд байдаг талтай нь бидэнд бэрхшээлтэй байдаг.
- Хүүхдүүдэд шаардлага тавихаар хүүхдийн эрхийг зөрчлөө, сэтгэл зүйн дарамт учруулаа гэх зэргээр өмнөөс тайлбар тавьж, сургуулийн захиргаанд мэдэгддэг.
- Бие засах газрын асуудал нэн тулгамдаж байна. Байр дотроо бие засах газартай ч ялангуяа өвлийн цагт насос нь эвдрэх гэх зэргээр ажиллагаагүй болчихоод байдаг нь хүүхдүүдэд, тэр тусмаа бага ангийн хүүхдүүдэд том бэрхшээл үүсгэдэг. Үүнтэй холбоотой асуудлууд их гардаг.
- Үйлчлэгчгүй тохиолдолд ээлжийн жижүүрүүд хүүхдүүдтэй хамтран бүх цэвэрлэгээгээ хийдэг.
- Хүүхдүүдийн аюулгүй байдлыг бүрэн хангаж, эрүүл мэнд, цаашлаад амь насыг хариуцдаг ажил болохоор тэр нь жаахан хэцүү.
- Дотуур байранд эмч байхгүй нь бэрхшээлтэй. Хүүхэд өвдсөн тохиолдолд сумын эмчид ханддаг. Ялангуяа, амралтын өдрүүдэд хэцүү.
- Бид “байрны багш” гэсэн нэртэй ч хүүхдүүд жижүүр, үйлчлэгч гэсэн байдлаар хандах нь нийтлэг байдаг.
- Ялангуяа одоо цагт хүүхдүүдтэй харилцах зарим талаар бэрхшээлтэй учраас дотуур байранд нийгмийн ажилтнаас гадна сэтгэл зүйч ажиллуулах шаардлагатай байна.

Тэр тусмаа хойд аав ээжтэй, ар гэрийн асуудалтай хүүхдүүд бүр их элэг барьдаг. Хүүхэд хамгааллын багийнхан ирэхээрээ хүүхдүүдэд та нар ийм ийм эрхтэй, ингэвэл та нарыг дарамталж байгаа гэсэн үг гээд тайлбарлачихдаг. Уг нь сайн хүүхдүүд байгаад байгаа юм. Хүүхдүүдтэй яаж харилцах бас их чухал юм шиг байгаа юм. Судалгаа авахаараа дандаа л яаж дарамтлуулж байна, яаж дээрэлхүүлж байна гэж л асуугаад байдаг.

*Сумын дотуур байрны ажилтнуудтай хийсэн ярилцлагаас*



Хамгийн том бэрхшээл нь дотуур байрны эмч гэж байдаггүй нь хэцүү. Дуудлага өгөхөд дороо ирдэг ч бүр болохгүй бол өөрөө тухайн хүүхдийг аваад явдаг. Мөн бас нэг бэрхшээл нь бага ангийнхныг сургуулийн нөгөө байранд хүргэж өгөхөд машин зам гарах шаардлагатай байдаг. Энэ хооронд зөөх унаа хэрэгтэй байгаа. Хүүхдүүд хичээлдээ яарах зэрэгт хувцас хунараа дутуу өмсөх гэх мэтээр даарах, ханиад хүрэх, өвдөх эрсдэлтэй байдаг. Сургуулийн унаа уг нь байгаа гэхдээ их хүйтэнд л зөөдөг. Бага сургууль нэлээн хойшоо их хол байдаг учраас машин зам гардаг нь нэг бэрхшээл болдог.

*Сумын дотуур байрны ажилтнуудтай хийсэн ярилцлагаас*

Мөн ярилцлагад хамрагдсан угаагч, үйлчлэгчдийн хувьд хүүхдүүдийг усанд оруулах, хувцсыг нь угаах тохиолдол их байдгийг дурдсаны зэрэгцээ эхэндээ зарим хүүхэд бие засах газрыг зохистой ашиглаж чаддаггүй, зааж зөвлөсний эцэст буюу 1-2 сарын дараа сурдаг гэсэн хариултыг өгчээ.

**Дотуур байрны ажилтнууд** ажлын байр болон ажлын чиг үүрэгтэй холбоотой сургалтад зарим үед хамрагддаг гэж хэлж байсны дотор:

эрүүл мэндийн төвөөс сургалт зохион байгуулдаг. Ариутгал, цэвэрлэгээний талаар сургалтууд ихэвчлэн явуулдаг очиж суудаг (жижүүр), ариутгалын бодисыг хэрхэн хэрэглэх. талаар зааж өгдөг (хоол зүйч), тэгш хамруулах боловсрол, боловсролын багц хууль гэх мэт сургалтуудыг нэрлэсэн.

Сэтгэл зүйн сургалт явдаг. Ерөнхийдөө хүүхдийн онцлогийн талаар 2 өдөр “Сэтгэл хөдлөлөө удирдах чадвар” гэсэн сургалт явагдсан.

*... аймгийн .....сумын дотуур байрны ажилтнуудтай хийсэн ярилцлагаас*

Ярилцлагад хамрагдсан тогооч, жижүүр багш нарын хувьд 7 хоног, 3 эсвэл 2 хоногийн сургалтад заримдаа оролцдог, ингэхдээ ажлаа зохицуулаад хамрагдахыг хичээдэг талаар дурдаж байсан. Эдгээр сургалтууд нь эрүүл зөв хооллолт – аймгийн БШУГ-аас зохион байгуулсан, эцэг эхтэй ажиллах, үдийн хоолтой холбоотой, хоолны орц норматив, аймаг сумдын дотуур байрны багш, жижүүрийн хооронд туршлага солилцох аян, хүүхэдтэй харилцах, эрсдлээс хамгаалах сургалт, хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт гэх мэт.

Хүүхэд хамгаалал, тэгш хамруулах сургалтад хамруулсан. Сая 10 сард хөтөлбөр, боловсролын тухай хууль танилцуулсан. Улиралд 1-2 удаа хамруулдаг. Сая 7 хоногт тогооч нар сургалтад хамрагдсан. Тогоочдын холбооноос зохион байгуулсан.

*Аймгийн төвийн сургуулийн дотуур байрны ажилтнуудтай хийсэн ярилцлагаас*

Тогоочийн сургалтад хамрагддаг. Аймагт л хийдэг. Хотын сургалтад үйлчлэгч, жижүүр нэг удаа ч хамрагдаж байгаагүй, багш нар л явдаг.

*Сумын сургуулийн дотуур байрны ажилтнуудтай хийсэн ярилцлагаас*

Зарим сургуулийн дотуур байрны ажилтнууд сургалтад хамрагдаж байсан гэхдээ олон жилийн өмнө, дотооддоо хааяа сургалт мэдээлэл авдаг (удирдлага, нийгмийн ажилтнууд) гэжээ.

Ямар нэг сургалтад хамрагдаж байгаагүй, сайн мэдэхгүй байна гэсэн хариултыг бас цөөнгүй өгсөн байгаа нь анхаарал татаж байна.

Ярилцлагад оролцсон тогооч нарын хувьд мэргэжлийн чиглэлийн сургалтад хамрагддаг талаараа тодорхой хэлж байсны дээр үр өгөөжтэй, ур чадвараа

дээшлүүлэхэд хэрэгтэй байдаг талаар дурдаж байсан. Тогооч нарын холбооноос сургалтууд зохион байгуулагддаг талаар тэд хэлж байсны зэрэгцээ зарим нь ачаалал ихтэй байдаг тул оролцдоггүй гэсэн хариултыг өгсөн байна.

Харин хүүхэд хамгаалалтай холбоотой сургалтын талаар ярилцлагад хамрагдсан зарим ажилтнууд бүрхэг ойлголттой байна.

Зарим аймаг, сумдын хувьд хүүхэд хамгаалалтай холбоотой сургалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулдаг гэсэн бөгөөд ихэвчлэн багш нар, нийгмийн ажилтнуудын дунд зохион байгуулагддаг талаар оролцогчид дурдсан байна. Тухайн сургалтад хамрагдсан багш нар сургуульдаа ирээд бусад ажилтан, ажилтдад мэдээлэл өгдөг тухай хэлсэн байна. Ярилцлагад хамрагдагчдын хариултаас үзэхэд дотуур байрны тогооч, үйлчлэгч, жижүүр буюу байрны багш нар нь энэ чиглэлийн сургалтад төдийлөн хамрагддаггүй, эсвэл тэднийг хамруулдаггүй талаар цөөнгүй тэмдэглэжээ. Иймээс энэ чиглэлийн сургалтад хамрагдах хэрэгцээ сонирхлоо зарим оролцогчид илэрхийлжээ.

Хүүхэд хамгааллын талаар сургалтад байрны багш, нийгмийн ажилтан, сумын байгууллагуудаас хүмүүс ирж зохион байгуулдаг. Сая намраас хойш 2-3 удаа болсон. Гэхдээ хүүхдүүдэд зориулсан.

**Ярилцлагаар сургуулийн буюу** удирдлагын зүгээс авдаг дэмжлэгийн талаар тодруулж асуухад ажлын орчин нөхцөлийн талаар санаа тавьж, анхаардаг, ажил хөнгөвчлөх зорилгоор тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж, цахилгаан тоног төхөөрөмжөөр хангасан, төсөл хөтөлбөрийн хүрээнд гал тогоог тохижуулж өгсөн, бүрэн засвар хийсэн, хэрэгтэй, шаардлагатай зүйлийн талаар тогтмол асууж анхаардаг гэдэг хариултыг дотуур байрны тогооч, туслах тогоочид нийтлэг хариулсан байна.

Сургуулийн захирал өдөр бүр шахам дотуур байранд ирж, юу болж байна, юу болохгүй байгаа талаар тодруулж асуугаад, аль болох хурдан хугацаанд шийдвэрлэж өгөхийг хичээдэг, арга хэмжээ авдаг. Жишээлэхэд, саяхан ширээ сандлыг шинэчилсэн.

*Дотуур байрны ажилтнуудтай хийсэн ярилцлагаас*

Түүнчлэн сургуулийн удирдлагын зүгээс аюулгүй байдлын талаар зөвлөгөө, зөвлөмж өгдөг, санаа тавьдаг, боломжийн хэрээр тусалдаг, хэрэгтэй зүйлд дэмжлэг өгдөг, тал талаасаа дэмжээд ажиллахад болж байна гэж хариулжээ. Дотуур байрны үйлчлэгчдийн хариулсан байдлаас үзэхэд шаардлагатай хувцас хэрэглэл, цэвэрлэгээний материал, хэрэгслээр хангаж, заавар зөвлөгөө өгдөг тухай дурджээ.

Дэмжлэгийн тал дээр захирал нярав, нягтлан 3 хамтран ажиллаад бид нарт заавар зөвлөгөөгөө өгөөд, ямар нэг бэрхшээл гарахад бид захирал, нярав, эмчдээ хэлээд, тэд хамтран тухайн нөхцөлд нь тааруулаад арга хэмжээ авчихдаг. Ямар ч байсан дэмжлэг үзүүлээд байдаг.

Харин дэмжлэг үзүүлдэггүй, нийгмийн ажилтан зэрэг хүмүүс ажилладаггүй, зөвхөн ажлын чиглэл өгдөг, уг ажлыг хариуцаад удаагүй тул сайн мэдхэгүй байна, хэмээн зарим оролцогч шүүмжлэлтэй хандсан байна.

Дотуур байранд суудаг хүүхдүүдийн хөгжил, хамгааллын чиглэлээр хамтарч ажилладаг талаараа ярилцлагад оролцогчид хэлэхдээ:


Хүүхэд хамгааллын чиглэлээр:

- Байрны багштайгаа хамтарч ажилладаг. Бүх л чиглэлээр хамтарч уялдаж ажилладаг.
- Байнгын хамтарч хүүхдийн аюулгүй байдалд анхаарал тавьдаг.
- Байрны багш, ажилтнуудтай хамтарч ажилладаг.
- Дотуур байрны хүүхдүүдийн эрх, хамгаалал хамтарсан багийн үйл ажиллагаа сэдэвт сургалтуудыг тогтмол явуулдаг.
- Байрны багшийн саналыг сонсдог. Хүүхэд хамгааллын талаар гараас гарт гэх мэтээр хамтарч ажилладаг.
- Зарим тохиолдолд байрны багш нь жижүүр багшийн хамт хонож хүүхдийн аюулгүй байдалд санаа тавьдаг гэх мэт хариултуудыг нийтлэг өгсөн байна.
- Ажлаас буугаад явсан ч багштай холбоотой ажилладаг. Хүүхдүүдээ бүртгэж эцэг эх болон багштай холбогддог. Эхлээд багш, эцэг эх цаашлаад дараагийн шатны хүмүүстэй холбогддог.
- Хүүхдүүдийг ажиглаж хооллолт дээр нь анхаарч мэдээлэлдэг.
- Дотуур байр бүрэн камержсан байдаг нь хүүхдийн аюулгүй байдлыг хангахад сайн нөлөөтэй.

Ер нь хүүхэд хамгааллын чиглэлээр байрны багш, жижүүр, үйлчлэгч, тогооч зэрэг дотуур байрны ажилтнууд сургуулийн удирдлага, бусад багш, нийгмийн ажилтан, эцэг эх, асран хамгаалагчидтай байнга холбоотой ажиллаж, ажиглах, тэмдэглэх, зөвлөх, шаардлага тавих гэх мэтээр тасралтгүй ажилладаг нь ярилцлагын явцад тэмдэглэгдсэн байна.

Мөн дотуур байрны багшаас авсан судалгаагаар 54 хувь нь сургуулийн удирдлага, багш, ажилтнуудын хамтын ажиллагаа сайн гэж үзсэн байна.

Зураг 36. Сургуулийн удирдлага ба дотуур байрны багш, ажилтнуудын хамтын ажиллагаа



Хүүхэд болгон дээр чинь судалгаа авна, тэгээд ингэж байна тэгж байна гээд бид хэд чинь тэгээд ар гэрийнхэнтэй нь холбогдоно, ангийн багштай нь холбогдоно, харилцан ярилцана, ер нь тэгээд л хүүхдүүдийнхээ өөрийн зан онцлогт тохируулаад л нэлээн судалгаа авч ажилладаг шүү дээ.

Дотуур байрны ажилтнуудтай хийсэн ярилцлагаас

Харин хүүхдийн хөгжил чиглэлээр:

- Хэд хэдэн төрлийн клубтэй бөгөөд тогтмол үйл ажиллагаа явуулдаг,
- Хүүхэд хөгжлийн өрөөтэй, тэнд сургалт явуулдаг.

- Төрөл бүрийн тэмцээн уралдаан зохион байгуулах, амралтын өдрүүдээр зааланд тоглуулах, хичээл давтуулах, сургуулийн номын санчтай хамтарч ажиллах, гэх мэтээр хамтран ажилладаг талаар оролцогчид санал нэгтэй хариулсан байна.

Хоёр багштайгаа л хамтарч ойр ажилладаг. Хүүхдийн хичээлийн хоцрогдол дээр санаа тавьж ярилцдаг. Ямар нэг үйл ажиллагаа зохион байгуулахаараа бид нар тойрч сууж байгаад жилийн төлөвлөгөө гаргаад, үйл ажиллагаа, сургалт зохион байгуулдаг. Хүүхдүүдтэйгээ ярилцдаг.

*Дотуур байранд хүүхдийн эрхийн зөрчил үүссэн тохиолдолд авах арга хэмжээ, нэгдсэн зураглал байдаг эсэх, үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг талаар* тодруулахад дотуур байранд хүүхдийн эрхийн зөрчил үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах зураглал тэр бүр байдаггүй талаар ярилцлагад оролцогчид нийтлэг хариулжээ. Ийм зураглал байгаа гэж зарим оролцогч хариулсан ч тодорхой хэлээгүй, бүрхэг байна. Мөн зарим оролцогч нь зөрчлийн эсрэг хариу арга хэмжээ авах зураглал гэж мэдэхгүй, тэр талаар ойлголтгүй байна гэжээ.

Дотуур байранд хүүхдийн эрхийн зөрчил үүссэн тохиолдолд ямар хариу арга хэмжээ авах зураглал байгаа. Эрхийн зөрчил үүсэн тохиолдолд ярилцаж, дараа нь аав ээж, багш нар, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч гээд шат дараалан 3 сургуулиараа хамтран ажилладаг.

*Дотуур байрны ажилтнуудтай хийсэн ярилцлагаас*

Хүүхдийн эрхийн зөрчил үүсэх тохиолдол гарах нь цөөн байдаг талаар тэд нийтлэг хэлсэн бөгөөд хэрэв ямар нэг зөрчил гарвал тухайлбал, хүүхдүүд муудалцах, биенээ шоглох гэх асуудал мэр сэр гарвал хамгийн түрүүнд байрны багш, нийгмийн ажилтанд мэдэгдэж арга хэмжээ авч, шаардлагатай бол эцэг эх, АУБ-д ханддаг талаар оролцогчид хэлжээ. Мөн сургуулийн сэтгэл зүйчтэй тохиолдолд хамтран ажилладаг талаар дурдсан байна. Дотуур байруудыг бүрэн камержуулсан байдаг тул зөрчил гарахаас сэргийлэхэд тустай тал дээр оролцогчид санал нэгтэй хариулсан байна.

Камержуулсан, эрэгтэй эмэгтэй хүүхдүүд тусдаа тул аюулгүй байдал хангагдсан гэж үздэг.

*Дотуур байрны ажилтнуудтай хийсэн ярилцлагаас*

Ярилцлагад хамрагдсан дотуур байрны ажилтнуудын зүгээс энэ асуултын хүрээнд хэлж, анхааруулж байсан зүйлийн дотор эцэг эх, асран хамгаалагчдын хариуцлага, ухамсар хангалтгүй байгаа, хүүхдэдээ тавих анхаарал халамж хангалтгүй, сургууль болон дотуур байрны багш, ажилтнуудтай хамтран ажиллах тал дутмаг байгаа зэрэг асуудлууд дурдагджээ.

**Дотуур байранд хүүхдийн аюулгүй байдал хэрхэн хангагдсан, ажилтнуудын зүгээс энэ тал дээр яаж анхаардаг талаар асуухад** дотуур байранд суудаг хүүхдүүдийн аюулгүй байдал ерөнхийдөө хангагдсан байдаг гэж ярилцлагад оролцогчдын ихэнх нь мэдээлсэн байна.

Хүүхдүүдийнхээ аюулгүй байдлыг чадах чинээгээрээ л хангах гэж хичээдэг. Жишээ нь нэгдүгээр давхрынхаа хүүхдийн өрөөний цонхонд тор хийсэн, бага ангийн хүүхдүүдэд өдөр тутам тусалж дэмжинэ, гадаа бие засах газар руу явах зам гэрэлтэй байдаг, яг хажууд нь мэдрэгчтэй гэрэлтэй. Аюулгүй байдал хангагдсан гэж үздэг. Цонхоо торлочихсон, жижүүр байнга байна, тойроод камержуулсан байгаа.

*Дотуур байрны ажилтнуудтай хийсэн ярилцлагаас*

Ярилцлагад оролцогчид дотуур байрны аюулгүй байдлын талаар хэлэхдээ голчлон орчны талаар дурдсан буюу гэрэлтүүлэг, камержуулалт, халаалт, хоолны хүрэлцээ, цонх торлосон байдал гэх мэт ерөнхий тохижилтыг тодруулж ярьсан байна.

Зарим оролцогчид аюулгүй байдлыг үнэлэхдээ “60-70 хувь”, “80 хувь” гэх зэргээр хэлсэн байгаагийн шалтгааныг “дотор бие засах газаргүй, машин замд ойр, цахилгааны утас зэрэг нь асуудалтай, барилга байгууламж хуучных болохоор хүйтэн, сургууль болон дотуур байр эмчгүй /ялангуяа сумын сургуулиуд/” гэх мэтээр хэлжээ.

Цөөн хэдэн дотуур байрны хувьд камержуулалт байхгүй, дутагдалтай байгаа нь аюулгүй байдлын талаас асуудал үүсгэж байгаа тухайг мөн дурдсан байна. Байрны багш нь жижүүртэй хамтран ээлжээр хонож жижүүрлэдэг тухай цөөнгүй оролцогчид дурдсаны дээр, энэ нь хүүхдүүдийг ямар нэг эрсдлээс сэргийлэх, гадны хүн дотуур байранд нэвтрэх, хүүхдүүд хяналтгүйгээр гарч орох зэргээс хамгаалах зорилготой, ялангуяа шөнө оройн цагаар гэдэг талаар тэмдэглэжээ.

Тохижилт дээр нэлээн анхаарч байгаа. Тасаг болгонд номын тавиур хийж өгсөн. Сургуулийн нөөц бололцоогоор ажиллаж байна. Хүүхдийг гараас гарт гэсэн зарчмаар бид ажилладаг.

*Дотуур байрны ажилтнуудтай хийсэн ярилцлагаас*

**Цаашид дотуур байранд ажиллах хүсэл эрмэлзэлтэй эсэх талаар** ярилцлагад хамрагдсан дотуур байрны ажилтнуудын ихэнх нь цаашид ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна. Ялангуяа, байрны жижүүр, тогоочид хүүхдүүдтэй ажиллахдаа сэтгэлээсээ ханддаг, энэ ажилдаа дуртай гэдгээ дурдсан бөгөөд тэдний бараг 60 орчим хувь нь тухайн сургууль, сургуулийн дотуур байрандаа ажиллаад олон жил болчихсон учраас тэтгэвэрт гартлаа эндээ ажиллана гэсэн хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Энэ хариултыг ялангуяа сумын сургуулийн дотуур байрны ажилтнууд илүү өгсөн байгаа нь анхаарал татаж байна.

Ажиллах гэж орсон учраас цаашид ажиллаад явна. Би тэтгэвэрт гартлаа ажиллана. Өмнө цэцэрлэгийн багш байж байгаад энэ ажилд орсон. Ажилдаа сэтгэл хангалуун байдал гайгүй. Хүүхдүүдтэйгээ болоод байдаг учраас ажлаас гаръя гэсэн бодол байдаггүй, ажлаас гарах бодол байдаггүй. Тиймээс ажиллана, хүүхдүүдийн хандлага харилцаа сайн байдаг гэгээлэг ажилдаа дуртай байдаг.

*Дотуур байрны ажилтнуудтай хийсэн ярилцлагаас*

## Дүгнэлт

- Дотуур байрны багшаар ажиллаж байгаа хүмүүсийн 5 хувь нь бусад мэргэжлийн, бүрэн дунд буюу тусгай дунд боловсролтой, 31 орчим хувь нь 5-аас доош жил ажилласан хүмүүс байгаа нь 2008 онд батлагдсан ЕБС-ийн дотуур байрны багшийн ажлын байрны тодорхойлолтын тавигдах шаардлага, 2019 онд батлагдсан дотуур байрны стандартын хүний нөөцөд тавигдах шаардлагын

“Дотуур байрны багш нь багш эсвэл нийгмийн ажилтан мэргэжилтэй 5-аас доошгүй жил хүүхэдтэй ажилласан туршлагатай байна” гэсэн заалт бүрэн хэрэгжихгүй байна.

- Дотуур байранд амьдардаг сурагчдыг жилд нэгээс хоёр удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг байна. Стандартын 7.13-д “Багш, ажилтнуудыг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна” гэж заасан ч бидэнд энэ талаар өгөгдөл байхгүй байна.
- Амьдралын зөв дадал хэвшил олгох зорилготой сургалт, зөвлөгөө болон уралдаан, тэмцээн дотуур байранд хамгийн их зохиогддог байна.
- Улсаас дотуур байрны багш нарт зориулсан сургалт жил бүр явдаг ч хүүхдийн хөгжил, ихэвчлэн хамгааллын чиглэлээр зохиогддог байна. Гамшгийн үеийн сургалт, дадлагад хамруулах, хүүхдийг гамшиг ослоос авран хамгаалах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, гал унтраах хэрэгслийг зөв ашиглах чадвар дадал эзэмшүүлэх, цэвэрлэгээ халдваргүйжүүлэлт хийх чиглэлийн сургалтыг зохион байгуулдаггүй байна.
- Улсаас жилд нэг удаагийн сургалт хийхээс бусдаар орон нутаг болон сургуулийн удирдлагын зүгээс багш нарт зориулсан сургалт бараг явагддаггүй байна.
- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хүүхдийн хөгжил, төлөвшлийн чиглэлээр хамгийн их хамтран ажилладаг гэж судалгаанд хамрагдсан багш нарын 67.4 хувь нь хариулсан байна. Ингэхдээ багш нар эцэг эх, асран хамгаалагчдад энэ чиглэлийн мэдээ, мэдээлэл бүхий самбарыг тогтмол ажиллуулж мэдээ, мэдээллийг хүргэхээс гадна мэдлэг, чадвар, туршлага, хамтын ажиллагааг нь дэмжин ажилладаг байна.
- Бага ангийн сурагчдын хичээлд дотуур байрны багш нар сайн тусалдаг байна. Дотуур байрны багш нь сурагчдын гэрийн даалгавраа хийхэд нь тусалж дэмжинэ гэж дотуур байрны стандартад заасан байна. Хичээлд нь тусалж чаддаггүй, зөвхөн бага ангийн сурагчдад тусалдаг гэж хариулсан багш нарын хувьд хүүхдийн тоо их, дунд, ахлах ангийн сурагчдад цаг зав гардаггүй, хичээл нь хүнд учир зааж өгч чаддаггүй, дунд, ахлах ангийн сурагчид тусламж хүсдэггүй гэж хариулсан байна.
- Дотуур байрны багш нарын 57 хувь нь цаашид дотуур байрны багшаар ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ тэдний ажлын ачаалал, цалин хөлс, нэмэгдэл зэрэг дээр анхаарч өгөх хүсэлтийг гаргах нь нийтлэг байна. Мөн дотуур байрны ажилтнуудын хувьд ажлын ачаалал ихтэй, туслах ажилтан хомсдолтой, цалин мөнгөний хүрэлцээ муу байгаа талаар ихэнх нь хэлсэн байна.
- Ярилцлагад хамрагдсан дотуур байрны ажилтнуудын ихэнх нь цаашид ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна. Ялангуяа, байрны жижүүр, тогоочид хүүхдүүдтэй ажиллах ажилдаа сэтгэлээсээ ханддаг, энэ ажилдаа дуртай гэдгээ дурдсан бөгөөд тэдний бараг 60 орчим хувь нь тухайн сургууль, сургуулийн дотуур байрандаа ажиллаад олон жил болчихсон учраас тэтгэвэрт гартлаа эндээ ажиллана гэсэн хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ.
- Дотуур байрны багшийн хомсдол бий болох магадлал байна. Цаашид багшаар ажиллах хүсэлгүй гэж хариулсан багш нарын ихэнх хувь нь багшийн цагийн ачаалал их, илүү цагаар ажилладаг, цалин бага ч хариуцлага өндөртэй учир цаашид ажиллах хүсэлгүй гэж хариулсан бол, зарим багш нарын хувьд мэргэжлийнхээ дагуу ажиллах хүсэлтэй, эцэг эх, сургуулийн удирдлагаас дарамт

их учир ажиллах хүсэлгүй гэж хариулсан байна. Ажил хүсэлгүй багш нар 30-40 насны залуу багш нар байна.

- Тогооч нарт амралтын өдөр ажилладаг, ажлын ачаалал ихтэй ч илүү цаг тооцож олгодоггүй байна.
- Дотуур байрны судалгаанаас харахад дотуур байрны багш ажлын байрны чиг үүргийн хүрээнд үндсэн зорилтуудаа ханган ажилладаг байна.

### **Санал, зөвлөмж**

- Дотуур байрны багш нарт хүүхдийг гамшиг ослоос авран хамгаалах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, гал унтраах хэрэгслийг зөв ашиглах чадвар дадал эзэмшүүлэх чиглэлээр гамшгийн үеийн сургалт зохион байгуулах
- Дотуур байрны багшийг бусад мэргэжлийн багш нартай адил илүү цаг тооцох, нэмэлт урамшуулал олгох, 40 хоногоор амралт тооцдог болгох
- Дотуур байранд хүүхдүүд эд зүйлээ хулгайд алдах тохиолдол гардаг гэж дотуур байрны багш нарын 79 хувь нь хариулсан байна. Иймээс дотуур байрны багш, ажилтан, сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан, дотуур байрны хүүхдүүд, эцэг эх, харгалзан дэмжигчид хамтран аюулгүй байдлыг ханган ажиллах хэрэгцээ байна.
- Сургуулийн удирдлага, багш, ажилтан, сурагч, эцэг эхийн хоорондын хамтын ажиллагаа сайн байдаг гэж хариулсан ч орон нутгийн хүүхдэд үйлчилдэг төрийн ба төрийн бус байгууллага, өмчийн олон хэлбэрийн үйлдвэр аж ахуйн нэгж, сум/хорооны нийгмийн ажилтан, хүүхдийн элч, хамтран ажиллагч мэргэжлийн хүмүүстэй хамтын ажиллагааг сайжруулах
- Дотуур байранд төсөвлөдөг санхүүжилт нь багш, ажилтнуудын цалин, хүүхдийн хоолны зардал, урсгал зардлууд байдаг нь багшийн материаллаг орчны буюу утас, компьютер, принтер, ширээ, сандал, шаардлагатай бичиг хэргийн хэрэгсэл, гарын авлагаар хангана гэсэн дотуур байрны багшийн ажлын байрны тодорхойлолтын 16 дугаар заалт хэрэгжихгүй байна.
- Зарим дотуур байрны хувьд хоолны орц, норм хүртээмжийн талаар санал хүсэлт эцэг эх, асран хамгаалагчдаас ирдэг байна. Мөн хүүхдүүд, ялангуяа ахлах ангийн хүүхдүүдийн хоолны хүртээмж хангалтгүй, өлсдөг гэсэн санал хүсэлт ирдэг сурагчдаас бас ирдэг байна. Иймээс дотуур байрны нэг хүүхдэд өгдөг хоолны орц нормыг хэрхэн нэмэгдүүлэх боломжийн талаар судлах
- Хүүхдүүдэд хүний эрх, хүүхэд хөгжил хамгааллын чиглэлээр сургалт орж эрхийг нь таниулдаг ч үүргийг нь тэр бүр таниулдаггүй байна. Иймээс дотуур байрны сурагчдад хүүхдийн эрхийн чиглэлээс гадна хүлээх үүрэг хариуцлагын чиглэлээр сургалт, мэдээлэл явуулах
- Дотуур байрны ажилчдад сургуулийн удирдлагын зүгээс ажлын байртай холбоотой тусламж, дэмжлэг сайн үзүүлдэг гэж судалгаанд оролцсон хүмүүс хариулсан ч нийгмийн баталгааг хангуулах чиглэлээр үзүүлдэг дэмжлэгийн талаар хэн ч хариулт өгөөгүй байна.


## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ДОТУУР БАЙРНЫ МЕНЕЖМЕНТ, ТҮНШЛЭЛ ХАМТЫН АЖИЛЛАГАА

### 4.1 Ерөнхий мэдээлэл

Дотуур байрны менежмент, түншлэл, хамтын ажиллагааны талаар сургуулийн удирдлагаас асуулгын аргаар судалгаа авахад 21 аймаг, сумын 264 дотуур байрны удирдах ажилтан хамрагдсаны 68.9 хувь захирал, 31.1 хувь нь сургалтын менежер байна. Мөн ЗДТГ-ын 136 мэргэжилтэн хамрагдсан байна. Судалгаанд сумын сургуулийн дотуур байр 81.4 хувийг эзэлж байгаа бөгөөд багийн сургууль хамрагдсан нь 7.3 хувьтай байна.


Сургуулийн захирал, сургалтын менежерүүдийн 39.8 хувь нь эмэгтэй, 60.2 хувь нь эрэгтэй байна.

Зураг 37. Асуулга судалгаанд хамрагдагсдын нас (мэргэжилтэн, сургуулийн удирдлага)




ЗДТГ-ын мэргэжилтнүүдийн ихэнх нь 39 хүртэлх насныхан байгаа бол сургуулийн удирдлагын олонх нь 40-49 насны оролцогчид байна. 50-аас дээш насныхан бага хувийг эзэлж байна.

Зураг 38. Сургуулийн захирал (сургалтын менежер)-аар ажиллаж буй жил



Судалгаанд хамрагдсан сургуулийн захирал, сургалтын менежерүүдийн 50-иас дээш хувь нь 6-аас дээш жил ажилласан байгаагаас үзэхэд сургууль болон дотуур байрны орчин нөхцлийн талаар мэдлэг, туршлагатай байгааг илэрхийлж байна.


Зураг 39. Мэргэжилтнээр ажиллаж буй жил





ЗДТГ-ын мэргэжилтнүүдийн ажлын туршлага буюу ажилласан жилийг авч үзвэл 50 орчим хувь нь 6-гаас дээш жил ажилласан байна.

Зураг 40. Боловсролын зэрэг, хувиар



Асуулга судалгаанд хамрагдсан сургуулийн захирал, сургалтын менежерүүдийн 58.0 хувь нь магистр зэрэгтэй бол ЗДТГ-ын мэргэжилтнүүдийн ихэнх нь буюу 79.4 хувь нь бакалаврын зэрэгтэй байна.

#### 4.2. Дотуур байрны хөгжилд сургуулийн удирдлагын үүрэг, хариуцлага

Сургуулийн бодлого тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд талуудын оролцоог хэр хангадаг талаар сургуулийн удирдлагаас асууж тодруулахад, дотуур байрны багшийг оролцуулдаг гэсэн хариулт нь хамгийн өндөр буюу 98.6 хувьтай, бусад талууд болох эцэг эх, асран хамгаалагч, тогооч, үйлчилгээний ажилтан, жижүүр манаачийг оролцуулдаг гэсэн хариултыг 79.1- 85.0 хувь нь өгчээ. Мөн хүүхдүүдийг татан оролцуулдаг цөөхөн ч бодлого боловсруулах, шийдвэр гаргахад талуудын оролцоог хангах гэж оролдож байгааг илэрхийлж байна.

Дотуур байрны үйл ажиллагааг төлөвлөх чиглэлээр, сургуулийн бодлого тодорхойлохдоо оролцогч талуудыг хэр татан оролцуулдаг тухай асуухад дотуур байрны багштай 68.2 хувь нь, ажилтнуудтай 48.9 хувь нь 7 хоног бүр уулздаг гэж хариулсан бол хүүхдүүдтэй сар бүр, эцэг эхчүүдтэй улирал бүр уулздаг гэж тэдний 50 орчим хувь нь хариулснаас үзэхэд дотуур байртай холбогдох талуудтай тогтмол холбоотой байдаг нь харагдаж байна.

Дотуур байрны үйл ажиллагааны чиглэл, хөгжлийн төлөвлөлтийг сургуулийн бодлоготой уялдуулдаг гэдэгтэй сургуулийн удирдлагууд бараг бүрэн санал нийлсэн бөгөөд “Сургуулийн үйл ажиллагааны нэг хэсэг болдог” тул уялдуулдаггүй гэсэн хариултыг цөөн оролцогч өгчээ.

Дотуур байрны менежментийг хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодруулж асуухад эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо, хамтын ажиллагаа хангалтгүй байдгаас гадна орчин нөхцөл (барилгын насжилт хэтэрсэн, номын сангүй, ариун цэврийн байгууламж хангалтгүй, дэд бүтэц хөгжөөгүй гэх мэт), хүний нөөцийн хүрэлцээ, хүүхдийн тоо их зэрэг асуудлуудыг дурдсан бөгөөд хамгийн тулгамдаж буй асуудал нь төсөв санхүү хангалтгүй байдаг гэж судалгаанд хамрагдагчдын дийлэнх нь хариулжээ.

Хүснэгт 23. Дотуур байрны төсвийн санхүүжилтийн зарцуулалт

	тийм	үгүй
дотуур байрны интернэт, компьютер, тоног төхөөрөмжийг сайжруулахад	25.9	74.1
тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийг дэмжихэд	8.6	91.4
номын сангийн фондыг нэмэгдүүлэхэд	11.8	88.2

*Дотуур байрны нөхцөл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа*


хоол хүнсний материалд	82.7	17.3
барилга байгууламжийн урсгал зардалд	60.9	39.1
эрүүл мэндийн үзлэг үйлчилгээнд	44.1	55.9
хүүхдийн сурч боловсрох, хөгжих үйл ажиллагаанд	53.6	46.4
хүүхдийн эрх хамгааллын үйл ажиллагаанд	59.5	40.5

Хүснэгтээс харахад санхүүжилтийг голчлон хоол хүнсний материал болон барилга байгууламжийн урсгал зардалд зарцуулдаг байна. Түүнчлэн хүүхдийн сурах, хөгжих болон хүүхдийн эрх хамгааллын үйл ажиллагаанд зарцуулдаг гэж талаас илүү хувь нь хариулжээ.

Дотуур байрны хүүхдийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахад эцэг эх, асран хамгаалагчийг оролцуулдаг талаар асуухад “заримдаа” гэсэн хариултыг сургуулийн захирал, сургалтын менежерүүдийн 83.6 хувь нь өгчээ.

Дотуур байрны багш нар бусад багш нартай хамтран ажиллахад нь сургуулийн удирдлагын зүгээс дэмжлэг үзүүлдэг гэдэгтэй 63.6 хувь нь бүрэн санал нийлж, харин 35.0 хувь нь “заримдаа” гэсэн хариултыг өгсөн байна. Дотуур байрны орчин нөхцөл, хоол хүнсний талаар сургууль өөрийн үнэлгээ хийдэг гэсэн хариултыг сургуулийн удирдлагуудын 64.5 хувь, “заримдаа” гэсэн хариултыг 35.0 хувь нь өгчээ. Өөрийн үнэлгээ хийгээд, үр дүнг нь хэрхэн ашигладаг талаар тодруулж асуухад ерөнхийдөө дотуур байрны үйл ажиллагааг сайжруулахад чиглэдэг гэдэг хариулт давамгайлсан.

*Зураг 41. Өөрийн үнэлгээний үр дүнг ашигладаг байдал*



Дээрх графикаас харахад, “дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулах, хүүхэд хөгжүүлэх”-эд өөрийн үнэлгээний үр дүнг ашиглах нь хамгийн бага байгаа нь харагдаж байна.

*Хүснэгт 24. Дотуур байрны менежментийг сайжруулснаар гарах өөрчлөлт*

	тийм	үгүй
суралцагчийн сурлагын амжилт, хөгжил, төлөвшилд	90.5	9.5
суралцагчийн хандлага, эрүүл мэндэд	79.1	20.9
байгууллагын соёл, хамт олны уур амьсгалд	64.1	35.9
үйл ажиллагааны зохион байгуулалтад	49.1	50.9
байгууллагын удирдлага, манлайлалд	26.4	73.6
сургалтын орчин хэрэглэгдэхүүнд	42.3	57.7
багшийн хөгжил, хандлагад	44.1	55.9
түншлэл-хамтын ажиллагаанд	40.0	60.0

Дотуур байрны менежментийг сайжруулах нь юуны өмнө суралцагчдын сурлагын амжилт, хөгжил, төлөвшилд эерэг өөрчлөлт гарна гэж асуулгад хариулагчдын 90.5 хувь үзжээ. Түүнчлэн суралцагчийн хандлага, эрүүл мэнд, байгууллагын ерөнхий соёл, уур амьсгал сайжирна гэсэн хариултыг түлхүү өгсөн байна.

Сургуулийн менежментийг нэвтрүүлж хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэгийн талаар тодруулахад өгөгдсөн бүх чиглэлд дэмжлэг авах сонирхолтой байгаагаа илэрхийлсний дотроос сургалтын орчин, хэрэглэгдэхүүн (62.3%), багшийн хөгжил, хандлага (65.5%), суралцагчийн сурлагын амжилт, хөгжил, төлөвшил (66.4%) болон суралцагчийн хандлага, эрүүл мэнд (61.4%) зэрэгт хамгийн их шаардлагатай байгаагаа илэрхийлжээ.

Дотуур байрны үйл ажиллагаа, хүүхэд бүрийн ахиц амжилт, хөгжлийн талаар тайланг тогтмол танилцуулдаг, ялангуяа улирал бүр гэж судалгаанд оролцогчдын 51.4 хувь нь хариулжээ.

Дотуур байрны нөхцөл байдал, хүчин чадлаас үл хамааран жилд 20-250 хүүхэд дотуур байранд суух хүсэлт гаргадаг бөгөөд хүсэлт гаргасан хүүхэд бүрийг аль болох боломжоороо хамруулдаг талаар сургуулийн захирал, сургалтын менежерүүд хэлсэн бөгөөд хэрэв багтаагүй, орж чадаагүй тохиолдолд садан төрлийндөө суудаг, эцэг эх, асран хамгаалагчдад тайлбарладаг, зөвлөмж өгдөг, тэдэнтэй хамтран өөр шийдэл хайдаг гэжээ.

Үүнээс үзэхэд дотуур байранд хүүхдээ оруулахдаа эцэг эх, асран хамгаалагчид нь сургуулийн захирал болон байрны багштай ярилцаж оруулдаг ба зарим тохиолдолд хүүхдийн амьдарч буй сум болон багийн дарга нар тухайн айлын амьдралыг мэдэж хүүхдийн эрхийг хамгаалахын тулд байранд оруулах тохиолдол байдаг ажээ.

Манай том хүүхэд одоо оюутан. Тэр маань 1-р ангид манай эгчийн гэрт байсан. Дараа жилээс дүү нь хичээлд орсон. 2 хүүхэд нэг айлд байх хэцүү байсан. Тэгээд 2 хүүхдээ байранд байлгахар шийдээд, байрны багштай уулзаж ярьсан. Дараа нь нэг өрөөнд 2-уулаа амьдардаг болсон. 9 сарын 1-нд байрандаа ирээд л шууд өөрсдийн өрөөндөө ордог.

..... аймгийн ..... сумын ..... ээжийн ярианаас


Эцэг эх, асран хамгаалагчид дотуур байранд мөнгөн хандив оруулсан гэдэг хариултыг судалгаанд хамрагдсан сургуулийн захирал, сургалтын менежерүүдийн 24 хувь нь өгчээ.

Үүнтэй холбоотойгоор эцэг эх, асран хамгаалагчдаас тодруулж ярилцахад хүүхдээ дотуур байранд амьдарч байх хугацаанд нь үйл ажиллагааг нь дэмжих зорилгоор амьдарч буй өрөө тасгийг нь тохижуулах, камержуулах, гэрэл солих, өрөөг нь хулдааслах, цонхыг нь дулаалах, ширээ сандал хөшиг, дэвсгэр, өрөөг нь тохижуулах зорилгоор ойролцоогоор 50.000 төгрөг хүртэлхийг хураалгадаг гэж хариулсан байна.

### **4.3. Дотуур байрны хөгжилд орон нутгийн дэмжлэг, оролцоо**

Дотуур байрны өнөөгийн байдлын талаарх судалгаанд хамрагдсан орон нутгийн ЗДТГ-ын мэргэжилтнүүдээс дотуур байрны нөхцөл байдалтай өнгөрсөн жил танилцсан эсэхийг тодруулж асуув.

Зураг 42. Дотуур байрны нөхцөл байдалтай танилцсан эсэх



Судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдийн хариултаас үзэхэд өнгөрсөн хичээлийн жилд дотуур байрны нөхцөл байдалтай ихэнх нь танилцсан бөгөөд жилийн төлөвлөгөө, үйл ажиллагаанд тусган ажилласан гэдэг хариултыг 78.9 хувь нь өгсөн байна. Эсрэг хариултыг өгсөн мэргэжилтнүүдийн хувьд “Төлөвлөгөө оны эхэнд гарсан, ажлын чиг үүрэгт тусгагдаагүй” гэсэн хариулт зонхилжээ.

Судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдийн 90.2 хувь нь дотуур байрны асуудлаар сургуулийн захиралтай ерөнхийдөө уулзаж ярилцдаг бөгөөд голчлон хүүхдийн сурч боловсрох, хөгжих болон тэдний эрх, хамгааллын талаарх асуудлыг хэлэлцсэн гэжээ. Энд орон нутгийн байгууллагуудын хандив тусламж болон мөнгө санхүүгийн дэмжлэгийн тухайд 20 хүрэхгүй хувь нь “тийм” гэсэн хариултыг өгсөн нь материаллаг талын тусламж дэмжлэг хангалтгүй байсныг харуулж байна.

Орон нутгийн төсөвт дотуур байрны хөрөнгө оруулалт тусгагдсан байдаг гэж судалгаанд оролцогчдын 71.4 хувь нь хариулсан байгаа ч энэ нь голдуу дотуур байрны тохижилт үйлчилгээ, барилга байгууламжид чиглэсэн байдаг гэж хариулснаас үзэхэд бусад асуудал, тухайлбал, эрүүл мэндийн үзлэг үйлчилгээ, хүүхдийн хөгжилд зарцуулах нь хангалтгүй байгааг илэрхийлж байна гэж үзэж болохоор байна.

Орон нутгийн иргэдээс дотуур байртай холбоотой санал хүсэлтүүд ирдгээс хамгийн гол нь барилга байгууламж, дотуур байрны тохижилт, үйлчилгээ, хоол хүнс гэдгийг голчлон тэмдэглэсний зэрэгцээ хүүхдийн сурч боловсрох, хөгжих, хүүхдийн эрх, хамгаалал болон багш нарын харилцаа хандлагын талаар ч иргэдийн 30 орчим хувь нь санал хүсэлт ирүүлдэг болохыг дурджээ.

Иргэд, олон нийтээс ирсэн санал хүсэлтийг шийдвэрлэдэг олон арга замуудыг дурдсаны дотор:

- Холбогдох газар, удирдах шатны хүмүүс, Засаг даргад танилцуулан, ЗДТГ, ИТХ-аар хэлэлцдэг шийдвэрлэдэг,
- Холбогдох албан тушаалтнуудад танилцуулдаг, орон нутгийн хийгдэх ажилд санал оруулдаг,
- Хамтарсан багийн хурлаар оруулан хэлэлцэж, шийдвэрлэдэг,
- Аль болох тухай бүрд нь нөөц бололцоондоо тулгуурлан арга хэмжээ авдаг, шийдвэрлэдэг гэсэн хариултауд зонхилсон байна .

Түүнчлэн төлөвлөгөөнд тусгадаг, аймаг, орон нутгийн зүгээс хийх ажилд санал оруулдаг, сургуулийн удирдлага, захирал зэрэг холбогдох хүмүүстэй уулзалт хийдэг зэрэг хариултыг өгсөн байна.

Хүснэгт 25. Сургуулийн зүгээс шаардлагатай дэмжлэг

	тийм	үгүй
барилга байгууламж	39.1	60.9
хоол хүнс	26.3	73.7
тоног төхөөрөмж	41.4	58.6
тохижилт, үйлчилгээ	59.4	40.6
эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээ	23.8	76.2
хүүхдийн сургалт, хөгжил	47.4	52.6
хүүхдийн эрх, хамгаалал	43.6	56.4
багш нарын хөгжил	39.8	60.2

Ерөнхий боловсролын сургуулиуд дотуур байрны орчин, үйлчилгээгээ сайжруулах зорилгоор ямар дэмжлэг хүсдэг талаар орон нутгийн ЗДТГ-ын мэргэжилтэн, нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтнүүдээс асуухад ихэвчлэн буюу 59.4 хувь нь тохижилт үйлчилгээ гэдгийг сонгосон байна. Үүнтэй холбоотой буюу дотуур байрны орчин, үйлчилгээний талаар сүүлийн гурван жилд тодорхой үйл ажиллагаа явуулсан гэсэн хариулттай судалгаанд хамрагдагсдын 80.5 хувь нь санал нийлсэн. Харин ямар нэг үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй гэж хариулсны гол шалтгааныг санхүү, хөрөнгө мөнгө (69.2%), ажлын чиг үүрэгт тусгагдаагүй (19.2%) гэдэгтэй холбож тайлбарлажээ.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 28.7 заалт буюу “тэгш хамран сургах чиглэлээр дараах үйл ажиллагааг тусган хэрэгжүүлнэ” гэсэн заалтын хүрээнд:

28.7.1. нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай суралцагчдад боловсрол эзэмшихэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

28.7.2. шаардлагатай хүүхдүүд аюулгүй тээвэр, дотуур байрны үйлчилгээ үзүүлэх;

28.7.3. энэ хуулийн 6.2-д заасан орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

28.7.4. хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих;

28.7.5. сургууль завсардсан сургуулийн насны хүүхдэд боловсрол нөхөн эзэмшүүлж, ерөнхий боловсролын сургуульд үргэлжлүүлэн суралцахад дэмжлэг үзүүлэх” гэсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлдэг гэдэгтэй судалгаанд оролцогчдын 93.2 хувь нь санал нийлсэн байна. Эдгээр заалт, түүнтэй холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд хийж буй ажлуудыг тодруулж асуухад:

- дотуур байрны амьдрах орчин нөхцөл, хоол хүнс, аюулгүй байдлын талаар хяналт шалгалт хийж, зөрчлийг тухай бүр арилгуулах,
- дотуур байрны барилгын асуудлын талаар холбогдох байгууллагуудад санал хүргүүлэх,
- дотуур байрны сурагчдыг эрүүл мэндийн үзлэгт жилд нэг удаа хамруулах гэх мэтчилэн ихэвчлэн материаллаг орчинд анхаарал тавьж ажилладаг талаар оролцогчдын олонх нь хариулсан байна.

Орон нутгийн БШУГ-аас дотуур байрны орчин, үйлчилгээг сайжруулахад дэмжлэг туслалцааг “хааяа” үзүүлдэг гэж судалгаанд хамрагдагсдын 61.7 хувь нь хариулжээ. Малчин эцэг эхчүүдтэй жилд нэг удаа уулзаж ярилцдаг гэж ЗДТГ-ын мэргэжилтнүүдийн тал хувь, “улиралд нэг удаа” гэж 43.6 хувь нь хариулжээ.

Аймаг, орон нутгийн байгууллагуудын дэмжлэгийн талаарх асуултуудад дараах байдлаар хариулсан байна (Хүснэгт 27).

Хүснэгт 26. Аймаг, орон нутгийн байгууллагуудын дэмжлэг (%)

	тийм	хааяа	үгүй
Дотуур байрны орчин, үйлчилгээг сайжруулж, үр дүнд хүргэхэд орон нутгийн удирдлагаас сайн дэмждэг.	54.6	37.6	7.5
Дотуур байрны орчин, үйлчилгээг сайжруулахтай холбоотойгоор мэргэжлийн байгууллагуудаас дэмжлэг тусалцаа авдаг.	34.6	57.1	8.3
Эцэг эх, асран хамгаалагчийн оролцоог сайжруулах, хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулахад оролцдог.	36.1	47.4	16.5
Дотуур байрны эрх зүйн болон үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, дэмжлэг тусалцаа үзүүлэх талаар мэдээлэл хэрэгтэй байдаг.	61.7	34.6	3.8
Дотуур байрны орчин, үйлчилгээг сайжруулахад эцэг эх, олон нийт дэмжиж, оролцдог.	51.9	38.3	9.8
Дотуур байрны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр байрныбагш, хүүхдүүдээс шинэлэг бүтээлч санаачилгууд ирдэг.	39.8	45.1	15
Дотуур байрны үйл ажиллагааг сайжруулах, шинэлэг байдлаар хийх бүтээлч санаачилгуудыг нь дэмждэг.	60.9	34.6	4.5
Сургуулийн дотуур байрны үйл ажиллагаа, төлөвлөгөөний биелэлтийг ярилцаж, сайжруулах талаар хамтран хэлэлцдэг.	39.1	43.6	17.3

Аймаг, орон нутгийн байгууллагуудаас үйл ажиллагааны шинжтэй дэмжлэгийг үзүүлдэг гэдгийг судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүд хэлсэн байна. Тухайлбал, дотуур байрны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр байрны багш, хүүхдүүдээс ирсэн бүтээлч санаа санаачилгуудыг аль болох дэмждэг гэж 60.9 хувь нь хариулжээ.

Дээрх дурдсан чиглэлийн дэмжлэг, тусалцаа үзүүлдэг гэсэн санааг судалгаанд оролцогчид өгсөн ч дотуур байрны эрх зүйн болон үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, дэмжлэг тусалцаа үзүүлэх талаар *мэдээлэл хэрэгтэй* гэдэг санааг тэдний 60 гаруй хувь нь тэмдэглэсэн байна.

Хүснэгт 27. Дотуур байрны барилга, тоног төхөөрөмжийн дэмжлэг

	тийм	хааяа	үгүй
Дотуур байранд шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг орон нутгаас нийлүүлдэг.	39.1	44.4	16.5
Зарим шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэхэд бүх дотуур байранд хүртээмжтэй байж чаддаг.	25.6	36.1	38.3
Шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлдэг ч заримыг нь ашиглахад багш, ажилтны чадвар дутагддаг гэж үздэг.	14.3	37.6	48.1
Дотуур байрны хүүхдийн хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж, эд материал, хэрэгслийг эцэг эхчүүдийн дэмжлэгтэйгээр авдаг.	20.3	41.4	38.3
Дотуур байрны дотоод орчны тохижилт сайн байдаг.	48.1	34.6	17.3
Дотуур байрны гаднах байдал, гадаад орчин цэвэрхэн, сайн тохижсон.	51.1	33.8	15.0

## **Дүгнэлт**

Дотуур байрны менежмент, түншлэл, хамтын ажиллагааны талаар сургуулийн удирдлагаас асуулгын аргаар судалгаа авахад 21 аймаг, сумын 264 дотуур байрны удирдах ажилтан хамрагдсаны 68.9 хувь нь захирал, 31.1 хувь нь сургалтын менежер байна. Мөн ЗДТГ-ын 136 мэргэжилтэн хамрагдсан байна.

Дотуур байрны үйл ажиллагааг төлөвлөх чиглэлээр сургуулийн бодлого тодорхойлохдоо сургуулийн удирдлагууд нь дотуур байрны багш, ажилтнуудтай 7 хоног бүр тогтмол уулздаг байна.

Эцэг эх, асран хамгаалагчдын тодорхой хувь нь дотуур байранд мөнгөн хандив оруулсан гэж судалгаанд хамрагдсан сургуулийн захирал, сургалтын менежерүүд дурджээ.

Дотуур байрны нөхцөл байдал, хүчин чадлаас үл хамааран жилд 20-250 хүүхэд дотуур байранд суух хүсэлт гаргадаг бөгөөд хүсэлт гаргасан хүүхэд бүрийг аль болох боломжоороо хамруулдаг талаар сургуулийн захирал, сургалтын менежерүүд хэлсэн бөгөөд хэрэв багтаагүй, орж чадаагүй тохиолдолд: садан төрлийндөө суудаг, эцэг эх, асран хамгаалагчдад тайлбарладаг, зөвлөмж өгдөг, тэдэнтэй хамтран өөр шийдэл хайдаг гэсэн байна.

Орон нутгийн ЗДТГ, БШУГ-аас дотуур байрны орчин, үйлчилгээний талаарх санал хүсэлтийг хүлээн авч, дотуур байрны орчин, үйлчилгээг сайжруулахад дэмжлэг туслалцааг тодорхой хэмжээгээр үзүүлж, дотуур байранд суудаг хүүхдийн малчин эцэг эх, асран хамгаалагчидтай жилд, улиралд уулзаж ярилцдаг тухай дурдсан байна.

Түүнчлэн дотуур байрны орчин, үйлчилгээний талаар сүүлийн гурван жилд тодорхой үйл ажиллагаа явуулсан гэсэн хариулттай судалгаанд хамрагдагсдын 80.5 хувь нь санал нийлсэн.

Дотуур байрны үйл ажиллагааг төлөвлөх чиглэлээр, сургуулийн бодлого тодорхойлохдоо оролцогч талуудыг татан оролцуулахыг хичээдэг, дотуур байрны орчин нөхцөл, хоол хүнсний талаар сургууль өөрийн үнэлгээ хийдэг, түүний дагуу холбогдох арга хэмжээг авч, сургууль өөрийн нөөц бололцоо, бусад арга замуудыг ашиглан шийдвэрлэдэг талаар дурджээ. Дотуур байрны менежментийг сайжруулах нь юуны өмнө суралцагчдын сурлагын амжилт, хөгжил, төлөвшилд эерэг өөрчлөлт гарна гэж судалгаанд хамрагдсан сургуулийн захирал, сургалтын менежерүүдийн олонх үзсэн байна.

Судалгаанаас үзэхэд дотуур байрны нөхцөл, тохижилт зэрэг асуудалд сургуулийн удирдлага төдийгүй аймаг, орон нутгийн байгууллагууд жигд анхаарч байгаа ч энэ чиглэлээр цаашид үйл ажиллагааг тогтмолжуулах, холбогдох байгууллагын мэргэжилтнүүдийн ажил үүргийг тодорхой болгох шаардлагатай нь харагдлаа.

## **ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ**

### ***Дотуур байрны орчин***

Дотуур байрууд нь хүүхдийн ая тухтай аюулгүй амьдрах орчин нөхцийг бүрдүүлэхэд анхаарал хандуулж байгаа нийтлэг сайн тал байна. Үүнд: зөөлөн эд хэрэглэлийг солих, ариун цэврийн өрөөг тохижуулах, давхар бүрд камер байрлуулах, цахилгааны аюулгүй байдлыг хангах, хүүхдийг цэвэр ус уух боломжийг өөрсдийн нөхцөл байдалд тохируулан бүрдүүлэхийг хичээж байгаа сайн туршлагууд байна. Гэвч хүүхэд асуулгад

хариулсан байдлаас харахад, ойролцоогоор 5 хүүхэд тутмын 3 нь хөнжил гудсаа цэвэрхэн зөөлөн гэж хариулсан бол 2 нь бохир, тухгүй хатуу, солих шаардлагатай гэж үзжээ.

Үүний зэрэгцээ цаашид сайжруулах шаардлагатай асуудлууд нь :

- Дотуур байрны гадна орчинд мод тарьж, зүлэгжүүлсэн байх, эзэмшил газрын 25 хувиас багагүй газрыг мод тарьж зүлэгжүүлсэн байх шаардлагыг судалгаанд хамрагдсан 5 дотуур байр тутмын бараг 2-3 нь хангаагүй;
- Тэргэнцрийн зориулалтын зам, аюулгүй байдлын дохиолол, аянга зайлуулагчтай байх шаардлага тэр бүр хэрэгжихгүй байна.
- Гадаа 00-ын явган суултуурыг шалнаас дээш өндөрлөж суурилуулах, бат бэх аюулгүй материалаар хийгдсэн байх, гадна бие засах газар дотуур байрнаас 30 м зайд байрласан байх, бие засах өрөөнд эвгүй үнэргүй байх, бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан суултууртай байх стандарт шаардлагыг жигд баримталдаг байх
- Бага насны тэрчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан угаалтуур, шүршүүртэй байх стандарт шаардлагыг хэрэгжүүлэх
- Дотуур байранд эмчийн өрөөг стандарт шаардлагын дагуу тохижуулах (анхан шатны тусламж үзүүлэх эм хэрэгсэл, жин, өндөр хэмжигч, чагнуур, даралт хэмжигч, үзлэгийн ор гэх мэт)
- Барилга байгууламжийн хувьд 5 дотуур байр тутмын 1 нь 1980 оноос өмнө ашиглалтад орсон байгаа нь суралцагчдын эсэн мэнд амьдрах эрхийг зөрчих нөхцөл байдлыг бий болгож байна. Мөн 2020 оноос хойш баригдсан 5 дотуур байр тутмын бараг 3 -т нь ариун цэврийн өрөө нь эвгүй үнэртэй байгаад зайлшгүй анхаарлаа хандуулах шаардлагатай байна.
- Дотуур байранд хүүхэд хөгжлийн өрөө байдаг хэдий ч сурах бичиг, гарын авлага хангалтгүй байна. Ойролцоогоор 60 хувь нь уран зохиолын номтой байна.
- Номын сангийн хувьд нийт хүүхдийн 20 хувьд нь нэгэн зэрэг үйлчлэх ширээ, сандал, самбартай байх стандарт тал хувьд нь хангалтгүй байна.

### **Хүүхдийн хөгжил, хамгаалал**

Хүүхдийн эрхийн тухай хуульд зүйлчлэн заасан хүүхдийн хөгжих эрхийн хэрэгжилт ЕБС-ийн дотуур байранд дараах дүр зурагтай байна.

- “Хүүхэд хөгжлийн өрөөн”-д 5 хүүхэд тутмын 1 нь ном уншдаг, 1-2 нь хичээлээ давтдаг, 6 хүүхэд тутмын 1 нь тоглох юм уу, зурагт үздэг гэсэн хариултыг өгсөн нь хангалтгүй байна. Интернэтэд орох, хөгжим сонсох боломж бараг байхгүй байна.
- Номын санд 4 хүүхэд тутмын 1 нь хичээл давтдаг, 5 хүүхэд тутмын 2 нь ном уншдаг гэсэн хариултыг өгсөн ба интернэтэд орж мэдээлэл хайх, хөгжим сонсох боломж боломж бүрдээгүй. Ялангуяа, интернэтээр мэдээлэл хайх боломж нөхцөл алга байна.
- Хичээлээ хүүхдүүд ихэвчлэн амьдардаг тасагтаа л хийдэг аж. Гэтэл амьдардаг тасагт нь ширээ сандал хүүхдийн тоогоор хангалтгүй байна.
- Дотуур байранд хүүхэд хөгжүүлэх төлөвлөгөөг багш нар хийдэг гэж хариулж байгаа ч хүүхдүүд тэр бүр мэдэхгүй байгаа нь хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаа тасралтгүй явагдах нөхцөл сул байна гэж дүгнэхүйц дүр зураг харагдлаа.
- Дотуур байранд хүүхдэд амт чанартай хоолоор үйлчлэх, хоолны амт чанарын талаар хүүхдүүдээс ямар нэгэн байдлаар санал асуулга авдаг, цэвэрлэгээ



үйлчилгээ тогтмол хийдэг, хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт жилд доод тал нь 1-2 удаа хамруулдаг, хүүхдийг өвдсөн үед эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт сайн байгаа сайшаалтай талууд байна.

- Дотуур байрны хүүхдүүдэд зориулсан дугуйлан секцийн тоог дотоод хүний нөөц, боломжоо ашиглан идэвхжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, дотуур байранд хөгжим, урлагийн, харилцааны чадвар олгох сургалт, клубын үйл ажиллагааг удирдан чиглүүлэхэд багш, нийгмийн ажилтан сэтгэл зүйч, жижүүр байрны багш ажиллавал санхүүгийн урамшуулал, хөшүүргийг хэрхэн тусгах боломжтой талаар судлах хэрэгцээтэй байна.
- Дотуур байранд тогтмол дасгал хөдөлгөөн хийж хэвших, бие бялдраа хөгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх хэрэгцээтэй байна.
- Дотуур байрны хоолны чанар стандарт шаардлагыг хангаж байна гэж олонх хүүхэд үзсэн хэдий ч 5 хүүхэд тутмын 1 нь нэр төрөл нь олон биш, хэмжээ нь бага цаддаггүй, мах бага гэсэн тул хоолны хүртээмжийг хэрхэн нэмэгдүүлэх тал дээр судалгаатай хандах шаардлага ажиглагдлаа.
- Дотуур байрны хүүхдүүд хоорондоо, багш, ажилтнуудтай ерөнхийдөө эерэг харилцаатай байгаа ч биенээ цохих, нэр хоч өгөх явдал нийтлэг байдаг байна. Үүнийг бууруулахын тулд харилцаа хандлага ёс суртахууны төлөвшлийн нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй байна.

#### **Багш, ажилтны ажлын байрны чиг үүрэг**

- Дотуур байрны багш нь дээд боловсролтой, багш мэргэжлийн хүмүүс байгаа нь стандарт шаардлагыг хангахуйц байна. Гэвч 5 орчим хувь нь дээд боловсролтой бус, багш мэргэжлийг хүмүүс бус байгааг анхаарах нь зүйтэй юм.
- Дотуур байрны багшийн ажлын зураглалыг ерөнхийд нь авч үзэл, анх хүүхдийг дотуур байранд хүлээж аваад дотуур байрны дүрэм журам танилцуулах, эмчийн үзлэгт хамруулах, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, эцэг эхчүүдтэй хамтарч ажиллах үүргүүдийг гүйцэтгэдэг байна .
- Байрны багш нарын хариултаас үзэхэд, ойролцоогоор 3 багш тутмын 1 нь хүүхэд хөгжлийн төлөвлөгөөг ганцаараа боловсруулдаг, 6 багш тутмын нэг нь сургуулийн удирдлагатай хамтарч боловсруулдаг, хүүхдүүдийн санал хүсэлтэд тулгуурладаг, 8 багш тутмын 1 нь бусад ажилтнуудтай хамтарч боловсруулдаг гэсэн хариултыг өгсөн ч хүүхдүүд бараг хүүхэд хөгжлийн төлөвлөгөөний талаар мэдээлэл байхгүй байлаа. Хүүхэд хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа хүүхдийн оролцоог бий болгох, нүдэнд харагдахуйц газар байрлуулах, танилцуулах, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг явуулдаг байх тал дээр анхаарч ажиллах нь зүйтэй байна.
- Дотуур байрны багш ихэвчлэн бага ангийн хүүхдүүдэд гэрийн даалгавраа хийхэд нь тусалдаг ба дунд, ахлах ангийн хүүхдүүд бие дааж хийх, тусалцаа шаардлагатай үед ах эгч нар болон үе тэнгийнхнээсээ асуух, интернэтээс мэдээлэл хайх замаар тулгарсан асуудлаа шийддэг ажээ. Хүүхдүүд ярилцлагаараа, дотуур байрны багш нар дунд, ахлах ангийнхны хувьд хичээлээ хийх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд анхаардаг гэжээ.
- Сургуулийн бодлого боловсруулах шийдвэр гаргах үйл явцад дотуур байрны багш ажилтнууд оролцдог гэж сургуулийн удирдлагууд үзсэн. Сургуулийн удирдлага дотуур байрны багш ажилтнуудтай тогтмол уулзаж хамтарч ажилладаг талаараа асуулгад дурджээ.

- Дотуур байрны багшаар ажиллахад хамгийн их тулгардаг бэрхшээл нь цалин хөлс, амралтын хоног бага байх, ажлын байрны дагуу үүрэг хариуцлага өндөр байгааг дурдсан байна. Мөн эцэг, эх, удирдлагын зүгээс дарамт шахалт цөөнгүй байдгийг онцолжээ.

#### **Дотуур байрны менежмент, түншлэл хамтын ажиллагаа**

- Дотуур байрны үйл ажиллагааг төлөвлөхөд сургуулийн удирдлага дотуур байрны багш, ажилтнууд, тэрчлэн хүүхдүүдийн татан оролцуулдаг гэснээс харахад, олон талт хамтын ажиллагааг чухалчилдаг дүр зураг харагдаж байна.
- Дотуур байрны менежментийг хэрэгжүүлэхэд, эцэг эх асран хамгаалагчдын оролцоо хамтын ажиллагаа хангалтгүй, хүүхдийн тоо их, дотуур байрны орчин нөхцөл муу, ялангуяа барилга насжилт ихтэй, номын сангүй ариун цэврийн байгууламж хангалтгүй, дэд бүтэц хөгжөөгүй хүний нөөц хангалтгүй, төсөв санхүү хүрэлцээгүй нь тулгамдсан асуудал болж байгааг дурджээ.
- Сургууль дотуур байрны орчин нөхцөл, хоол хүнсний талаар өөрийн үнэлгээг хэрэглэж үр дүнг нь дотуур байрны үйл ажиллагааг сайжруулахад хэрэглэдэг гэсэн хариултыг сургуулийн удирдлага өгсөн байна. Харин материаллаг орчин нөхцөл сайжруулах, хүүхдийн эрх хамгааллын үйл ажиллагаанд, хүүхдийг хөгжүүлэхэд тэр бүр ашигладаггүй дүр зураг харагдлаа. Иймд өөрийн үнэлгээг тухайн чиглэлд хэрэглэдэг байх нь үр дүнтэй юм.
- Хүүхдийг дотуур байранд оруулахад эцэг, эх асран хамгаалагчид сургуулийн удирдлага эсвэл байрны багшид хүсэлт гаргадаг байна.

#### **Орон нутгийн дэмжлэг оролцоо**

- Орон нутгийн ЗДТГ нь сургуулийн дотуур байрны үйл ажиллагаатай танилцаж, байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, үйл ажиллагаанд тусгаж ажилладаг гэсэн хариултыг судалгаанд хамрагдсан засаг захиргааны байгууллагын 5 мэргэжилтэн тутмын 4 нь үзсэн байна.
- Орон нутгийн ЗДТГ нь дотуур байрны асуудлаар захирлуудтай тогтмол уулзаж хэвшсэн байна. Орон нутгийн төсөвт дотуур байрны хөрөнгө оруулалтыг тусгахдаа барилга байгууламж, тохижилтод чиглэдэг аж.
- Орон нутгийн ЗДТГ-т дотуур байртай холбоотой иргэдээс ирж байгаа санал гомдлын ихэнх нь барилга, байгууламж, тохижилт, хоол хүнстэй холбоотой байдаг бол 30 орчим хувь нь хүүхдийн сурч боловсрох эрх, хөгжил, хамгаалалтай холбоотой байдаг гэжээ.
- Орон нутгийн ЗДТГ, БШУГ-аас дотуур байрны орчин, үйлчилгээний талаарх санал хүсэлтийг хүлээн авч, дотуур байрны орчин, үйлчилгээг сайжруулахад дэмжлэг тусалцааг тодорхой хэмжээгээр үзүүлж, дотуур байранд суудаг хүүхдийн малчин эцэг эх, асран хамгаалагчидтай жилд, улиралд уулзаж ярилцдаг тухай дурджээ.

#### **Санал, зөвлөмж**

##### **Үндэсний түвшинд хэрэгжүүлэхүйц санал**

- Дотуур байрны төсөв санхүүд тухайн жилийн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт зардал тусдаггүй нь олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй байдлыг үүсгэж байгаа тул асуудлыг шийдэх нэг арга зам бол дотуур байрны төсвийн төлөвлөгөөг боловсруулахдаа өмнөх оны хэрэгжилтэд суурилагаас

гадна уян хатан байдлаар судалгаатай боловсруулдаг байх нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

- Хичээлийн жилийн явцад дотуур байранд амьдрах хүүхдийн тоо нэмэгдэхэд зардал нэмэгддэггүй нь сургуулийн удирдлагад бэрхшээлтэй нөхцөл үүсдэгийг анхаарч залруулах шаардлагатай.
- Дотуур байранд хүүхдийн эрх хангагдах нөхцөл байдлыг бий болгох, материаллаг болон материаллаг бус орчныг хүүхдэд ээлтэй болгоход дотуур байрны багш нарын үүрэг оролцоог тодорхой болгох
- Сайн туршлага, үйл ажиллагааг дотуур байр бий болгосон байгаа нь ажиглагдсан бөгөөд тэдгээрийг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг орон нутгийн болон үндэсний хэмжээнд зохион байгуулахад бодлого хэрэгжүүлэгч үндэсний болон орон нутгийн байгууллагууд хамтран ажиллах хэрэгтэй байна.
- Сургуулийн гүйцэтгэлийн үр дүнг тооцохдоо дотуур байртай сургуульд хамаарах нэмэлт үзүүлэлтийг тусгах талаар холбогдох байгууллага, мэргэжилтнүүд анхаарал хандуулах шаардлагатай байна.
- Сургуулийн захирлын санаачилга, идэвх зүтгэлээс хамаарч дотуур байрны материаллаг нөхцөл ялгаатай байгаа нь анхаарал татаж байгаа тул ямар ч захирал ажиллаж байгаагаас үл хамааран үйл ажиллагаа доголдохгүй байх нийтлэг стандарт нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, танил тал багатай, өөрт ногдсон ажлаа бүрэн гүйцэтгэхэд анхаарч ажилладаг захиралтай сургуулийн дотуур байр улсаас барьж буй бодлого, орон нутгийн дэмжлэгээр хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлдэг байх нийтлэг нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй байна.
- Дотуур байрны стандартад хөнжил, гудсын зузааны хэмжээг заасан заалт оруулах шаардлагатай байна.
- Дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүдэд зориулсан ном, сурах бичгийг хүүхдийн насны онцлогт нь нийцүүлэн төрөл зүйл, тоо хэмжээгээр нь заасан заалтыг стандартад нэмэлтээр тусгаж өгөх нь чухал байна.
- Дотуур байранд номын санчийн орон тоог бий болгох, номын санч ажиллах тал дээр судалгаатай хандаж шийдвэрлэх хэрэгтэй байна.

### **Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхүйц санал**

- Дотуур байрны байрны шинээр баригдаж буй барилга байгууламжийг чанаржуулах, барилгын явцад нь хөндлөнгийн хяналт тавих, хүлээж авахдаа чанар, стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг үнэлж хүлээж авахад орон нутгийн холбогдох байгууллагатай хамтарч ажиллах хэрэгцээтэй байна.
- Дотуур байртай сургуулиуд орон нутгийн хүүхэд гэр бүлийн газар, цагдаагийн байгууллага, аймгийн спорт хороо зэрэг холбогдох байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллахаа жилийн ажлын төлөвлөгөөндөө тодорхой тусгаж мөрдөж ажиллаж хамтран тайлагнадаг байх нь хүүхэд хөгжил, хамгааллыг сайжруулахад чухал.
- Дотуур байрны багш, ажилтнуудыг чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх үндэсний болон орон нутгийн сургалтад тогтмол хамруулах шаардлагатай. Одоогийн байдлаар сургуулийн түвшинд нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын чиглэлээр зохион байгуулсан сургалтад хамрагдах нь нийтлэг дүр төрхтэй байна.

Ялангуяа жижүүр, тогооч, үйлчлэгч гэх мэт ажилтныг сургалтад идэвхтэй хамруулахад БШУГ санаачилгатай ажиллах хэрэгтэй байна.

- Аймаг, орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагааг дотуур байрны багш, ажилтнуудыг чадавхжуулах, дотуур байрны хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр эрчимжүүлэхээс гадна энэ чиглэлийн ажиллагааг тогтмолжуулах, эргэх холбоотой болгох хэрэгтэй байна.
- БШУГ-т дотуур байр, хүүхдийн хөгжил хамгаалал хариуцсан нийгмийн ажилтан гэсэн мэргэжилтний орон тоо байгаа ч ихэвчлэн тэд давхар ачаалалтай явж байгааг орон нутгийн түвшинд анхаарч ачааллыг тооцох шаардлагатай.
- Сайн туршлага, үйл ажиллагааг сургуулиуд бий болгосон байгаа нь ажиглагдсан бөгөөд тэдгээрийг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг орон нутгийн болон үндэсний хэмжээнд зохион байгуулахад бодлого хэрэгжүүлэгч үндэсний болон орон нутгийн байгууллагууд хамтран ажиллах хэрэгтэй байна.
- Дотуур байрны хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчийг хүүхдийн хөгжил, эрх, аюулгүй байдлыг хангахад татан оролцуулах орон нутгийн онцлог боломжид түшиглэсэн нээлттэй, харилцан биеэ дэмжсэн, оролцоонд тулгуурласан, хүүхдийн хөгжлийг эрхэмлэсэн менежментийг бий болгох хэрэгтэй байна.
- Орон нутгийн ЗДТГ-тай сургуулийн удирдлага нь дотуур байрны материаллаг орчин нөхцөл, хүүхэд хөгжил хамгааллын чиглэлээр жил бүр хамтран ажиллах чиглэлээ тодорхой болгон хоёр талаасаа санал нэгдэж төлөвлөлт, хэрэгжилт, үнэлэх үе шатанд үр дүнгээ тооцон ажиллаж, боловсролын хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлага харагдлаа.
- Дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүдээс авдаг сэтгэл ханамжийн үнэлгээний үр дүнг ашигладаг аргачлалд дотуур байрны багш, тогооч, ажилтныг сургаж, энэ чиглэлийн үйл ажиллагааг сайжруулахад сургуулийн удирдлагыг БШУГ-аас чиглүүлж ажилладаг болох
- Сургуулийн эмчийн дэмжлэгийг дотуур байранд авах, дотуур байрны эрүүл ахуйн нөхцөл, үйлчилгээг сайжруулахад дотуур байрны багш, тогооч, ажилтнууд хамтран ажиллахад сургуулийн удирдлага хэрхэн анхаарч ажиллах тал орон нутаг дэмжлэг үзүүлдэг байх чадавх, тогтолцоотой болох хэрэгцээтэй байна.
- Дотуур байрны эрсдэлийн үнэлгээний үр дүнгийн ашиглалтыг сайжруулахад дэмжлэгийг тодорхой болгох зэрэг болно.

### ***Сургалтын байгууллагын түвшинд хэрэгжүүлэхүйц санал***

- Дотуур байрны гаднах орчин талбайг зүлэгжүүлэх стандарт шаардлагыг хангахад сургуулийн удирдлага анхаарч ажиллах шаардлагатай.
- Дотуур байранд хүүхэд хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан сургуулийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд тусгаж, оролцогч талуудын үүрэг оролцоог нарийн тусгадаг байхаас гадна дотуур байрны суралцагчдад танилцуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлдэг, хэрэгжитийн үр дүнг тайлагнадаг байх тогтолцоог бүрдүүлэх
- Дотуур байранд хүүхдийн эрх хангагдах нөхцөл байдлыг бий болгох, материаллаг болон материаллаг бус орчныг хүүхдэд ээлтэй болгоход дотуур байрны багш нарын үүрэг оролцоог тодорхой болгох
- Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нөхцөл байдлыг сайжруулахдаа хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлж, хүүхэд хөгжлийн үйл ажиллагааг хүүхдийн нас,

сэтгэл зүйн онцлогтой уялдуулан хэрэгжүүлэхдээ төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

- Дотуур байрны ажилтнууд ялангуяа, тогоочийн ажлын ачааллыг зохицуулах, хөдөлмөрийн хуулийг дагаж мөрдөх тал дээр анхаарч ажилалх шаардлагатай байна.
- Дотуур байрны багшийн өрөө нь MNS 6781:2019 стандартын дагуу 10м2-аас багагүй талбайтай байх ба 2008 онд батлагдсан, одоо мөрдөж байгаа дотуур байрны багшийн ажлын байрны тодорхойлолтод заасан дараах материаллаг нөөц хэрэгслээр бүрэн хангах. Үүнд:
  - Компьютер
  - Принтер
  - Ширээ
  - Сандал
  - Шаардлагатай бичиг хэргийн хэрэгсэл
- Дотуур байрны багш, жижүүрийн өрөөнд камерыг хянах дэлгэцийг заавал байрлуулах нь хүүхдийн аюулгүй байдлыг хангахад чухал байна.
- 2023 онд батлагдсан номын санчид тавих нийтлэг шаардлагад туссан чиг үүргийн дагуу дотуур байрны сурагчдыг номын сангийн үйлчилгээнд тэгш, хүртээмжтэй хамрагдах боломж нөхцөлөөр хангах.
- Өсвөр насны охидод зориулсан өрөөг зориулалтаар байгуулахад сургуулийн удирдлага анхаарч ажиллах нь хэрэгцээтэй байна.
- Сургуулийн номын санч нь жил бүрийн хэвлэмэл болон цахим ном, сурах бичиг, бүтээгдэхүүн, хэрэгцээтэй тоног төхөөрөмж, хэрэгслийг худалдан авах, хүчин чадлыг сайжруулах, засварлах зардлын тодорхой хувийг дотуур байрны номын санд төлөвлөдөг байх зохицуулалтыг хийх нь чухал байна.
- Нэг өрөөнд нас насны онцлогоор нь хүүхдүүдийг байрлуулах стандартыг дагаж мөрддөг байхад анхаарч ажиллах нь зүйтэй юм.
- Дунд, ахлах ангийн хүүхдүүдэд хичээл номоо давтах тал дээр сургуулийн удирдлага, дотуур байрны багш нар хамтарч ажиллах хэрэгцээтэй байна.
- Дотуур байранд хүүхдүүд интернэт ашиглах боломжийг төр, хувийн хэвшлийн байгууллагатай хамтарч бүрдүүлэх тал дээр БШУГ, орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран ажиллах нь хүүхдийн сурч хөгжих, тав тухтай байх боломжийг бүрдүүлэх нэг нөхцөл юм.
- Дотуур байрандаа хүүхдүүд хичээлээ давтах тав тухтай орчинг бүрдүүлэхийн тулд дотоод боломжидоо аль болох түшиглэн хичээл давтах өрөө тасалгааг бий болгох, тасгийн ширээ сандлыг сайжруулах, хүүхдийн насны онцлогт тохирсон амьдарч буй хүүхдийн тоогоор сандалтай болгох хэрэгцээтэй байна.
- Дотуур байрны хүүхдүүд сонирхлоороо олон төрлийн секц дугуйланд жигд хамрагдах тал дээр сургуулийн удирдлага зохицуулалт хийж ажилах шаардлагатай байна. Жишээлбэл, дотуур байрны ажилтнуудын нөөц бололцоонд тулгуурлан дугуйан секц ажиллуулах, сургуулийн секц дугуйланд хамруулах, мөн сургуулиас гадуурх дугуйлан секцэд хамрагдахад сургууль, дотуур байрны зүгээс ямар зохицуулалт хийх талаар бодлого, үйл ажиллагааг, боловсруулан, төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Дотуур байранд хүүхдийн өөрийн удирдлагат байгууллын тоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь хүүхдийн хөгжлийг бодитоор дэмжих тал руу нь сайжруулах хэрэгцээтэй нь харагдлаа.

**Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ ерөнхий шаардлага – стандартын зарим заалтыг нэмэх ба хасах санал**

№	Заалтууд	Сайжруулах, хасах санал	Судалгааны үр дүн
<b>Дотуур байрны орчинд тавих шаардлага</b>			
1	5.1.4 Дотуур байрны хашаан дотор болон эзэмшил газарт авто машины зогсоол байгуулахыг хориглоно.	хасах	Судалгаагаар дотуур байрны 75 аас дээш хувь нь зогсоолтой болсон учир хэрэгжих боломжгүй болсон байна.
2	5.1.6 дотуур байрны эзэмшил газарт биеийн тамирын задгай талбай байх бөгөөд гүйлтийн тойрог, гимнастикийн дасгал хөдөлгөөн хийхэд зориулсан турник байрлуулж, гар бөмбөг, сагсан бөмбөг, хөл бөмбөг тоглох боломжийг бүрдүүлнэ.	Хэдийгээр 71 хувь нь хангагдсан гэж үзэж байгаа ч хэмжээ нь өөр өөр, зарим газар турник зарим газар сагсны шийд зоосон байгааг байна гэж тэмдэглэсэн байна. Үүнийг ямар хэмжээтэй ямар хэрэгслээр хийлгэх зэргийг тодруулж зааж өгөх	... 71 хувь нь биеийн тамирын задгай талбайтай түүнд турник, гар бөмбөг, сагсан бөмбөг, хөл бөмбөг тогтлох талбайтай байна гэсэн шаардлагыг биелүүлсэн байна.
<b>5.3 Хүүхэд амьдрах өрөө</b>			
3	5.3.1 амьдрах өрөөний нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээ 4 м <sup>2</sup> -аас багагүй байна.	Нэг өрөөнд нас насны онцлогоор нь хүүхдийг байрлуулах	
<b>5.4 Ариун цэврийн өрөө</b>			
4	5.4.10-Дотуур байрны шилжилтийн насны охидод зориулсан, дараах шаардлагыг хангасан өрөөтэй байна. үүнд : 45.4.10.1-5.4.10.3	Өсвөр насны охидод зориулсан ариун цэврийн өрөөг барилгын зураг төсөлд тусгаж оруулах	Судалгааны үр дүнд охидын өрөөг тусад нь гаргах боломж бага, жижиг хайрцаг ажиллуулах байдлаар шийдэж байна.
<b>5.7 Номын сан</b>			
5	5.7.1 Нийт хүүхдийн 20 хувьд нэг дор үйлчлэх боломж бүхий ширээ, сандал, самбартай, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй номын сантай байна	Номын сангийн өрөөг барилгын зураг төсөлд оруулах	Нийт хүүхдийн 20 хувьд нэг дор үйлчлэх ширээ, сандал, самбартай байх шаардлагыг 48.2 хувь нь биелүүлж байгаа ба номын сангийн 67.2 хувь нь байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй байна.

6	5.7.3 Номын санд хүүхдийг хичээл давтах боломжоор хангаж, сурах бичиг, хичээлийн нэмэлт даалгавар, бусад ном гарын авлагыг байрлуулна.	Дотуур байрны төсөвт номын санг баяжуулах, засварлах зардлыг тусгах Цахим номын сан, интернэт ашиглах зардлыг мөн тусгах	Хэдийгээр 66 хувь нь номын сантай гэж байгаа боловч номны агуулга, хүртээмж, сурах бичиг анги тус бүрээр хангалттай бус байна. Сурах бичгийн хувьд 38.7 хувь нь бүрэн дунд боловсролын сурах бичигтэй, 40.1 хувь нь суурь боловсрол, 40.1 хувь нь бага боловсролын сурах бичигтэй, 49.6 хувь нь гарын авлагатай; 59.1 хувь нь уран зохиолын номтой байна.
5.8 Багшийн өрөө			
7	Багшийн ажиллаж, амрах өрөөг хүүхдийн өрөөнөөс тусад нь 10м 2 -аас доошгүй талбайтай байгуулна.	Багшийн өрөөг байрны зураг төсөлд тусгах, оруулж	69.3 хувь нь 10 м2-аас доошгүй талбайтай өрөөтэй ч зориулалтын бус,
8	Дотуур байрны багшийн өрөө нь MNS 6781:2019 стандартын дагуу 10 м 2-аас багагүй талбайтай байх ба 2008 онд батлагдсан, одоо мөрдөж байгаа дотуур байрны багшийн ажлын байрны тодорхойлолтод заасан дараах материаллаг нөөц хэрэгслээр бүрэн хангах	2023 онд батлагдсан номын санчид тавих нийтлэг шаардлагад туссан чиг үүргийн дагуу дотуур байрны сурагчдыг номын сангийн үйлчилгээнд тэгш, хүртээмжтэй хамрагдах боломж нөхцөлөөр хангах.	69.3 хувь нь компьютер, хяналтын нэгдсэн камертай, 71.5 хувь нь ширээ, сандал амрах буйдантай, 69.3 хувь нь мэргэжлийн номтой байгаа ч нилээд багш нарт өөрсдийн гэсэн өрөөгүй, ажил гүйцэтгэх компьютер принтергүй, мэргэжлийн ном, гарын авлага хангалтгүй байна.
5.9 Эрүүл мэндийн өрөө			
9	5.9.1- 5.9.3 - ... 12м2-аас доошгүй өрөөтэй байна. ...	Эрүүл мэндийн өрөө, чийрэгжүүлэх өрөөг байрны зураг төсөлд тусгаж, оруулж  Цоожтой 1 өрөө байраар байнга ашигладаг болгох  Дотуур байрны төсөвт эмийн зардал тусгах	35.8 хувь нь сурагчдын алжаал тайлж, чийрэгжүүлэх, эмчийн үзлэг хийхэд зориулсан өрөөтэй байгаа ба түүнээс 46.7 хувь нь анхны тусламж үзүүлэх хэрэгсэл бүхий шүүгээтэй, 33.6 хувь нь хүүхдийн биеийн жин үзэх боломжтой, 36.5 хувь нь өндөр хэмжигчтэй, 34.3 хувь нь чагнууртай, 32.8 хувь нь даралт хэмжигчтэй, 32.1 хувь нь үзлэг хийх

			зориулалтын ортой, 41.6 хувь нь сандалтай, 41.6 хувь нь ширээтэй байна. Энэ нь дотуур байранд эмч ирж ажиллах тоног төхөөрөмжтэй өрөө хангалтгүй байгааг харуулж байна.
6.2 сурч боловсрол, хөгжүүлэхэд чиглэсэн үйлчилгээ			
10	6.2.2 хүүхэд гэрийн даалгавраа хийх, өөртөө үйлчлэхэд нь тусалж дэмжинэ.	- дунд, ахлах ангийн хүүхдэд зөвлөх туслах багш ажиллуулах	Бага ангийн сурагчдын гэрийн даалгавар хийхэд дотуур байрны багш тусалдаг, дунд, ахлах ангид ороход нь туслах боломжгүй болдог.
11	6.2.8 Хүүхдэд мэдлэг, чадвар олгоход шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн нь нас, бие, сэтгэхүй, хөгжлийн онцлог тохирсон, хүртээмжтэй, аюулгүй, сонирхол татахуйц байна.	... Хүүхэд хөгжлийн өрөөнд хөгжих боломжтой байх, шатар даам, хүүхэд хөгжүүлэх тоглоом дутагдалтай байгаа тул санхүүгийн асуудлыг тусгаж өгдөх байх.	...хүүхэд хөгжлийн өрөө, номын сан дотуур байранд байлаа ч тэр бүр хүүхдийн хөгжих хэрэгцээг хангаж чадахгүй байна гэж дүгнэхүйц байна.
12	Дотуур байрны үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэх гурвалсан гэрээг байгуулах үр дүнг нь хэлэлцдэг байх.	Гэрээний үр дүнг тогмтол хэлцдэг байх тодорхой хугацаанд үйл ажиллагаагаа дүгнэж ярилцдаг байх, харилцан мэдээлэл өгдөг байх талаар тодорхой тусгах	...олон хэлбэртэй, бүтэц нь өөр, тусгагдаж буй эрх үүргүүд өөр өөр, гэрээний хугацаа тодорхойгүй, гэрээг эхлэх дуусах үед нь хэрэгжсэн болон ямар заалтууд хэрэгжээгүй талаар харилцан ярилцдаггүй гэх зэрэг сул талууд байна.



## ХАВСРАЛТ -1

### ЕБС-ийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS6781:2019 -ын хэрэгжилт аймаг сумаар

5.1 Гадна орчны	Аймгийн төв	Сум
5.1. Дотуур байр сургуулиас 150 метр хүртэлх зайд байрласан.	71.43	88.07
5.1. Сургууль дотроо хамт байрласан.	39.29	28.44
5.1. Эзэмшил газрын 25 хувиас багагүй газрыг мод тарьж зүлэгжүүлсэн.	71.43	51.38
5.1. Эмнэлэг, цагдаа, онцгой байдлын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нэвтрэх болон ачаа ачих буулгах боломжтой.	89.29	93.58
5.1. Дотуур байрны хашаан дотор болон эзэмшил газарт автомашины зогсоолтой.	71.43	49.54
5.1. Биеийн тамирын задгай талбай, турник, гар, сагс, хөл бөмбөг тоглох талбайтай.	75.00	69.72
5.1. Дотуур байрны өрөө бүр цонхтой, бүх өрөөний цонх хамгаалалттай эсэх	85.71	67.89
5.2 Барилга,Байгууламж	Аймгийн төв	Сум
5.2. Төрийн албан ёсны хэлээр бичсэн хаягтай байна.	82.14	78.90
5.2. Тэргэнцрийн зориулалтын замтай.	50.00	43.12
5.2. Аюулгүй байдлын дохиоллын системтэй.	39.29	33.94
5.2. Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй.	96.43	91.74
5.2. Агааржуулалтын системтэй.	82.14	57.80
5.2. Аянга зайлуулагчтай.	50.00	45.87
5.2. Төвийн цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт холбогдсон байдал (220в уу 380в уу)	96.43	96.33
5.2. Хүүхдийн амьдрах өрөөнд цахилгааны разеткатай, ажиллагаатай эсэх (разетка хамгаалалттай)	89.29	80.73
5.2. Хүүхдийн өрөө нь цахилгааны холболтын аюулгүй байдал (цахилгааны утас ил биш, далдлагдсаныг хангасан эсэх)	92.86	82.57
5.2. Дотуур байрны коридор нь цахилгааны холболтын аюулгүй байдал (цахилгааны утас ил биш, далдлагдсан)	92.86	85.32
5.2. Дотуур байрны гал тогоо нь цахилгааны холболтын аюулгүй байдал (цахилгааны утас ил биш, далдлагдсан)	89.29	87.16
5.2. Төвийн дулааны эх үүсвэр бүхий халаалтын шугамтай.	92.86	84.40
5.2. Бие даасан уурын зуухтай.	21.43	24.77
5.2. Ус цэвэршүүлэгчтэй	82.14	83.49
5.2. Буцалсан устай	85.71	90.83
2.2. Дотуур байрны өрөө коридорын байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг хангалттай эсэх	100.00	88.07

*Дотуур байрны нөхцөл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа*

<b>5.3 Хүүхэд амьдрах өрөө</b>	<b>Аймгийн төв</b>	<b>Сум</b>
5.3. Нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээ 4м2 -аас багагүй байна.	75.00	71.56
5.3. Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн тустай өрөөтэй, Нэг өрөөнд 8-аас ихгүй хүүхэд амьдардаг.	92.86	94.50
5.3. Хүүхдийн тоогоор ортой	96.43	82.57
5.3. Гудас нь цэвэрхэн	100.00	85.32
5.3. Гудас нь зузаан	75.00	66.97
5.3. Хөнжил нь цэвэрхэн	100.00	88.07
5.3. Хөнжил нь дулаан	89.29	83.49
5.3. 22 С-ын хэмээс доошгүй дулаантай, салхивчтай	78.57	80.73
5.3. хогийн савтай	96.43	93.58
5.3. Ширээтэй	100.00	93.58
5.3. Сандалтай	100.00	90.83
5.3. Өрөөний тааз цагаан, хана цайвар өнгөтэй.	92.86	91.74
<b>5.4 Ариун цэврийн өрөө</b>	<b>Аймгийн төв</b>	<b>Сум</b>
5.4. Агааржуулалтын системтэй, цонхны салхивч нь дээд талдаа байрласан.	82.14	72.38
5.4. Цахилгааны холболт далд байна.	85.71	84.76
5.4. Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн 00 өрөө охид, хөвгүүдээр ялгасан таних тэмдэгтэй	85.71	80.00
5.4. Угаалга, хатаалгын өрөөтэй.	67.86	60.00
5.4. 50 хүүхэд тутамд 1 угаалгын машины тоо, индүүний тоо, индүүний тавцангийн тоо	78.57	64.76
5.4. Халуун усанд орох өрөөг тусдаа, охид, хөвгүүдээр ялгасан таних тэмдэгтэй.	60.71	61.90
5.4. 30 хүүхэд тутамд 1 угаалтуурын тоо	85.71	74.29
5.4. 20 хүүхэд тутамд 1 шүршүүрийн тоо	60.71	50.48
5.4. Гар угаах угаалтуур тогтмол савантай.	46.43	50.48
5.4. Гар хатаагч, таглаатай хогийн савтай.	57.14	48.57
5.4. Шал халтирдаггүй зориулалтын материалаар хийгдсэн.	64.29	58.10
5.4. Бага насны хүүхдэд зориулсан шүршүүртэй.	21.43	26.67
5.4. Бага насны хүүхдэд зориулсан суултууртай	32.14	40.95
5.4. Бага насны хүүхдэд зориулсан угаалтууртай,	25.00	49.52
5.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан шүршүүртэй.	3.57	10.48
5.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан суултууртай	14.29	20.00
5.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан угаалтууртай	10.71	18.10
5.4. Шилжилтийн насны охидод зориулсан дотуур хувцсаа угаах, солиход зориулсан, хаалгаар тусгаарласан угаалгын хэсэг байна.	32.14	22.86
5.4. Ариун цэврийн хэрэглэл, бусад хог хаягдлыг хаях тагтай хогийн савтай байна.	82.14	69.52

*Дотуур байрны нөхцөл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа*

<b>5.5 Бие засах газар</b>	<b>Аймгийн төв</b>	<b>Сум</b>
5.5. Суултуурууд тусгаарлагчтай.	96.43	73.15
5.5. 25 эрэгтэй хүүхэд тутамд нэг суултуур, нэг шээлтүүртэй.	78.57	62.04
5.5. 20 эмэгтэй хүүхэд тутамд нэг суултууртай.	82.14	66.67
5.5. Дотор 00-ын явган суултуурыг шалнаас дээш өндөрлөж суурилуулсан.	67.86	56.48
5.5. Чийг болон эвгүй үнэр гардаг уу?	50.00	42.59
5.5. Гадаа 00-ын явган суултуурыг шалнаас дээш өндөрлөж суурилуулсан.	14.29	27.78
5.5. Гадна жорлон нь бат бэх, аюулгүй байдлыг хангасан материалаар хийгдсэн	14.29	50.93
5.5. Суултуурын татуурга, бариул нь бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиромжтой.	28.57	38.89
5.5. Гадна бие засах газар нь дотуур байрын гарах хаалганаас 30 метр хүртэл зайнд байрлана.	21.43	57.41
5.5. Гадна бие засах газар хүрэх зам гэрэлтүүлэгтэй байна.	17.86	57.41
5.5. Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан суултууртай байна.	10.71	24.07
<b>5.6 Хүүхэд хөгжлийн өрөө</b>	<b>Аймгийн төв</b>	<b>Сум</b>
5.6. Өрөөний талбайн хэмжээ 30м -ээс доошгүй байна.	84.62	80.77
5.6. Хөгжим	30.77	40.38
5.6. Зурагт	69.23	78.85
5.6. Компьютер	50.00	32.69
5.6. Интернет холболт	50.00	22.12
5.6. Сэтгэхүй хөгжүүлэх тоглоом	57.69	71.15
5.6. Буйдан	57.69	48.08
5.6. Номын булан	65.38	70.19
<b>5.7 Номын сан</b>	<b>Аймгийн төв</b>	<b>Сум</b>
5.7. Нийт хүүхдийн 20 хувьд нэг дор үйлчлэх ширээ, сандал, самбартай.]	85.00	59.04
5.7. Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй.	100.00	86.75
5.7. 1 хүүхдэд ногдох тайлбай 2.4 м2 -аас доошгүй байна.	90.00	65.06
5.7. Бүрэн дунд боловсролын сурах бичигтэй	70.00	46.99
5.7. Суурь боловсролын сурах бичигтэй	60.00	51.81
5.7. Бага боловсролын сурах бичигтэй	40.00	56.63
5.7. Гарын авлага	75.00	63.86
5.7. Уран зохиолын гадаад, дотоодын ном зохиол	80.00	78.31
<b>5.8 Багшийн өрөө</b>	<b>Аймгийн төв</b>	<b>Сум</b>

*Дотуур байрны нөхцөл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа*

5.8. 10 м2-аас доошгүй талбайтай.	85.19	74.23
5.8. Компьютер, хяналтын нэгдсэн камер	66.67	79.38
5.8. Ширээ сандал, Амрах буйдан	88.89	76.29
5.8. Мэргэжлийн ном, гарын авлага	77.78	76.29
<b>5.9 Эрүүл мэндийн өрөө</b>	<b>Аймгийн төв</b>	<b>Сум</b>
5.9. Алжаал тайлж, чийрэгжүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эмчийн үзлэг хийхэд зориулсан 12м2-аас доошгүй талбайтай өрөөтэй байна.	73.33	59.38
5.9. Анхан шатны яаралтай тусламж үзүүлэх, эм эмнэлгийн хэрэгсэл бүхий шүүгээтэй	93.33	78.13
5.9. Жин	66.67	56.25
5.9. Өндөр хэмжигч	73.33	60.94
5.9. Чагнуур	66.67	57.81
5.9. Даралт хэмжигч	60.00	56.25
5.9. Үзлэг хийх зориулалтын ор	73.33	51.56
5.9. Сандал	80.00	70.31
5.9. Ширээ	80.00	70.31
<b>5.10 Гал.тогоо</b>	<b>Аймгийн төв</b>	<b>Сум</b>
5.10. Шал, хана плитатай	96.00	85.71
5.10. Тааз ус нэвтэрдэггүй, бат бөх, тэгш гөлгөр гадаргуутай	84.00	76.19
5.10. Гал унтраах хэрэгслийг нүдэнд ил харагдах газар байрлуулсан.	80.00	64.76
5.10. Хүнсний зориулалтын материалаар хийсэн, таглаатай ундны ус зөөх хадгалах савтай байна.	72.00	84.76
5.10. Аяга, таваг, хоолны сав нь шаазан, шилэн материалтай	72.00	69.52
5.10. Хооллох хэрэгслийг угаах, хатаах, ариутгах машинтай	88.00	79.05
<b>Аюулгүй байдал- орчин</b>	<b>Аймгийн төв</b>	<b>Сум</b>
1.11. Дотуур байрны гадна талд камертай	100.00	89.47
1.11. Давхар бүрд камертай	100.00	94.74
1.11. Хүүхдийн амьдардаг өрөөнөөс бусад өрөөнүүд камертай	77.78	69.47

## ХАВСРАЛТ -2

### Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ ерөнхий шаардлага стандартын статистик үзүүлэлтүүд

Дотуур байрны орчин, үйлчилгээ ерөнхий шаардлага стандартын дагуу:

- Дотуур байрны орчин,
- Барилга, байгууламж,
- Хүүхэд амьдрах өрөө
- Ариун цэврийн өрөө
- Бие засах газар
- Хүүхэд хөгжлийн өрөө
- Номын сан
- Багшийн өрөө
- Эрүүл мэндийн өрөө
- Гал тогоо
- Аюулгүй байдал гэсэн бүлгүүдээр харилцан хамаарлыг авч үзлээ.

Орчин болон бусад үзүүлэлтийн хамраарал

Орчин	Сургуулиас 150 метр хүртэлх зайд	Сургууль дотроо хамт	Эзэмшил газрын 25 хувиас багагүй газрыг модтой.	Эмнэлэг, цагдаа, онцгой байдлын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл нэвтрэх болон ачаа ачих	Хашаан дотор болон эзэмшил газарт автомашины зогсоолтой.	Биеийн тамирын задгай талбай,	Дотуур байрны өрөө бүр цонхтой, бүх өрөөний цонх хамгаалалттай эсэх
Pearson Correlation	.225**	.275**	.486**	.362**	.535**	.607**	.507**
Sig. (2-tailed)	0.008	0.001	0.000	0.000	0.000	0.000	0.000
N	137	137	137	137	137	137	137

Барилга байгууламж болон бусад үзүүлэлтийн хамаарал

Барилга, байгууламж	Pearson Correlation	Sig. (2-tailed)	N
Төрийн албан ёсны хэлээр бичсэн хаягтай	.377**	0	137
Тэргэнцрийн зориулалтын замтай	.404**	0	137
Аюулгүй байдлын дохиоллын системтэй	.545**	0	137
Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй	.295**	0	137
Агааржуулалтын системтэй	.634**	0	137
Аянга зайлуулагчтай	.469**	0	137
Төвийн цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт холбогдсон байдал (220в уу 380в уу)	.227**	0.008	137
Хүүхдийн амьдрах өрөөнд цахилгааны разеткатай, ажиллагаатай эсэх (разетка хамгаалалттай)	.486**	0	137

*Дотуур байрны нөхцөл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа*

Хүүхдийн өрөө нь цахилгааны холболтын аюулгүй байдал (цахилгааны утас ил биш, далдлагдсаныг хангасан эсэх)	.601**	0	137
Дотуур байрны коридор нь цахилгааны холболтын аюулгүй байдал (цахилгааны утас ил биш, далдлагдсан)	.555**	0	137

*Цахилгаан холболтын аюулгүй байдал*

Барилга, байгууламж	Pearson Correlation	Sig. (2-tailed)	N
Дотуур байрны гал тогоо нь цахилгааны холболтын аюулгүй байдал (цахилгааны утас ил биш, далдлагдсан)	.476**	0	137
Төвийн дулааны эх үүсвэр бүхий халаалтын шугамтай.	.191*	0.025	137
Бие даасан уурын зуухтай.	.219*	0.01	137
Ус цэвэршүүлэгчтэй	.278**	0.001	137
Буцалсан устай	.216*	0.011	137
Дотуур байрны өрөө коридорын байгалийн болон зохиомол гэрэлтүүлэг хангалттай эсэх	.524**	0	137

*Хүүхэд амьдрах өрөө ба хамаарал*

Хүүхэд амьдрах өрөө	Pearson Correlation	Sig. (2-tailed)	N
Нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээ 4м2 -аас багагүй байна.	.393**	0.000	137
Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн тустай өрөөтэй, Нэг өрөөнд 8-аас ихгүй хүүхэд амьдардаг.	.234**	0.006	137
Хүүхдийн тоогоор ортой	.524**	0.000	137
Гудас нь цэвэрхэн	.623**	0.000	137
Гудас нь зузаан	.588**	0.000	137
Хөнжил нь цэвэрхэн	.581**	0.000	137
Хөнжил нь дулаан	.578**	0.000	137
22 С-ын хэмээс доошгүй дулаантай, салхивчтай	.329**	0.000	137
Хогийн савтай	.266**	0.002	137
Ширээтэй	.391**	0.000	137
Сандалтай	.366**	0.000	137
Өрөөний тааз цагаан, хана цайвар өнгөтэй.	.401**	0.000	137

*Ариун цэврийн өрөө ба хамаарал*

Ариун цэврийн өрөө	Pearson Correlation	Sig. (2-tailed)	N
Агааржуулалтын системтэй, цонхны салхивч нь дээд талдаа байрласан.	.530**	0.000	137
Цахилгааны холболт далд байна.	.449**	0.000	137
Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн 00 өрөө охид, хөвгүүдээр ялгасан таних тэмдэгтэй	.614**	0.000	137
Угаалга, хатаалгын өрөөтэй.	.507**	0.000	137
50 хүүхэд тутамд 1 угаалгын машины тоо, индүүний тоо, индүүний тавцангийн тоо	.453**	0.000	137
Халуун усанд орох өрөөг тусдаа, охид, хөвгүүдээр ялгасан таних тэмдэгтэй.	.663**	0.000	137
30 хүүхэд тутамд 1 угаалтуурын тоо	.638**	0.000	137
20 хүүхэд тутамд 1 шүршүүрийн тоо	.655**	0.000	137
Гар угаах угаалтуур тогтмол савантай.	.529**	0.000	137
Гар хатаагч, таглаатай хогийн савтай.	.499**	0.000	137
Шал хальтардаггүй зориулалтын материалаар хийгдсэн.	.454**	0.000	137
Бага насны хүүхдэд зориулсан шүршүүртэй.	.615**	0.000	137
Бага насны хүүхдэд зориулсан суултууртай	.635**	0.000	137
Бага насны хүүхдэд зориулсан угаалтууртай,	.620**	0.000	137
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан шүршүүртэй.	.367**	0.000	137
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан суултууртай	.478**	0.000	137
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан угаалтууртай	.500**	0.000	137
Шилжилтийн насны охидод зориулсан дотуур хувцсаа угаах, солиход зориулсан, хаалгаар тусгаарласан угаалгын хэсэг байна.	.561**	0.000	137
Ариун цэврийн хэрэглэл, бусад хог хаягдлыг хаях тагтай хогийн савтай байна.	.555**	0.000	137

*Бие засах өрөө ба хамаарал*

Бие засах өрөө	Pearson Correlation	Sig. (2-tailed)	N
Суултуурууд тусгаарлагчтай.	.548**	0.000	137
25 эрэгтэй хүүхэд тутамд нэг суултуур, нэг шээлтүүртэй.	.553**	0.000	137
20 эмэгтэй хүүхэд тутамд нэг суултууртай.	.609**	0.000	137
Дотор 00-ын явган суултуурыг шалнаас дээш өндөрлөж суурилуулсан.	.472**	0.000	137
Чийг болон эвгүй үнэр гардаг уу?	0.134	0.119	137
Гадаа 00-ын явган суултуурыг шалнаас дээш өндөрлөж суурилуулсан.	.527**	0.000	137
Гадна жорлон нь бат бэх, аюулгүй байдлыг хангасан материалаар хийгдсэн	.426**	0.000	137
Суултуурын татуурга, бариул нь бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиромжтой.	.533**	0.000	137
Гадна бие засах газар нь дотуур байрны гарах хаалганаас 30 метр хүртэл зайнд байрлана.	.576**	0.000	137
Гадна бие засах газар хүрэх зам гэрэлтүүлэгтэй байна.	.363**	0.000	137
Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан суултууртай байна.	.497**	0.000	137

*Хүүхэд хөгжлийн өрөө ба хамаарал*

Хүүхэд хөгжлийн өрөө	Pearson Correlation	Sig. (2-tailed)	N
Өрөөний талбайн хэмжээ 30м -ээс доошгүй байна.	.466**	0.000	137
Хөгжим	.660**	0.000	137
Зурагт	.521**	0.000	137
Компьютер	.604**	0.000	137

*Дотуур байрны нөхцөл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа*

Интернэт холболт	.535**	0.000	137
Сэтгэхүй хөгжүүлэх тоглоом	.688**	0.000	137
Буйдан	.590**	0.000	137
Номын булан	.582**	0.000	137
Хүүхэд хөгжлийн өрөө	1		137

*Номын сан ба хамаарал*

Номын сан	Pearson Correlation	Sig. (2-tailed)	N
Нийт хүүхдийн 20 хувьд нэг дор үйлчлэх ширээ, сандал, самбартай.]	.660**	0.000	137
Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй.	.808**	0.000	137
1 хүүхдэд ногдох тайлбай 2.4 м2 -аас доошгүй байна.	.755**	0.000	137
Бүрэн дунд боловсролын сурах бичигтэй	.774**	0.000	137
Суурь боловсролын сурах бичигтэй	.810**	0.000	137
Бага боловсролын сурах бичигтэй	.789**	0.000	137
Гарын авлага	.782**	0.000	137
Уран зохиолын гадаад, дотоодын ном зохиол	.749**	0.000	137
Номын сан	1		137

*Багшийн өрөө ба хамаарал*

Багшийн өрөө	10 м2-аас доошгүй талбайтай.	Компьютер, хяналтын нэгдсэн камер	Ширээ сандал, Амрах буйдан	Мэргэжлийн ном, гарын авлага	Багшийн өрөө
Pearson Correlation	.760**	.649**	.734**	.649**	1
Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000	0.000	
N	137	137	137	137	137

*Эрүүл мэндийн өрөө ба хамаарал*

Эрүүл мэндийн өрөө	Pearson Correlation	Sig. (2-tailed)	N
Алжаал тайлж, чийрэгжүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, эмчийн үзлэг хийхэд зориулсан 12м2-аас доошгүй талбайтай өрөөтэй байна.	.756**	0.000	137
Анхан шатны яаралтай тусламж үзүүлэх, эм эмнэлгийн хэрэгсэл бүхий шүүгээтэй	.792**	0.000	137
Жин	.867**	0.000	137
Өндөр хэмжигч	.845**	0.000	137
Чагнуур	.919**	0.000	137
Даралт хэмжигч	.874**	0.000	137
Үзлэг хийх зориулалтын ор	.889**	0.000	137
Сандал	.919**	0.000	137
Ширээ	.919**	0.000	137
Эрүүл мэндийн өрөө	1		137

*Гал тогоо ба хамаарал*

Гал тогоо	Шал, хана плитатай	Тааз ус нэвтэрдэггүй, бат бөх, тэгш гөлгөр гадаргуутай	Гал унтраах хэрэгслийг нүдэнд ил харагдах газар байрлуулсан.	Хүнсний зориулалтын материалаар хийсэн, таглаатай ундны ус зөөх хадгалах савтай	Аяга, таваг, хоолны сав нь шаазан, шилэн материалтай	Хооллох хэрэгслийг угаах, хатаах, ариутгах машинтай
-----------	--------------------	--	--	---	--	---



Дотуур байрны нөхцөл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа

Pearson Correlation	.592**	.688**	.587**	.670**	.546**	.553**
Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000
N	137	137	137	137	137	137

Аюулгүй байдал ба хамаарал

Аюулгүй байдал	Дотуур байрны гадна талд камертай	Давхар бүрд камертай	Хүүхдийн амьдардаг өрөөнөөс бусад өрөөнүүд камертай
Pearson Correlation	.786**	.828**	.794**
Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000

Үзүүлэлтүүдийн хамаарал

Нийт. үнэлгээ	Гадна орчин	Барилга байгууламж	Хүүхэд амьдрах өрөө	Ариун цэврийн өрөө	Бие засах өрөө	Хүүхэд хөгжлийн өрөө	Номын сан	Багшийн өрөө	Эрүүл мэндийн өрөө	Аюулгүй байдал
Pearson Correlation	.467**	.692**	.460**	.792**	.508**	.611**	.667**	.511**	.519**	.304**
Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000
N	137	137	137	137	137	137	137	137	137	137

Стандарт үзүүлэлтүүдийн хоорондын хамаарал

		Барилга, байгууламж	Хүүхэд амьдрах өрөө	Ариун цэврийн өрөө	БЗӨрөө үнэлгээ	Хүүхэд хөгжлийн өрөө	Номын сан	Багшийн өрөө	Эрүүл мэндийн өрөө	Гал тогоо	Аюулгүй байдал	Нийт. үнэлгээ
Судалгааг биечлэн болон онлайнгаар	Pearson Correlation			.195*	.214*		.266**	.256**	.190*	.176*		.265**
	Sig. (2-tailed)			0.023	0.012		0.002	0.003	0.026	0.040		0.002
	N			137	137		137	137	137	137		137
Гадаад орчин. үнэлгээ	Pearson Correlation	.403*	.380**	.316**		.271**		.280**			.176*	.467**

Дотуур байрны нөхцөл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа

	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000		0.001		0.001			0.039	0.000
	N	137	137	137		137		137			137	137
Барилга, байгууламж	Pearson Correlation	1	.389**	.529**	.291**	.274**	.328**	.328**	.219*	.291**	.240**	.692**
	Sig. (2-tailed)		0.000	0.000	0.001	0.001	0.000	0.000	0.010	0.001	0.005	0.000
	N		137	137	137	137	137	137	137	137	137	137
Хүүхэд амьдрах өрөө	Pearson Correlation		1	.367**	.287**	.282**		.217*				.460**
	Sig. (2-tailed)			0.000	0.001	0.001		0.011				0.000
	N			137	137	137		137				137
Ариун цэврийн өрөө	Pearson Correlation			1	.460**	.428**	.432**	.340**		.222**		.792**
	Sig. (2-tailed)				0.000	0.000	0.000	0.000		0.009		0.000
	N				137	137	137	137		137		137
Бие засах газар	Pearson Correlation				1	.222**				.185*		.508**
	Sig. (2-tailed)					0.009				0.030		0.000
	N					137				137		137
Хүүхэд хөгжлийн өрөө	Pearson Correlation					1	.438**	.305**	.223**		.183*	.611**
	Sig. (2-tailed)						0.000	0.000	0.009		0.032	0.000

Дотуур байрны нөхцөл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа

	N						137	137	137		137	137
Номын сан	Pearson Correlation						1	.375**	.350**	.287**	.235**	.667**
	Sig. (2-tailed)							0.000	0.000	0.001	0.006	0.000
	N							137	137	137	137	137
Багшийн ерөө	Pearson Correlation							1	.187*	.238**	.377**	.511**
	Sig. (2-tailed)								0.029	0.005	0.000	0.000
	N								137	137	137	137
Эрүүл мэндийн ерөө	Pearson Correlation								1	.317**		.519**
	Sig. (2-tailed)									0.000		0.000
	N									137		137
Гал тогоо	Pearson Correlation									1		.435**
	Sig. (2-tailed)											0.000
	N											137
Аюулгүй орчин	Pearson Correlation										1	.304**
	Sig. (2-tailed)											0.000
	N											137